



## **“ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ” ХХК**

**ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН НУТАГ ДАХЬ  
ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛ, ОЛБОРЛОЛТЫН ТӨСӨЛ,  
“ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ” ХХК-НИЙ ХХІ ТАЛБАЙН  
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН НУТАГ ДАХЬ ГАЗРЫН ТОСНЫ  
ХАЙГУУЛ, ОЛБОРЛОЛТЫН ТӨСӨЛ,  
“ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ” ХХК-НИЙ ХХІ ТАЛБАЙ**

**2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**/Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар – 906 /2023.12.12/**

**/Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар – 2075385/**

**ХЯНАСАН:**

БОУАӨЯ-ны ХБОБНУГ-ын ахлах шинжээч: \_\_\_\_\_ /...../

**БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАГНАСАН:**

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний

ХАБЭАБО хэлтсийн менежер: \_\_\_\_\_ /Б.Сүхбат/

ХАБЭАБО хэлтсийн байгаль орчны мэргэжилтэн: \_\_\_\_\_ /Э.Болорчимэг/

## АГУУЛГА

1. 2025 ОНЫ ОЛБОРЛОЛТ, ЭКСПОРТЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	
1.1. Төслийн товч танилцуулга. . . . .	.1
1.2. 2025 оны газрын тос олборлолт, экспортын мэдээ. . . . .	.5
1.3. XXI талбай дахь тос цуглуулах шугам хоолой ба олборлолтын нэгдсэн ил Байгууламж. . . . .	.6
1.4. Ус ашиглалт. . . . .	.10
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	
2.1. Сөрөг нөлөөллийн бууруулах төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд. . . . .	.11
2.2. Саармагжуулж хатууруулан техникийн нөхөн сэргээлт хийсэн газруудаас дээж авч лабораторийн шинжилгээ хийлгэх ажил. . . . .	.12
2.3. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажил. . . . .	.20
2.4. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөр. . . . .	.22
2.4.1. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээний мод тариалалт. . . . .	.22
2.4.2. “Тэрбум мод” хөтөлбөрийн орон нутгийн хамтын ажиллагаа. . . . .	.24
2.5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нэмэлт ажлууд. . . . .	.25
2.5.1. Хөрсөнд тос нэвчихээс хамгаалах дэвсгэр дэвсэх. . . . .	.26
2.5.2. Ашиглалтаас гарсан замыг хагалах, тэмдэгжүүлэх. . . . .	.26
2.5.3. Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж. . . . .	.28
2.5.4. Байгаль хамгаалах чиглэлээр хийсэн сургалт, мэдээллийн ажил . . . . .	.31
3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	
3.1. Өрмийн шаврын хаягдлын сангийн техникийн нөхөн сэргээлтийн ажлын тайлан. . . . .	.33
3.2. Үйлдвэрлэлийн шингэн хаягдлын сангийн техникийн нөхөн сэргээлт. . . . .	.35
3.3. Биологийн нөхөн сэргээлтийн нөхөн сэргээлт. . . . .	.36
4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	
4.1. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний 2025 оны хэрэгжилт. . . . .	.38
5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ. . . . .	.45
6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭТ. . . . .	.45
7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	
7.1. Хүчтэй цасан болон шороог шуурга. . . . .	.48

7.2. Объект болон хээрийн түймэр.	.49
7.3. Ган болон зуд .	.51
7.4. Зам тээврийн осол .	.51
7.5. Халдварт өвчин.	.52
7.6. Химийн бодисын асгаралт .	.53
<b>8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b>	
8.1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .	.56
8.2. Үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдал.	.56
8.3. Аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад шилжүүлсэн .	.58
<b>9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ</b>	
9.1. Агаар орчны хяналт шинжилгээ .	.62
9.2. Усан орчны хяналт шинжилгээ .	.70
9.3. Хөрсний хяналт шинжилгээ .	.85
9.4. Ургамлын нөмрөгийн хяналт шинжилгээ .	.98
<b>10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b>	
10.1. ХАБЭАБО хэлтсийн бүтэц бүрэлдэхүүн.	.172
10.2. Хамтран ажилласан мэргэжлийн байгууллагууд.	.172
10.3. Байгаль орчны чиглэлээр нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлууд.	.173
10.4. Орон нутгийн удирдлагын санал, зөвлөмжийн хүрээнд хийгдсэн ажлууд.	.173
<b>11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.</b>	
	.175
<b>12. БАЙГАЛЬ ОРЧИН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮГНЭЛТ, ТӨСӨВ</b>	
<b>13. ХАВСРАЛТ</b>	

## **1. 2025 ОНЫ ОЛБОРЛОЛТ, ЭКСПОРТЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

### **1.1. Төслийн товч танилцуулга**

Төсөл хэрэгжиж буй XXI талбай нь Монгол орны газарзүйн мужлалын хувьд Дорнод Монголын тал, хээрийн бүсэд хамаардаг бөгөөд харин засаг захиргааны өнөөгийн хуваарийн дагуу Дорнод аймгийн Халхгол сумын нутаг дэвсгэрт оршдог. XXI талбайн үйлдвэрлэлийн бааз нь Халхгол сумын төвөөс баруун зүгт 120 км зайд, Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос зүүн урд зүгт 210 км зайд оршдог.

Хөрөнгө оруулагч БНХАУ-ын газрын тос, байгалийн хий олборлолтын корпораци нь 2005 оны 8 дугаар сард “Соко Интернешил” ХХК-ийн хувьцааг худалдан авч Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (БХГ)–ний эрх үүргийг шилжүүлэн авснаар “Петрочайна Дачин Тамсаг (Монгол)” ХХК-ийг анх байгуулсан.


Газрын тос олборлолтын БХГ нь Хөрөнгө оруулагч болон Монгол Улсын Засгийн газрын хооронд байгуулагдсан ба Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн 1996 оны 8 тоот зөвлөмж, Монгол Улсын Засгийн газрын 1996.08.09-ний өдрийн 183 дугаар тогтоолоор зөвшөөрөгдөж, Монгол Улсын Засгийн газрын 1996.08.09-ний өдрийн 144-р тогтоолоор тус тус баталгаажсан.

Төсөл хэрэгжүүлэгч нь БХГ-ний дагуу Монгол Улсын үйлдвэр худалдааны яамны 2006.04.13-ны өдрийн 47 тоот “тусгай зөвшөөрөл” болон Уул уурхайн яамны сайдын 2012 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 72 дугаар тушаалаар олгосон “Аж ахуйн үйл ажиллагааны” 11 тоот зөвшөөрлөөр Дорнод аймгийн Тамсагийн сав газарт газрын тос олборлох үйл ажиллагаа явуулж байна.

БХГ-т талбайд XIX, XXI, XXII талбай тус тус хамаарч байсан бөгөөд XIX талбайн хайгуулын хугацаа 2010 онд, XXI талбайн хайгуулын хугацаа 2012 онд тус тус дуусч үйлдвэрлэлийн олборлолтод шилжсэн. XXII талбайг эдийн засгийн үр ашиггүй гэж үзэн буцаах хүсэлтээ гаргасан. Төсөл хэрэгжүүлэгч нь БХГ-т XXI талбайд хайгуулын үеийн нийт 5278.2 км<sup>2</sup> талбайд үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд Монгол улсын Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 154 дүгээр тогтоолоор уурхайн эдэлбэр буюу ашиглалтын талбайг 209,2 км<sup>2</sup> байхаар багасган тогтоосон байна. Эргүүлэн олгох талбайн хэмжээ нь 5038,7 км<sup>2</sup> ба энэ хэсэгт нийт 7 газрын тосны хайгуул үнэлгээний цооног өрөмдсөн байна.

Газрын тосны өрөмдлөг, олборлолтын техник, технологийн дараалал

Газрын тосыг олборлох үйл явц нь Өрөмдлөг → Цооногийн насос суурилуулалт → Олборлолт → Тээвэрлэлт гэсэн дараах дарааллаар явагддаг.




Зураг-1. Олборлолтын техник, технологийн дараалал

Өрөмдлөгийн дараалал, цооногийн гүн болон хугацаа: Өрөмдлөгийн ажил нь өрөмдлөгийн цэгийг тогтоох, замын судалгаа хийх, суурь барих, цооногийн арамыг угсрах, нүүлгэлт хийх, тоног төхөөрөмжийг суурилуулах, анхны өрөмдлөг, хоёр дахь өрөмдлөг, өрмийг оруулах, гаргах, өрмийн хошууг солих, дахин өрөмдөх, дуусах, цахилгаан тест хийх, бэхэлгээний хоолой суулгах, бэхжүүлэх гэсэн дараалалтай байна.

Өрөмдлөгийн ажил нь өрөмдөж эхлээд өрөмдөж дуусах хүртэл бүхий л ажлыг хэлнэ. Ихэнх тохиолдолд анхны өрөмдлөг, дээд давхаргад бэхэлгээний хоолой суулгах, бэхжүүлэх, хоёр дахь өрөмдлөг цооногт тест хийх болон цооногийн хананаас чөмгөн дээж авах, технологийн хоолой суулгах, бэхжүүлэх, гурав дахь өрөмдлөг, зорилтот цэгт хүрэх гэсэн дараалалтай байна.

Дундаж өрөмдлөгийн гүн 2100м, 1 цооногийг өрөмдөж дуусах дундаж хугацаа 20 хоног байдаг.



Зураг-2.Өрөмдлөгийн төхөөрөмжийн бүдүүвч зураг

Түүхий нефтийн насосын ажиллах зарчим болон бүрэлдэх хэсгүүд: XXI талбайд одоогийн байдлаар 240 цооног дээр морин толгой (насос) суурилуулан түүхий тос олборлож байна. Ажиллах зарчим → Цахилгаан мотор хүч дамжуулна.

Хурд багасгагч төхөөрөмж цахилгаан моторын өндөр хурдыг хамгийн удаан хурдтай болгож хөшүүрэг, холбогч гар, тэнцвэржүүлэгч бүтэц нь эргэлдэх хөдөлгөөнийг насосын давтамжит хөдөлгөөн болгож хувирган гүн цооногийн насосын үүргийг гүйцэтгэнэ.

1. Хүч үүсгэх төхөөрөмж: Цахилгаан төхөөрөмж нь насост үндсэн хүч дамжуулна.

2. Хурд багасгагч төхөөрөмж: Хурд багасгагч нь цахилгаан моторын өндөр хурдыг багасгаж тахир тэнхлэгийн хамгийн удаан хөдөлгөөнийг үүсгэж хөшүүргийн тэнцвэртэй байдлыг хангана.

3. Хөшүүрэг, холбогч гар, тэнцвэржүүлэгч бүтэц: Цахилгаан моторын эргэлт нь морин толгойн дээш доош хөдлөх хөдөлгөөнийг үүсгэнэ. Холбогч гар нь тэнцвэржүүлэгчийн дээд хэсэгт холбогдож хөшүүргийн үзүүр доод хөшүүрэгт холбогдож хүч дамжуулна. Тэнцвэржүүлэгч нь арам дээр бэхлэгдэх бөгөөд урд хэсэг нь морин толгойд бэхлэгдэж ачаалал авна. Хойд хэсэг нь тэнцвэржүүлэгч, холбогч, хөшүүрэг, хурд багасгагчид холбогдож цахилгаан моторын хүчийг дамжуулна.

4. Бусад хэсэг: Морин толгой нь тэнцвэржүүлэгчийн урд хэсгийн нуман хөдөлгөөнийг хувиргаж насосын шахагч гол эгц шулуун хөдөлгөөнд орно. Мөн насос ажиллах үед шахагч гол цооногийн амсрын төвд чиглэх бөгөөд цооногийн гүнд даралт өгөх үүрэгтэй. Холбогч нь шахагч гол болон морин толгойг холбосон зөөлөн чанартай эд анги бөгөөд хүчний тестерт график зураг гаргахад ашиглагдана. Арам нь дунд тэнхлэгт тулгуурлан тэнцвэржүүлэгчийг тулж шат болно. Түүхий нефтийн насосын суурь дээр насосын бүх жин төвлөрнө. Хундаам нь хүнд жингийн улмаас түүхий нефтийн насосын газарт суухаас хамгаална.

Түүхий тос хадгалах сав: Цооног бүрийн хажууд түүхий тос түр хадгалах сав буюу танк байна. Цооног бүр дээр 1 танк байрлах бөгөөд түүний багтаамж нь 32тн байна. Танканд хуримтлагдсан түүхий тос нь хэсэг хугацааны дараа хүндийн жингийн улмаас ус, тосны үеийг үүсгэдэг. Ус нь хүндийн жингээрээ доод талд нь тунах бөгөөд энэ усыг цистернээр зөөн үйлдвэрлэлийн шингэн хаягдлын түр санд хуримтлуулдаг.

Нефть дамжуулах хоолойн бүтэц: Нефть дамжуулах хоолой нь ган бүтэцтэй байна. Ган хоолойн гадуур дулаан алдахаас сэргийлсэн материалаар бүрсэн байдаг. Мөн ган хоолойг халаагч утсаар халааж түүхий тосны температурыг хэвийн байдалд хадгалдаг. Ган хоолой нь цооногийн толгойгоос түүхий тос түр агуулах танк хүртэл дунджаар 15м үргэлжилдэг.

### 1.2. 2025 оны газрын тос олборлолт, экспортын мэдээ

Газрын тос олборлолтын БХГ Тамсаг XXI талбайд нийт 572 цооног гарган ашиглах төлөвлөгөөтэй байна. 2025 онд нийт 474 цооногийг ашиглаж байгаагаас 331 нь тос олборлолтын, 143 нь ус шавхалтын цооног байна. 255 цооногоос савлуурт төхөөрөмжөөр, 76 цооногоос шавхалтын техникээр тос олборлож байна.

2013 оноос 2025 оны хооронд газрын тосны олборлолтын мэдээг графикаар үзүүлэв. 2025 оны олборлолтын хэмжээ  $192,8 \cdot 10^3$ тн (2025 оны 10-р сарын 25 байдлаар).




График-1. 2013-2025 оны газрын тосны олборлолтын мэдээ нь график

Цооногийн өрөмдлөг, угсралтын ажил: XXI талбайд 2025 онд газрын тосны хайгуул, олборлолт, үнэлгээний 2 цооног өрөмдөж, цооног угсарч ашиглалтанд шилжүүлэх төлөвлөгөөтэй байсан хэдий ч компанийн санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан өрөмдлөг хийгдээгүй болно.




График-2. 2011-2025 онд ашиглалтад орсон олборлолтын цооног

**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

Газрын тосны олборлолт, экспорт: “Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь 2025 онд БХГ-т XXI талбайгаас нийт 1,572,452.6 баррель буюу 250,000.00 тонн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байсан бөгөөд 2025 оны 10 дугаар сарын 25-ний өдрийн байдлаар олборлолтын цооногуудаас 1,280,926.97 баррель газрын тос олборлож, 1,233,232.72 баррель газрын тосыг ТА-2 олборлолтын ил байгууламжаас ачин Дорнод аймгийн Өвдөг-Баянхошуу боомтоор БНХАУ-руу экспортолсон байна.

<b>2025 он</b>	<b>Олборлолт /тн/</b>	<b>Экспорт /тн/</b>
1-р сард	21051.02	19208.96
2-р сард	18565.464	20826.204
3-р сард	19994.98	19758.6
4-р сард	18785.85	16507.85
5-р сард	19227.14	18177.34
6-р сард	18755.86	21882.03
7-р сард	19373.749	21919.71
8-р сард	19615.58	20289.76
9-р сард	18882.27	18931.75
10-р сард	29399.20	18566.13
11-р сард		
12-р сард		
Нийт	203651.113	196068.334

*Хүснэгт-1. 2025 оны 10-р сарын 25-ны байдлаар*

**1.3. XXI талбай дахь тос цуглуулах шугам хоолой ба олборлолтын нэгдсэн ил байгууламж**

XXI талбайн ТА-2 олборлолтын нэгдсэн ил байгууламжийг 2014 оны 09 дүгээр сарын 13-ний өдөр ашиглалтанд оруулан ажиллаж эхлэсэн. Цооногуудаас олборлох тосны гарцыг сайжруулах, олборлосон тосноос ус болон хийг өндөр түвшинд ялгах, олборлолтын цооног болгоноос машинаар зөөж байсан тосны шингэнийг дамжуулах хоолойгоор солин, тос тээвэрлэлт зөвхөн нэг станцаас явагдах болж машин замаар хөрс талхлагдах, бохирдох явдал эрс буурсан.



**Зураг-3. ТА-2 олборлолтын нэгдсэн байгууламж**

Олборлолтын нэгдсэн байгууламжийн технологи ажиллагааны  
ерөнхий зарчим



Олборлолтын нэгдсэн байгууламж нь үйлдвэрийн баазын түр суурингаас баруун тийш 500 метр зайд байршина. Олборлолтын цооногуудаас тосыг дан болон давхар хоолойгоор халуун ус холих аргаар цуглуулна. Одоогийн байдлаар 240 цооног нэгдсэн байгууламжид холбогдсон байна. Харин ТА-2 нэгдсэн байгууламжид холбогдоогүй болон шавхалтын 15 цооногоос олборлосон тосыг автомашинаар ТА-2 байгууламж руу тээвэрлэн зөөж байна.

Олборлолтын цооног	ТА-2-т холбогдсон цооног	ТА-2-т холбогдоогүй олборлолтын цооног	Өндөр хүчдэлд холбогдсон
331	240	15	255

*Хүснэгт- 2. XXI талбайн ашиглаж буй цооногууд*

Олборлолтын цооногуудыг холбосон шугам хоолойн сүлжээнд тос цуглуулах ба ус хуваарилах дэд станц, ус шахалтын станц баригдсан. Нийт 15 дэд станц байна. Дэд станц бүрд цооногуудыг цагирагаар холбосон байдаг. Олборлолтын цооногоор олборлосон шингэн ойролцоох тос цуглуулах дэд станцаар дамжин олборлолтын нэгдсэн байгууламж руу шахагдана. Олборлолтын нэгдсэн байгууламжаас шахагдсан ус нь хуваарилах дэд станцууд болон шахалтын станцаар дамжин шахалтын цооногоор газрын гүний давхарга руу шахагдана. Тос цуглуулах ба ус хуваарилах дэд станцууд нь бүгд хоорондоо холбоотой байна. Олборлолтын цооног бүрийн технологийн үзүүлэлтүүдийг автоматаар хянах бололцоотой.

Ус холих шугам хоолойг тос цуглуулах ба ус шахах хоолойтой нэг сувагт байрлуулснаар газар шорооны ажлыг хамгийн бага хэмжээнд хийж, хөрсний температурыг хадгалах, шугам хоолойн дулааны алдагдлыг багасгах ач холбогдолтой. Мөн дэд станцуудын шугам хоолойг хооронд нь цуваа холбосноор дулааны нөхцөл сайжирч холих усны тоо багасах ба тос цуглуулах ерөнхий системийн радиус багасаж үйл ажиллагааны зардал буурна.

Газрын тосыг ус, хийнээс ялгах ерөнхий технологи усгүйжүүлэх станцаар боловсруулах шингэний хамгийн дээд хэмжээг 2009 оны олборлолтын удирдамж дээр тодорхойлж гаргасан ба 890 т/ө байна. Түүхий тосыг 2 үе шаттайгаар усгүйжүүлнэ. Үүнд: 1-р шат: 3 фазын сеператор 2-р шат: саванд тунгаах Энэ технологи нь үр дүн тогтвортой, эрчим хүч бага хэрэглэдэг, удирдлага хяналт сайтай, энгийн хялбар арга юм. Цооногийн шингэн нам температурын 3 фазын дегидраторт (усгүйжүүлэх төхөөрөмж) орж тос, ус, хий ялгагдана. Ялгасан тосоо 60 минут орчим тунгаагаад дараа нь халаах зууханд 600С температурт хүртэл халаана. Халаасны дараа 2-4 өдөр босоо саванд тунгаагаад автомашинд ачихад бэлэн болно. Сеператороос гарсан хийг түлшинд хэрэглэснээр байгаль орчны бохирдлоос сэргийлнэ.

**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

Хий үйлдвэрлэл болон ашиглалтын байдал: XXI талбайн ус, тос, хий ялгах ТА-2 байгууламж нь 2025 оны 10-р сарын 25 байдлаар нийт 5,603,160 хий үйлдвэрлэснээр 5,603,160 хийг дулаан үйлдвэрлэхэд ашигласан байна.

№	Огноо	Үйлдвэрлэсэн хий	Дулаанд ашигласан хий	Генераторт ашигласан хэмжээ
1	1-р сар	365753	365753	0
2	2-р сар	327398	327398	0
3	3-р сар	364124	364124	0
4	4-р сар	339631	339631	0
5	5-р сар	341733	341733	0
6	6-р сар	317383	317383	0
7	7-р сар	352353	352353	0
8	8-р сар	356394	356394	0
9	9-р сар	2569910	218595	0
10	10-р сар	268481	268481	0
11	11-р сар			
12	12-р сар			
Нийт		5,603,160	5,603,160	0

*Хүснэгт-3. 2025 онд ТА-2 байгууламжаар үйлдвэрлэсэн хий /м<sup>3</sup>-ээр/*

Ус, тос, хий ялгах байгууламж ашиглалтанд орохоос өмнө хийг олборлолтын явцад цооногийн толгойн хаалтыг нээн байгальд шууд хаядаг байсан бол ТА-2 байгууламж ашиглалтанд орсноор олборлолтын явцад гарсан хийг дулааны энерги болгон халаах зууханд хэрэглэх болсон. Энэ нь байгальд ээлтэй ногоон технологи юм. 1м<sup>3</sup> хийг шатаахад 8500 кКал дулааны энерги ялгардаг гэж үзвэл 2025 онд 47.6\*10<sup>9</sup> хэмжээний кКал дулааны энерги үйлдвэрлэн технологийн хэрэгцээнийхээ усыг халаах зууханд халаан хэрэглэсэн байна.

Ус цэвэршүүлэх үйл ажиллагаа: Ус цэвэршүүлэх үйл ажиллагаа нь дараах зарчмаар явагдана. Үүнд: Усны худаг → усыг хийжүүлэх → марганцтай элсэн шүүр → нарийн цэвэрлэгээний шүүр → цэвэр ус хураах сав → (исэлдэлт идэвхгүйжүүлэх хольц 30 мг/л тунгаар тасралтгүй нэмнэ, бактери, ариутгагч хольц 100 мг/л тунгаар 6-8 цагаар 5 өдрийн давтамжтайгаар нэмнэ) → ус хуваарилах дэд станц.

#### 1.4. Ус ашиглалт

XXI талбайд гадаргын усны илэрц байхгүй бөгөөд унд, ахуйн болон технологийн зориулалттай ус хангамжийн эх үүсвэр нь газрын доорх ус байдаг.

XXI талбай нь сав газрын ангиллаар Мэнэнгийн талын сав газар, Буйр нуур-Халхголын сав газарт хамаардаг. XXI талбайн унд ахуй, газрын тосны хайгуул, ерөмдлөг, олборлолтын үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх усны хэмжээг жил бүр тооцоолон гаргаж холбогдох эрх бүхий байгууллага Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”-аас 2025 оны 04-р сарын 17 өдрийн Е-2501-000145 дугаартай “Ус ашиглуулах дүгнэлт” авсан.

Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”-ын дүгнэлтийг үндэслэн 2025 оны 04-р сарын 29 өдрийн А\07 тоот албан тооттой “Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргааны даргын тушаал”-аар “Ус ашиглах зөвшөөрөл”, “Ус ашиглах гэрээ” байгуулан ажиллаж байна.

2025 онд XXI талбайн хэмжээнд усыг дараах байдлаар ашигласан байна.

1. Ажиллагсдын унд-ахуйн хэрэгцээ болон усалгааны хэрэглээ
2. Нефть олборлолтын технологийн хэрэглээ

1. Унд ахуйн хэрэглээнд: XXI талбайд ажиллагсдын хоол хүнс, унд ахуйн хэрэгцээний усыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм”-ын дагуу тооцдог бөгөөд 2025 онд унд ахуйд  $90'337.50\text{м}^3$  ус ашиглахаас 2025 оны 11 сарын 05-ны өдрийн байдлаар  $46'569.0\text{м}^3$  ус ашигласан байна. Ахуйн хэрэглээний усыг ажилчдын суурингийн дэргэдэх Т21-W36, Т21-W18 усны худгуудаас шугам хоолойгоор дамжуулан ахуйн хэрэглээнд нийлүүлдэг.

2. Нефть олборлолтын үеийн технологийн усны хэрэглээ: XXI талбайн 2025 оны олборлолт нэмэгдүүлэх цооног ерөмдлөг болон барилга байгууламж барих, нефть олборлолт цооногийн ус шахалт, олборлолтын үеийн бүх шатны ажлуудад шаардлагатай усны хэмжээг ус ашиглах төлөвлөгөөндөө тусган холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч ажилласан. Тус төслийн хэмжээнд ус ашиглалтын төлөвлөгөөнд үйлдвэрлэлийн бааз дахь тос олборлох технологийн ус шахалт голлох байр суурийг эзэлдэг бөгөөд тос олборлох технологийн чухал нэг хэсэг юм.

2025 онд XXI талбайн газрын гүнээс үйлдвэрийн технологийн хэрэгцээнд  $1,256,081.5$  усыг авч ашиглахаас үйлдвэрлэлийн зориулалтаар  $733,627.00\text{м}^3$  ус олборлон ашигласан байна. 2025 онд унд ахуй болон үйлдвэрлэлийн хэрэгцээнд

Халхгол сумын нутагт байрлах 34 усны худгийг тоолууртайгаар ашиглаж Дорнод аймгийн Татварын хэлтэст 1,520,075,144.00 төгрөгийг ус ашигласны төлбөр болгон төлж, аймаг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

<b>Огноо</b>	<b>Ашигласан усны хэмжээ /м<sup>3</sup>/</b>	<b>Сарын төлөлт /төгрөг/</b>
1-р сар	76,965.00	154,386,555.20
2-р сар	103,656.00	208,914,876.00
3-р сар	91,266.00	184,425,197.60
4-р сар	85,244.00	172,197,082.40
5-р сар	74,232.00	148,513,560.00
6-р сар	67,860.00	124,545,966.40
7-р сар	81,514.00	147,601,406.40
8-р сар	68,905.00	135,831,943.20
9-р сар	62,623.00	123,731,877.60
10-р сар	67,971.00	124,062,006.4
11-р сар		
12-р сар		
<b>Нийт</b>	<b>780,236.00</b>	<b>1,524,210,471.20</b>

*Хүснэгт-4. 2025 оны 01-р сараас 01-нээс 11-р сарын 05-ны ашигласан усны хэмжээ, төлбөр*

## **2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

### **2.1. Сөрөг нөлөөллийн бууруулах төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд**

Бүтээгдэхүүн хуваах гэрээт XXI талбайн газрын тосны өрөмдлөг, олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.

<b>№</b>	<b>Хэрэгжүүлэх арга хэмжээ</b>	<b>Хэрэгжилт</b>
1	Саармагжуулж хатууруулан техникийн нөхөн сэргээлт хийсэн газруудаас дээж авч лабораторын шинжилгээ хийлгэх	Саармагжуулж хатууруулах техникийн нөхөн сэргээлт хийсэн газруудаас дээж авах ажлыг байгаль орчны зөвлөх үйлчилгээ эрхэлдэг, мэргэжлийн байгууллага болох “Баялаг баян ундарга” ХХК-н гүйцэтгэсэн. Нийт 25 цооногийн нөхөн сэргээлт хийсэн талбайгаас хөрсний дээж авч “Геологийн төв” лаборатори болон Байгаль орчин хэмжилзүйн төв лабораториудад шинжлүүлсэн.

2	Байгаль орчны үнэлгээний ажил	XXI талбайн газрын тосны олборлолт үйл ажиллагаанаас байгаль орчинд /Нэгдсэн байгууламжийн тослог бохир усыг гүн цэвэрлэх байгууламжийг сэргээн засварлах төсөл, химийн бодис, агуулахын эрсдэлийн үнэлгээ/ үзүүлэх сөрөг нөлөөлөл болон болзошгүй эрсдэлийн үед байгаль орчинд бий болох бохирдол, доройтлыг тодорхойлох зорилгоор байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлыг “Цавчирын хөндий” ХХК хийж гүйцэтгүүлж байна.
3	“Тэрбум мод” үндэсний хөтөлбөр	Кемп дотор болон гадна, XXI талбайн дотоод болон экспортын зам дагуу, туслан гүйцэтгэгч ангиуд нийт 2260 ширхэг мод тариалалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Тэрбум модны хөтөлбөрийн хүрээнд Дорнод аймгийн Хэрлэн суманд 5500 ш, Халхгол суманд 5500 ш, Халхгол сумын ялалт багт 1300 ш, Мэнэнгийн отрядад 490 ширхэг модны суулгацыг тус тус хүлээлгэн өгсөн.
4	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нэмэлт ажлууд	Сөрөг нөлөөллийн нэмэлт ажлыг тайланд дэлгэрэнгүй тусгав.

## 2.2. Саармагжуулж хатууруулан техникийн нөхөн сэргээлт хийсэн газруудаас дээж авч лабораторийн шинжилгээ хийлгэх ажил

Нефтийн хайгуул ашиглалтыг 1800-3000м хүртэл гүнтэй цооногуудаар хийдэг учир эдгээр цооногуудын өрөмдлөгийн явцад тодорхой хэмжээний химийн бодисуудыг агуулсан өрмийн шлам үүсдэг. Өрмийн шламуудыг тухайн цооногуудын дэргэд байгуулсан шламын шингэн хаягдлын санд цуглуулдаг. Нэг жилийн дараа уг хаягдлыг булшлан анхны хөрсөөр нь хучдаг. Эдгээр техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдсэн цэгүүдээс хөрсний дээж авч органик бус элементүүдийг лабораторын шинжилгээгээр тодорхойлуулдаг.

Саармагжуулж хатууруулах техникийн нөхөн сэргээлт хийсэн газруудаас дээж авах ажлыг байгаль орчны зөвлөх үйлчилгээ эрхэлдэг, мэргэжлийн байгууллага болох “Баялаг баян ундарга” ХХК-н гүйцэтгэсэн. 2011-2025 оны хооронд нөхөн сэргээлт хийсэн 25 цэгээс 0-20 см-ийн гүнээс хөрсний холимог дээж авч, хэмжилт, зураг авч хээрийн судалгааны ажлыг 2025 оны 09 сарын 04-06-ны өдрүүдэд хээрийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэв.

Уг ажлын хүрээнд MNS3298-90 “Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд” стандартыг баримтлан, нийт 25 цооногийн нөхөн сэргээлт хийсэн талбайгаас хөрсний дээж авч “Геологийн

**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

судалгаа-шинжилгээний төв” лаборатори болон Цаг уур, орчны шинжилгээний газар, Байгаль орчин хэмжилзүйн төв лабораториудад шинжлүүлсэн.

№	Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг			Техникийн нөхөн сэргээлт хийсэн он
		Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд	
1	N-500-252	116	56	10.23	47	38	57.43	2014
2	N-504-260	116	56	50.67	47	38	39.98	2014
3	ҮШХС 1	117	2	0.94	47	37	0.9	2025
4	ҮШХС 2	117	2	2.18	47	37	0.81	2025
5	ҮШХС 3	117	2	7.85	47	37	0.6	2025
6	ҮШХС 4	117	2	11.93	47	37	0.88	2025
7	N-496-210	117	0	26.58	47	39	56.04	2016
8	N-490-200	116	59	39.43	47	40	16.6	2018
9	N-502-192	117	1	16.01	47	40	1.33	2016
10	N-506-182	117	1	16.01	47	40	1.33	2014
11	N-516-180	117	1	36.12	47	39	43.83	2019
12	N-518-174	117	1	59.86	47	39	46.62	2019
13	N-544-170	117	2	49.62	47	38	57.44	2016
14	N-502-142	117	3	36.73	47	41	2.07	2014
15	N-486-158	117	2	18.5	47	41	14.9	2011
16	N-500-176	117	1	31.83	47	40	24.11	2014
17	T21-36-p33	117	5	27.26	47	45	26.59	2025
18	N-474-178	117	0	31.44	47	41	17.01	2017
19	N456-104	117	3	58.28	47	42	54.59	2016
20	N454-66	117	6	42.39	47	43	40.97	2016
21	N428-64	117	6	13.74	47	44	44.6	2018
22	N480-172	117	1	4.37	47	41	9.92	2011
23	N566-214	117	0	41.09	47	37	28.94	2016
24	T21-54-X4	116	48	5.36	47	26	6.48	2024
25	T21-54-X3	116	47	48.26	47	25	40	2024

**Хүснэгт-5.Хөрсний дээж авсан цэгүүдийн газарзүйн солбицол**

**Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори:** Хээрийн судалгааны үр дүн болон лабораторийн шинжилгээний үр дүнгүүдийг дүгнэж, цэг (цооног) тус бүрээр задлан шинжилгээг доор оруулав (Хүснэгт 5).

№	Дээж авсан цэг	Кадмий (Cd)	Хар тугалга (Pb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Стронций (Sr)	Эрдэс тос	pH	Сульфат (SO <sub>4-2</sub> )
1	N500-252	<0.05	12.0	<0.005	<0.5	<0.5	28.0	387.0	0.22	8.12	20.0
2	N504-260	<0.05	8.0	<0.005	<0.5	<0.5	26.0	441.0	0.28	8.35	14.0
3	ҮШХС -1	<0.05	9.0	<0.005	<0.5	9.0	16.0	339.0	0.14	8.22	16.0
4	ҮШХС -2	0.2	10.0	<0.005	<0.5	<0.5	26.0	321.0	0.28	8.25	18.0
5	ҮШХС -3	<0.05	10.0	<0.005	<0.5	<0.5	29.0	354.0	0.28	8.52	12.0
6	ҮШХС -4	<0.05	9.0	<0.005	<0.5	1.0	28.0	312.0	2.78	8.65	18.0
7	N 496-210	<0.05	12.0	<0.005	<0.5	<0.5	29.0	321.0	2.0	7.98	35.0
8	N 490-200	0.1	9.0	<0.005	<0.5	<0.5	28.0	309.0	2.0	8.59	19.0
9	N502-192	<0.05	7.0	<0.005	<0.5	<0.5	27.0	292.0	0.05	8.78	19.0

**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

10	N506-182	1.2	11.0	<0.005	<0.5	16.0	28.0	314.0	0.1	8.13	15.0
11	N516-180	<0.05	11.0	<0.005	<0.5	39.0	27.0	309.0	0.12	8.56	28.0
12	N518-174	<0.05	7.0	<0.005	<0.5	<0.5	27.0	310.0	0.44	8.32	45.0
13	N544-170	1.0	1.0	<0.005	<0.5	<0.5	29.0	371.0	0.22	7.26	56.0
14	N502-142	2.3	11.0	<0.005	<0.5	<0.5	26.0	295.0	0.9	8.12	11.0
15	N486-158	0.8	8.0	<0.005	5.0	27.0	23.0	319.0	0.4	8.36	35.0
16	N500-176	<0.05	9.0	0.8	<0.5	40.0	28.0	256.0	0.98	8.79	14.0
17	T21-36-p33	<0.05	8.0	<0.005	<0.5	16.0	30.0	299.0	3.44	8.95	20.0
18	N474-178	0.2	9.0	<0.005	<0.5	<0.5	28.0	264.0	0.32	8.02	16.0
19	N456-104	0.1	8.0	<0.005	<0.5	<0.5	28.0	329.0	0.26	8.38	21.0
20	N454-56	0.9	7.0	<0.005	<0.5	<0.5	28.0	330.0	0.32	8.74	3.0
21	N428-64	0.4	8.0	0.6	<0.5	<0.5	29.0	306.0	0.28	8.36	19.0
22	N480-172	0.1	8.0	<0.005	<0.5	25.0	28.0	237.0	1.32	7.58	5.0
23	N566-214	<0.05	8.0	<0.005	<0.5	<0.5	29.0	333.0	0.35	8.01	16.0
24	T21-54-X4	0.6	8.0	<0.005	<0.5	37.0	29.0	292.0	0.34	8.59	28.0
25	T21-54-X3	<0.05	9.0	<0.005	<0.5	<0.5	29.0	287.0	0.2	8.32	7.0
<b>MNS 5850:2019/ ЗДХ/</b>											
<b>Хүлцэх хэмжээ, мг/кг</b>	<b>3.0</b>	<b>100.0</b>	<b>2.0</b>	<b>150.0</b>	<b>300.0</b>	<b>100</b>	<b>800.0</b>				

*Хүснэгт-6. Тамсаг-XXI талбайн нөхөн сэргээлт хийсэн цооногийн хөрсөн дэх хүнд металл, эрдэс тос, уусмалын орчин болон сульфатын агууламж<sup>1</sup>*

Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн задлан шинжилгээний үр дүнгээс харахад бүх цэгүүдээс авсан хөрсний уусмалын орчин 7.26-7.98 байж хөрс сул шүлтлэгээс (7.1-8.0) дунд шүлтлэг (8.1-8.8)-ийн хооронд хэлбэлзэж байна. Тодруулбал, N496-210; N544-170; N480-172 дугаартай цооног орчимд нөхөн сэргээлт хийсэн газрын хөрс нь сул шүлтлэг гэсэн “сайн” үзүүлэлттэй байна. Харин бусад бүх цооногийн орчимд нөхөн сэргээлт хийсэн газрын хөрс давсжилт ихтэй өөрөөр хэлбэл рН нь 8.1-8.8 буюу “дунд” шүлтлэг шинж чанартай байна. Нийт 25 цэгээс 22 цооногийн (88%) хөрс нь дунд шүлтлэг чанартай байна. 2021 онд хийсэн судалгаанаас үзэхэд байгалийн жамаар байгаа талын хүрэн хөрсний уусмалын орчин (рН) 7.7-8.1 байсан байна (Энхтөр, 2021). Иймд XXI талбайн хөрс ер нь “дунд” шүлтлэг шинж чанартай болохыг гэрчилж байна (график-3).

<sup>1</sup> Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн задлан шинжилгээний үр дүн





График-3. Цооногийн орчимд нөхөн сэргээлт хийсэн хөрсний уусмалын орчин, эрдэс тос мөн сульфатын агууламж

Эрдэс тос буюу хөрсөнд агуулагдах нефтийн хэмжээ 0.1-3.4 гр/кг. ҮШХС-4: N496-210; N490-200; T21-36-p33 дугаартай цооногуудад эрдэс тосны хэмжээ 2.0-3.4 гр/кг байж бусад цооногийнхоос их гарсан байна. Сульфат 3-56 мг/кг байгаа нь хөрс хүхрийн хүчлийн үлдэгдлээр бохирдоогүй байгааг харуулж байна. График-4-д Цооног бүрийн нөхөн сэргээлт хийсэн газрын хүнд металлуудыг үзүүлэв.






График-4. Цооногийн орчимд нөхөн сэргээлт хийсэн газрын хүнд металлууд

Байгаль орчин хэмжил зүйн төв лабораториор тодорхойлуулсан бүх цооногийн орчимд нөхөн сэргээлт хийсэн газарт Кадмий (Cd), Хар тугалга (Pb), Мөнгөн ус (Hg), Хром (Cr), Цайр (Zn), Зэс (Cu), Стронций (Sr) зэрэг хүнд металлууд зөвшөөрөгдөх хэмжээнээс бүгд “бага” хэвийн байна. Өөрөөр хэлбэл хөрсөнд хүнд металлын бохирдол байхгүй. Мөнгөн ус (Hg)-ны задлан шинжилгээ бүх дээжид маш бага <0.005 мг/кг байгаа бол N500-176; N428-64 дугаартай цооногийн дэргэд 0.6-0.8 буюу зөвшөөрөгдөх хэмжээнээс “бага” байна.

Геологийн судалгаа-шинжилгээний төв: XXI талбайн 25 цэгээс авсан хөрсний давталт бүхий (адил) холимог дээжид хийлгэсэн шинжилгээний дүнг Хүснэгт 6-д харуулав.

№	Дээж авсан цэг	Кадмий (Cd)	Хар тугалга (Pb)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Стронций (Sr)
1	N500-252	<0.1	14.3	16.8	5.8	<5.0	198.0
2	N504-260	<0.1	12.9	11.9	9.8	6.5	183.0
3	ҮШХС -1	<0.1	12.8	10.4	<5.0	<5.0	178.0
4	ҮШХС -2	<0.1	14.7	13.9	14.4	<5.0	175.0
5	ҮШХС -3	<0.1	12.2	9.3	<5.0	<5.0	166.0
6	ҮШХС -4	<0.1	12.3	12.0	<5.0	<5.0	160.0
7	N 496-210	<0.1	12.5	12.7	32.7	<5.0	172.0


XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

8	N 490-200	<0.1	11.6	11.5	9.3	15.0	167.0
9	N502-192	<0.1	12.3	15.6	9.0	<5.0	164.0
10	N506-182	<0.1	11.9	14.6	7.0	<5.0	155.0
11	N516-180	<0.1	12.7	10.7	32.0	<5.0	160.0
12	N518-174	<0.1	11.7	11.1	16.8	5.5	159.0
13	N544-170	0.11	13.3	14.7	8.9	5.4	164.0
14	N502-142	0.1	11.9	26.8	18.6	<5.0	175.0
15	N486-158	<0.1	12.3	29.2	26.7	<5.0	197.0
16	N500-176	0.1	11.3	19.2	6.9	<5.0	153.0
17	T21-36-p33	<0.1	12.1	15.5	13.1	<5.0	183.0
18	N474-178	0.1	13.7	13.9	10.7	5.45	167.0
19	N456-104	<0.1	12.4	13.0	7.0	5.50	174.0
20	N454-56	<0.1	11.4	16.3	5.5	<5.0	175.0
21	N428-64	0.1	12.5	31.1	15.2	<5.0	189.0
22	N480-172	<0.1	11.9	15.0	<5.0	<5.0	156.0
23	N566-214	<0.1	13.2	16.0	12.5	<5.0	167.0
24	T21-54-X4	<0.1	11.6	17.2	<5.0	<5.0	183.0
25	T21-54-X3	<0.1	11.3	16.9	7.8	<5.0	159.0
<b>MNS 5850:2019 / ЗДХ/</b>							
<b>Хүлцэх хэмжээ, мг/кг</b>	<b>3.0</b>	<b>100.0</b>	<b>150.0</b>	<b>300.0</b>	<b>100.0</b>	<b>800.0</b>	
<b>Хортой хэмжээ, мг/кг</b>	<b>10.0</b>	<b>500.0</b>	<b>400.0</b>	<b>600.0</b>	<b>500.0</b>	<b>3000.0</b>	

Хүснэгт-7. Тамсаг-XXI талбайн нөхөн сэргээлт хийсэн цооногийн хөрсөн дэх 6 хүнд металлын агууламж

Хүснэгт 6-аас харахад Геологийн төв лабораториор тодорхойлуулсан 25 цооног орчимд нөхөн сэргээлт хийсэн газарт Кадмий (Cd), Хар тугалга (Pb), Хром (Cr), Цайр (Zn), Зэс (Cu), Стронций (Sr) зэрэг 6 хүнд металлууд зөвшөөрөгдөх хэмжээнээс бүгд “бага” хэвийн байна. Өөрөөр хэлбэл хөрсөнд хүнд металлын бохирдол байхгүй байна.

Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори (Хүснэгт 5) болон Геологийн судалгаа-шинжилгээний төв (Хүснэгт 6)-д Кадмий (Cd), Хар тугалга (Pb), Хром (Cr), Цайр (Zn), Зэс(Cu), Стронций (Sr) хэмээх 6 хүнд металлын задлан шинжилгээ хоёр лабораторид тодорхойлогдсон. Тэдгээрийн задлан шинжилгээний дүнгээс үзэхэд бүгд хүлцэх агууламжаас бага байна.






График-5. Цооногийн орчимд нөхөн сэргээлт хийсэн газрын хүнд металлууд

Хүснэгт 6 болон график-5-аас харахад Геологийн судалгаа-шинжилгээний төвөөр тодорхойлуулсан 25 цооногийн орчимд нөхөн сэргээлт хийсэн газарт Кобальт (Co), Никель (Ni), Молибден (Mo), Цагаан тугалга (Sn) зэрэг 4 хүнд металлууд зөвшөөрөгдөх хэмжээнээс бүгд “бага” хэвийн байна. Өөрөөр хэлбэл хөрсөнд дээр дурдсан 4 хүнд металлын бохирдол ажиглагдаагүй.

№	Дээж авсан цэг	Кобальт (Co)	Никель (Ni)	Молибден (Mo)	Цагаан тугалга (Sn)
1	N500-252	2.7	6.8	0.8	1.5
2	N504-260	2.8	9.0	0.7	1.0
3	ҮШХС -1	3.0	5.9	0.5	1.0
4	ҮШХС -2	3.6	9.2	0.6	1.2
5	ҮШХС -3	2.7	6.5	0.5	1.0
6	ҮШХС -4	2.7	6.3	0.5	1.0
7	N 496-210	3.0	6.6	0.6	1.0
8	N 490-200	3.0	7.0	1.1	1.1
9	N502-192	3.4	7.1	0.8	1.1
10	N506-182	3.0	7.0	0.6	1.0
11	N516-180	2.8	5.8	0.6	1.0
12	N518-174	2.8	6.6	0.5	1.0
13	N544-170	3.3	7.2	0.7	1.1
14	N502-142	3.0	6.8	0.5	1.0

№	Дээж авсан цэг	Кобальт (Co)	Никель (Ni)	Молибден (Mo)	Цагаан тугалга (Sn)
15	N486-158	2.8	7.2	0.6	1.1
16	N500-176	2.8	5.8	0.6	1.0
17	T21-36-p33	3.4	7.6	0.6	1.0
18	N474-178	3.2	6.6	0.7	1.1
19	N456-104	2.8	6.2	0.5	1.0
20	N454-56	2.8	6.5	0.5	1.0
21	N428-64	3.6	8.0	0.6	1.1
22	N480-172	2.5	6.0	0.5	0.8
23	N566-214	2.7	6.1	0.7	1.0
24	T21-54-X4	2.7	7.2	0.5	1.0
25	T21-54-X3	2.5	7.1	0.5	0.9
<b>MNS 5850:2019/ ЗДХ/</b>					
<b>Хүлцэх хэмжээ, мг/кг</b>		<b>50.0</b>	<b>50.0</b>	<b>5.0</b>	<b>50.0</b>
<b>Хортой агууламж</b>		<b>500.0</b>	<b>1000.0</b>	<b>20.0</b>	<b>300.0</b>
<b>Аюултай агууламж</b>		<b>1000.0</b>	<b>1800.0</b>	<b>50.0</b>	<b>500.0</b>

Хүснэгт-8. Геологийн судалгаа-шинжилгээний төвд хийсэн хөрсний задлан шинжилгээний үр дүн




График-6. Хөрсөн дэх хүнд металлын агууламжийн тархалт

**Хөрсөн дэх хүнд металлын агууламжийн тархалт:** Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори (хөх өнгө) болон Геологийн судалгаа-шинжилгээний төв (улаан өнгө)-ийн шинжилгээний үр дүнг харьцуулан тархалтаар үзүүлэв. Нөхөн сэргээгдсэн хөрсний дээжийн 25 цэгт тодорхойлогдсон хүнд металлын (Cd, Pb, Cr, Zn, Cu, Sr) агууламжийн утгууд MNS 5850:2019 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага байна.

**ДҮГНЭЛТ:** XXI талбайн дээж авсан цэг нь 2011 онд 1, 2014 онд 5, 2016 онд 6, 2017 онд 1, 2018 онд 2, 2019 онд 2, 2024 онд 2, 2025 онд 5 гээд нийт 25 цэг нь нөхөн сэргээлт хийсэн компанийн хувьд өөр өөр, он цагийн хувьд харилцан

адилгүй, байршлийн хувьд таруу байдалтай түүвэрийн аргаар сонгон авсан цэгүүд бөгөөд энэхүү 25 газрын тодорхойлуулсан хөрс бохирдуулагч бодисын агууламжуудад онцолж тусгайлан үзэх ялгаа ажиглагдахгүй байна. Өөрөөр хэлбэл бүх цэгүүдэд хүнд металл болон бусад бохирдуулагч параметрийн агууламжийн тоон утгууд бүгд давхцалтай төлөв байдал ажиглагдаж байна. Судалгаа хийсэн газарт карбонаттай талын хүрэн хөрс тархсан байна.

MNS 5850:2019 “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартыг мөрдлөг болгон Байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори болон Геологийн судалгаа-шинжилгээний төвд 25 цэгийн хөрсөнд хөрсний органик биш бохирдуулагч бодисууд болох Хром (Cr), Никель (Ni), Цагаан тугалга (Sn), Кобальт (Co), Молибден (Mo), Зэс (Cu), Хар тугалга (Pb), Цайр(Zn), Кадмий (Cd), Стронций (Sr)-ын агууламж, эрдэс тос, уусмалын орчин (pH), сульфат (SO<sub>4</sub>-2) зэрэг 13 параметрийг тодорхойлов. Тайланд дурдсан хүнд металл болон бусад аль ч бодисоор хөрс бохирдоогүй байна.

### **2.3. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажил**

Бүтээгдэхүүн хуваах гэрээт “Тамсаг XXI талбайн газрын тос олборлох төсөл”-ийн 2025 оны БОННУ-ний нэмэлт тодотголын хүрээнд Нэгдсэн байгууламжийн тослог бохир усыг гүн цэвэрлэх байгууламжийг сэргээн засварлах болон Химийн бодис, агуулахын төслүүд багтсан.

2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан дээрх төсөлт ажлуудыг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоох, байгаль хамгаалах арга хэмжээг төлөвлөх зорилгоор байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланг мэргэжлийн байгууллагаар боловсруулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын гол зорилго нь ТА-2 нэгдсэн байгууламжийн тослог бохир усыг гүн цэвэрлэх байгууламжийг сэргээн засварлах болон Химийн бодисны агуулахын төслийн хүрээнд БОУАӨЯ-аас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан чиглэл, хуваарийн дагуу төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон нийгэм эдийн засагт үзүүлэх гол болон болзошгүй нөлөөллүүд, эрсдэлийг үнэлэх, сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж үнэлэлт дүгнэлт өгөх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад оршино.

Төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын ажлыг тогтвортой хөгжил, байгаль орчны зөвлөх үйлчилгээний "Цавчирын Хөндий" ХХК хийж гүйцэтгэж байна.

"Цавчирын Хөндий" ХХК нь БОННУ-ний нэмэлт тодотголын хүрээнд хээрийн судалгааны ажлыг төслийн талбайд 2 удаа ирж ажилласан ба байгаль орчны бүрдэл хэсгүүдийг тодорхойлж, хэмжилт, дээжлэлт хийн, төслийн үйл ажиллагааны явцад зайлшгүй оролцож, шийдвэр гаргах байгууллага, орон нутгийн удирдлагуудтай уулзалт хийж, төслийн талаарх танилцуулга, санал авах, хээрийн судалгааны ажилд хөндлөнгийн хяналт хийх ажлуудыг зохион байгуулсан.

2025 оны БОННУ-ний нэмэлт тодотголын тайлан боловсруулах, хээрийн хэмжилт судалгааны ажилд "Цавчирын хөндий" ХХК-ийн захирал Б.Дашлхам, гүйцэтгэх захирал, ургамал судлаач Э.Цэнгэлмаа, Байгаль орчны мэргэжилтэн, газарзүйч Б.Сайханчимэг, Хөрс судлаач Г.Түвшин, Сүхбаатар ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторийн эрхлэгч Н.Мөнхбаяр нар хээрийн судалгааны ажлыг хийн хөрсний зүсэлт, ургамлын геоботаникийн бичиглэл, агаарын сорьц, усны шинжилгээ, төслийн талбайн өнөөгийн төлөв байдлыг судалж, судалгааны үр дүнд үндэслэн тайланг боловсруулсан.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайланг боловсруулахад судалгааны талбай түүний орчны бүс нутагт хийгдэж байсан 1999, 2012, 2013, 2014, 2015, 2019, 2020, 2023, 2024 оны байгаль орчны үнэлгээний тайлан, 40 гаруй ном товхимол, судалгааны ажлыг шүүн суурь мэдээлэл цуглуулж, цаг уур орчны шинжилгээний газрын Халхгол станцын 1961-2024 оны агаарын температур, хур тунадасны мэдээ, бусад үзүүлэлтүүдийг сүүлийн 10 жилийн цаг уурын мэдээнд анализ хийн дүгнэсэн.

Хээрийн хэмжилт судалгааны ажлыг 2025 оны 7, 9 дүгээр сард гүйцэтгэн төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй 16 худагт газрын доорх усны түвшний хэмжилт хийн, кемпийн унд ахуйн ус, ТА-2 үйлдвэрийн цэвэршүүлсэн болон ялгасан ус, цэвэрлэх байгууламжаас гарч буй уснаас тус тус дээж авч Шинжлэх ухааны академийн Газарзүй геоэкологийн хүрээлэнгийн шинжилгээний лабораторид шинжлүүлэн, хөрсөн бүрхэвчийн судалгаагаар нөлөөлөлд өртөх бүсэд хөрсний 3 хагас зүсэлт, орчны бүсэд буюу дээрх цэгүүдтэй ойрхон байрлалтай мониторингийн 5 цэгт тус тус хөрсний хэмжилт судалгаа хийж, хөрсний төлөв байдлыг тодорхойлох зорилгоор өнгөн хөрсний буюу 0-10 см болон хагас зүсэлтийн 0-40 см гүнээс дээжлэлт хийж нийт 11 ширхэг дээж авч Газарзүй

геоэкологийн хүрээлэн, хүнд металлыг SGS Mongolia олон улсын магадлан итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн үр дүнд анализ хийж, ургамлан нөмрөгийн судалгаагаар 15 цэгт ургамлан нөмрөгийн хээрийн бичиглэл хийж тархалт, бүрхэц, нягтшил, хэв шинж, зүйлийн бүрдлийг тодорхойлон хэв шинж, газрын гадарга, ландшафтын ялгаатай байдлыг үнэлж, амьтны аймгийн хээрийн судалгааг урьдчилан төлөвлөсөн маршрутын дагуу явж тэмдэглэл хөтөлж, фото зургаар баримтжуулсан.

Суурин боловсруулалтын ажлын үе лабораторийн задлан шинжилгээний үр дүнгүүдийг холбогдох стандартууд, бүс нутгийн суурь утга зэрэгтэй харьцуулан үнэлэлт дүгнэлт өгснөөс гадна газрын доорх усны зүй тогтлыг тогтооход геоморфологийн хэв шинжийг хээрийн маршрутаар тандан судлах, гадаргуугийн налуу тогтоох, гидрогеологийн зураглал үйлдэх, ус хурах талбайг загварчлалаар тооцоолсон. Тухайн талбайн газрын доорх усны ус хурах талбайг тооцоолохдоо SWAT загварчлалыг ашигласан, ургамлан бүрхэвчийн өөрчлөлтийг үнэлэхэд ургамлын нормчилсон индекс NDVI-ийг тус тус ашигласан.

Зураглалын ажлыг гүйцэтгэхдээ ArcGIS 10.4 программын ArcMap программ ашигласан бөгөөд судалгааны зорилгод нийцүүлэн агаар, сансрын зургуудыг (Landsat 15 м, 2010 он, Google Earth 2019, Sentinel 2018) ашиглан газрын гадаргын бүрхэвчийн сэдэвчилсэн зургуудыг Arc GIS 9.3, Global Mapper 12.0 зэрэг газарзүйн мэдээллийн системийн үндсэн программуудыг ашиглан үйлдэж (өндөршил, налуу, зүг зовхис г.м), байр зүйн зураг (1:500,000) болон бусад зургуудыг зохих масштабын дагуу боловсруулсан болно.

## **2.4. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөр**

### **2.4.1. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээний мод тариалалт**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн ажлын хүрээнд “Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн.

2025 оны мод тариалалтыг мод үржүүлэг, уул уурхайн нөхөн сэргээлт, цэцэрлэгжүүлэлт, гадна тохижилт, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Байгалиа дээдлье” ХХК-тай хамтарч ажилласан ба MNS5918:2008 стандартыг баримтлан мод тариалалт хийсэн бөгөөд өмнө жил тариалалт хийсэн ургаагүй болон малын хөлд өртсөн моднуудыг авч солиж нөхөн тариалалт хийсэн.

Хаврын мод тариалалтаар ажилчдын кемпийн баруун талд, туслан гүйцэтгэгч ангиуд, 58 км зам дагуу нийт 2260 ширхэг модыг тариалсан.

№	Модны нэр	Тоо хэмжээ	Тариалалтын байршил
1	Мөнгөлөг улиас	200	58км-ын зам дагуу 0.8 км-т
2	Мөнгөлөг улиас	600	Кемпийн баруун талд
3	Голт бор	200	
4	Гүйлс	200	
5	Шар хуайс	700	ТА-2 нэгдсэн байгууламж
6	Мөнгөлөг улиас	200	
7	Гүйлс	60	Туслан гүйцэтгэгч ангиуд
8	Голт бор	100	
Нийт		2260	

Хүснэгт-9.Тариалсан модны жагсаалт

Мөнгөлөг улиас модыг 2 метрийн зайтай салхины хаалт болон өндөр ногоон масс ихтэй байдлаар, голт бор, буйлс, гүйлс модыг гоёлын зориулалтаар, ТА-2 нэгдсэн байгууламжийн хашаа дотор хайлаас модыг замын хоёр талаар хашаа хэлбэрээр ойр ойрхон зайтай шар хуайс жигд модыг бөөрөнхий тогоо хэлбэрт оруулахаар, төгөл үүсгэж тариалсан нь төслийн талбай өнгө төрхийг үзэмжтэй болгох, үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх зорилготой ажлуудыг жил бүр хийж гүйцэтгэж байна.

2025 оны мод тариалалтын үйл ажиллагаа дараах байдлаар явагдсан. Үүнд:

- Ургалт дэмжих бордооны хэрэглээ: 6-р сар болон 8-р сард органик бордоо шингэн азотын бордоог тус бүр нэг удаа хэрэглэсэн.
- Хөрс хамгаалалт: Мод бүрийн үндэс орчимд мульч (өвс, сүрэл) тавьж, чийг баригчийн үүрэг гүйцэтгэсэн.
- Хортон шавьжийн эсрэг арга хэмжээ: Биологийн гаралтай “БиоХаб-1” бэлдмэлээр 2 удаа боловсруулалт хийсэн.
- Усалгааны горим: Мод тариалалтын дараа сард 5-6 удаа, намрын цэнэг усалгааг 10 сарын 01-нээс 10-р сарын 25 хооронд хийсэн.

№	Байршил	Модны усалгааны хуваар			
		Төлөвлөгөөт усалгаа		Хийгдсэн усалгаа	
		Сард	Намрын цэнэг усалгаа	06 сар-09 сар	10 сард намрын цэнэг усалгаа 25 хоног хийгдсэн.
1	Кемпийн баруун тал	5-6 удаа	10-р сарын 01-нээс 10-р сарын 25 өдөр хооронд	5-6 удаа	
2	ТА-2-оос урагшаа 1 км	5-6 удаа		5-6 удаа	
3	58 км зам дагуу баруун тал	5-6 удаа		5-6 удаа	

4	58 км зам дагуу зүүн тал	5-6 удаа		5-6 удаа	
5	Туслан гүйцэтгэгч ангиудын урд хэсэг	5-6 удаа		5-6 удаа	

Хүснэгт-10. Усалгааны хуваарь

#### 2.4.2. “Тэрбум мод” хөтөлбөрийн орон нутгийн хамтын ажиллагаа

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь нийгмийн хариуцлагын болон орон нутгийн хамтын ажиллагааны ажлын хүрээнд Дорнод аймгийн Хэрлэн сум, Дорнод аймгийн Халхгол сумын Засаг даргын Тамгын газарт 11000 ширхэг суулгацыг хүлээлгэн өгсөн. Мөн Дорнод аймгийн Халхгол суман дах сум дундын ойн ангид 1300 ширхэг, Мэнэнгийн отрядад 490 ширхэг модны суулгацыг хүлээлгэн өгсөн.

“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд манай компани нь 2025 оны 06-р сарын 09 өдөр Дорнод аймгийн Байгаль орчны газарт дараах модны суулгацуудыг хүлээлгэн өгсөн. Үүнд:

№	Суулгацны нэр төрөл	Тоо хэмжээ	Суулгацны нас	Суулгацны өндөр
1	Гүйлс	2500	2 нас	70-80 см
2	Жигд	2500	2 нас	60-70 см
3	Шар хуайс	500	2 нас	1.5м
Нийт		5500		

Хүснэгт-11. Дорнод аймагт өгсөн модны суулгац

“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд манай компани нь 2025 оны 06-р сарын 09-ны өдөр Дорнод аймгийн Халхгол сумын Засаг даргын тамгын газарт дараах нэр төрлийн модыг хүлээлгэн өгсөн. Үүнд:

№	Суулгацны нэр төрөл	Тоо хэмжээ	Суулгацны нас	Суулгацны өндөр
1	Гүйлс	2500	2 нас	70-80 см
2	Жигд	2500	2 нас	60-70 см
3	Шар хуайс	500	5 нас	1.5м
Нийт		5500		

Хүснэгт-12. Халхгол суманд өгсөн модны суулгац

“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд манай компани нь 2025 оны 06-р сарын 09 өдөр Дорнод аймгийн Халхгол суман дах сум дундын Ойн ангид доорх нэр төрлийн модны суулгацыг хүлээлгэн өгсөн. Үүнд:

**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

№	Суулгацны нэр төрөл	Тоо хэмжээ	Суулгацны нас	Суулгацны өндөр
1	Гүйлс	500	3 нас	1.2 м
2	Буйлс	100	4 нас	1.5 м
3	Голт бор	100	3 нас	1 м
4	Мөнгөлөг улиас	300	3 нас	1.2-1.8 м
5	Хайлаас	300	3 нас	1.5м
Нийт		1300		

*Хүснэгт-13. Халхгол суманд өгсөн модны суулгац*

“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд манай компани нь 2025 оны 06-р сарын 11 өдөр Мэнэнгийн отрядад доорх нэр төрлийн модны суулгацыг хүлээлгэн өгсөн. Үүнд:

№	Суулгацны нэр төрөл	Тоо хэмжээ	Суулгацны нас	Суулгацны өндөр
1	Гүйлс	100	3 нас	1.2 м
2	Буйлс	60	4 нас	1.5 м
3	Голт бор	40	3 нас	1 м
4	Мөнгөлөг улиас	90	3 нас	1.2-1.8 м
5	Хайлаас	200	3 нас	1.5м
Нийт		490		

*Хүснэгт-14. Мэнэнгийн отрядад өгсөн модны суулгац*

**ДҮГНЭЛТ:** “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд XXI талбайд тариалалт хийсэн хэсгүүдийн нөхөн сэргээлт, ногоон байгууламж нь төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчинд ээлтэй, орчны үзэгдэх байдалд өнгө төрх нэмсэн, тухайн орчны экосистем эерэг нөлөө үзүүлсэн ажил болсон.

**2.5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нэмэлт ажлууд**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт
1	Хөрсөн бүрхэвч	Хөрсөнд тос нэвчихээс хамгаалах дэвсгэр	Цооног өрөмдлөг болоод үйлчилгээ хийгдэж буй талбай	2025 онд цооног үйлчилгээний ажил 121 ажил хийсэн бөгөөд тухай бүрд нь хөрсөнд тос нэвчихээс сэргийлж дэвсгэр дэвсэн ажил гүйцэтгэсэн.
2	Ургамлан нөмрөг	Ашиглалтаас гарсан замыг	XXI талбайн хэмжээнд	XXI талбайн олборлолтын үйл ажиллагаанаас үүссэн олон салаа

		хагалах, тэмдэгжүүлэх		зам, ашиглахгүй болсон зам талбайнуудыг хаах, хагалах, борнойдох, тэмдэгжүүлэх ажлыг “Дорнод телнет сүлжээ” ХХК-аар нийт 30 га талбайг хагалах ажлыг хийж гүйцэтгүүлсэн.
3	Хөрсөн бүрхэвч, ус орчин	Ахуйн бохир цэвэрлэх байгууламж	XXI талбайн хэмжээнд	2025 онд стандартын шаардлага хангасан ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийг ашиглалтанд оруулсан.
4	Байгаль орчны мэдлэгийг дээшлүүлэх	Байгаль орчны чиглэлээр сургалт явуулах	XXI талбайн хэмжээнд	-Усны тухай, түүний хэрэглээ, усны эх үүсвэрийг хамгаалсан тухай -Хөрсний бохирдол, нүхэн жорлон түүний байгальд ээлтэй шийдэл -Хог хаягдлын менежмент

### 2.5.1. Хөрсөнд тос нэвчихээс хамгаалах дэвсгэр дэвсэх

2025 онд цооног үйлчилгээний 121 ажил хийсэн ба тухай үед тогтмол цооногийн толгой хэсэгт 8\*8м хэмжээтэй тос үл нэвчүүлэгч дэвсгэрийг давхарлаж дэвсүүлэх, тостой труба болон өрмийн суурь машинд хэрэглэгдсэн багаж төхөөрөмжийн дор дэвсүүлэн тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Мөн ашиглахгүй болсон дэвсгэрийг аюултай хог хаягдал гэж үзэж аюултай хог хаягдал авах тусгай зөвшөөрөлтэй компанид шилжүүлсэн ба дэлгэрэнгүйг хог хаягдлын тайланд тусгасан. Хог хаягдлын тайлангийн хавсралт зурагт хэсэгт оруулав.

### 2.5.2. Ашиглалтаас гарсан замыг хагалах, тэмдэгжүүлэх

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний XXI талбайн олборлолты бүс нутагт ашиглахгүй болсон олон салаа замуудыг хаах, хагалах, борнойдох, тэмдэгжүүлэх ажлыг “Дорнод телнет сүлжээ” ХХК хийж гүйцэтгэсэн. “Дорнод телнет сүлжээ” ХХК нь байгаль орчны биологийн болон техникийн нөхөн сэргээлт, харилцаа холбооны агаарын болон газрын шилэн кабель суурилуулах, радио релейний станц болон үүрэн холбооны хөдөөгийн сайтуудын галын хамгаалах зурвас татах зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.

Уг ажлыг 2025 оны 09-р сарын 25 өдрөөс 2025 оны 10-р сарын 13 өдөр буюу нийт 19 өдөр, 30 га газар хагалах ажлыг хийсэн ба дугуйт трактор, өндөр хүчин чадал бүхий гидравлик анжис ашиглан чирэгчээр 15 см гүнтэй газрыг хагалсан.

Тухайн газрын хөрсийг үр дүнтэй суллаж сийрүүлэх зорилгоор хөрсийг суллаж сийрүүлсэний дараах нягтаршиж хатуурсан хөрсний ширхэгийг 5см\*5см\*5см-ээс бага хэмжээтэй байхаар буталсан. Зарим хэсэгт хөрс маш хатуу нягтаршил их байсан ба нягтаршиж хатуурсан хөрсний том хэмжээтэйг механик аргаар буталсан.

**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

зам	урт (км)	өргөн (м)	талбай (га)	1	2	3
0.2 - 0.41	0.44	6.8	0.2992	47°39'34.51"N 116°58'20.25"E	47°39'45.09"N 116°58'30.28"E	
0.3 - 0.5	0.92	5.3	0.4876	47°39'46.6"N 116°58'12.61"E	47°39'23.87"N 116°58'38.96"E	
0.0 - 0.1	0.87	5	0.435	47°39'25.95"N 116°57'06.41"E	47°39'08.8"N 116°57'39.42"E	
1.1.1 - 1.1.2	1.12	6.8	0.7616	47°45'24.38"N 117°05'27.99"E	47°44'51.08"N 117°05'49.7"E	
1.2.1 - 1.2.22	0.39	4.9	0.1911	47°45'27.44"N 117°06'02.93"E	47°45'27.04"N 117°06'20.59"E	
1.2.3 - 1.2.4	0.23	4.3	0.0989	47°45'27.55"N 117°06'12.18"E	47°45'24.5"N 117°06'22.28"E	
1.3.1 - 1.3.2	0.17	4.5	0.0765	47°44'33.53"N 117°06'40.83"E	47°44'38.89"N 117°06'42.99"E	
1.4.1 - 1.4.2	0.16	4.5	0.072	47°44'38.89"N 117°06'42.99"E	47°44'34.06"N 117°06'39.37"E	
2.1.1 - 2.1.2	0.2	4.5	0.09	47°43'29.37"N 117°05'06.88"E	47°43'35.65"N 117°05'06.96"E	
2.3.1 - 2.3.2 - 2.3.3	0.42	4.3	0.1806	47°43'20.24"N 117°06'19.35"E	47°43'15.47"N 117°06'14.18"E	47°43'12.67"N 117°06'04.11"E
2.2.1 - 2.2.2	0.24	3.6	0.0864	47°43'37.05"N 117°05'10.49"E	47°43'43.4"N 117°05'16.78"E	
2.3.3 - 2.3.4 - 2.3.5	0.28	5.4	0.1512	47°43'14.91"N 117°05'59.22"E	47°43'12.67"N 117°06'04.11"E	47°43'09.3"N 117°06'08.46"E
2.3.4 - 2.3.2	0.39	5.2	0.2028	47°43'09.3"N 117°06'08.46"E	47°43'15.47"N 117°06'14.18"E	
2.3.4 - 2.3.6	0.29	4.8	0.1392	47°43'18.48"N 117°06'09.98"E	47°43'09.3"N 117°06'08.46"E	
2.3.2 - 3.2.1	1.62	6.2	1.0044	47°43'09.3"N 117°06'08.46"E	47°42'24.5"N 117°05'28.3"E	
3.2.1 - 3.2.2	0.65	5.3	0.3445	47°41'24.28"N 117°00'48.73"E	47°41'25.14"N 117°01'19.39"E	
3.1.1 - 3.1.2 - 3.1.4 x2	7.92	4.9	3.8808	47°42'48.86"N 117°03'09.03"E	47°42'46.03"N 117°02'45.69"E	47°41'31.97"N 117°00'44.48"E
3.1.2 - 3.1.3	0.54	4.7	0.2538	47°42'46.03"N 117°02'45.69"E	47°43'00.16"N 117°03'00.22"E	
3.1.3 - 3.1.6	0.32	4.9	0.1568	47°43'03.96"N 117°03'10.45"E	47°43'00.16"N 117°03'00.22"E	
3.2.2 - 3.2.1	0.62	4.6	0.2852	47°42'42.85"N 117°05'15.92"E	47°42'24.5"N 117°05'28.3"E	
3.3.2 - 3.3.1	0.78	4	0.312	47°42'49.01"N 117°03'13.72"E	47°42'49.14"N 117°03'51.21"E	
3.4.1 - 3.4.2	1	4	0.4	47°42'59.42"N 117°05'59.04"E	47°42'59.42"N 117°05'59.04"E	
3.5.1 - 3.5.2	1.96	7	1.372	47°41'29.43"N 117°02'29.4"E	47°42'16.07"N 117°03'32.99"E	
3.5.3 - 3.5.1	1.3	4	0.52	47°42'16.07"N 117°03'32.98"E	47°41'36.14"N 117°03'13.02"E	
3.6.1 - 6.6.1	0.82	5	0.41	47°41'25.53"N 117°01'14.63"E	47°41'35.26"N 117°01'51.84"E	
504.152 hudag - 3.2.1	0.9	5.1	0.459	47°41'57.48"N 117°05'12.76"E	47°42'24.5"N 117°05'28.3"E	
5.1.1 - 5.1.2	0.23	4	0.092	47°40'42.95"N 117°02'46.59"E	47°40'50.2"N 117°02'50.12"E	
5.4.3 - 5.4.2 - 5.4.1	0.56	6.6	0.3696	47°40'25.8"N 117°03'27.33"E	47°40'30.03"N 117°03'34.92"E	47°40'37.03"N 117°03'47.71"E
6.1.1 - 6.1.2	0.72	5.2	0.3744	47°41'16.67"N 117°02'06.92"E	47°41'03.55"N 117°02'35.17"E	
6.2.1 - 6.2.2 - 6.2.3	1.7	6.9	1.173	47°41'15.72"N 117°02'11.8"E	47°40'44.77"N 117°01'28.11"E	
6.3.1 - 6.3.2	0.25	4.8	0.12	47°41'14.28"N 117°02'17.9"E	47°41'08.56"N 117°02'26.37"E	
6.4.1 - 6.4.2	0.59	6	0.354	47°40'55.22"N 117°01'20.51"E	47°41'00.65"N 117°01'57.6"E	47°40'58.39"N 117°01'47.92"E
6.5.1 - 6.5.2	0.11	5	0.055	47°40'53.36"N 117°01'40.05"E	47°40'56.52"N 117°01'37.51"E	
6.7.2 - 6.7.1	0.31	5.6	0.1736	47°41'25.08"N 117°01'25.29"E	47°41'25.89"N 117°01'40.02"E	
6.6.1 - 3.3.1	2.9	4.7	1.363	47°41'35.26"N 117°01'51.84"E	47°42'49.01"N 117°03'13.72"E	
7.1.1 - 7.1.2	0.23	5.6	0.1288	47°40'17.4"N 117°02'34.37"E	47°40'13.71"N 117°02'43.28"E	
7.2.1 - 7.2.2	0.39	6.8	0.2652	47°40'16.13"N 117°02'57.41"E	47°40'19.08"N 117°03'14.82"E	
7.3.11 - 7.3.2	0.38	4.6	0.1748	47°40'28.65"N 117°02'39.97"E	47°40'17.19"N 117°02'34.85"E	
7.5.3 - 7.5.2 - 7.5.2	0.39	4	0.156	47°40'12.11"N 117°01'38.37"E	47°40'07.49"N 117°01'50.02"E	47°40'07.18"N 117°01'54.71"E
7.4.2 - 7.4.1	0.32	6	0.192	47°40'18.19"N 117°01'56.03"E	47°40'09"N 117°01'50.88"E	
7.5.4 - 7.5.3	0.1	4	0.04	47°40'06.58"N 117°01'58.01"E	47°40'07.18"N 117°01'54.71"E	
7.4.2 - 7.4.3	0.22	3	0.066	47°40'09"N 117°01'50.88"E	47°40'02.23"N 117°01'52.48"E	
7.4.2 - 7.5.4	0.17	4	0.068	47°40'09"N 117°01'50.88"E	47°40'06.58"N 117°01'58.01"E	
7.5.4 - 7.5.5	0.17	4	0.068	47°40'06.58"N 117°01'58.01"E	47°40'06.92"N 117°02'05.75"E	
8.1.1 - 8.1.2	0.42	5.1	0.2142	47°40'41.09"N 117°00'54.86"E	47°40'28.29"N 117°00'58.96"E	
8.2.1 - 8.2.2	0.1	5	0.05	47°40'56.32"N 117°00'47.87"E	47°40'54.84"N 117°00'49.58"E	
8.3.1 - 8.3.2	0.19	4.5	0.0855	47°41'16.95"N 117°01'19.39"E	47°41'15.06"N 117°01'11.55"E	
8.4.1 - 8.4.2	0.12	4.6	0.0552	47°40'56.71"N 117°01'00.52"E	47°41'00.27"N 117°00'58.69"E	
9.1.1 - 9.1.2	0.18	4	0.072	47°40'43.96"N 117°00'29.98"E	47°40'39.01"N 117°00'34.32"E	
9.2.1 - 9.2.2	0.24	4.2	0.1008	47°40'30.3"N 117°00'38.73"E	47°40'24.09"N 117°00'33.08"E	
10.1.1 - 10.1.2	0.76	3.6	0.2736	47°39'21.63"N 117°00'38.48"E	47°39'09.22"N 117°00'10.66"E	
10.2.1 - 10.2.2 - 10.2.3	0.49	4.7	0.2303	47°39'23.05"N 117°00'48.05"E	47°39'18.92"N 117°00'57.13"E	47°39'14.88"N 117°01'08.24"E
10.3.1 - 10.3.2	0.31	5.5	0.1705	47°39'45.43"N 117°00'47.39"E	47°39'47.15"N 117°01'00.42"E	
10.4.1 - 10.4.2	0.17	4.3	0.0731	47°39'26.53"N 117°01'10.92"E	47°39'21.69"N 117°01'08.63"E	
10.5.1 - 10.5.2	0.2	4.6	0.092	47°39'50.08"N 117°01'01.48"E	47°39'54.43"N 117°01'08.23"E	
10.0.1 - 10.0.0	0.8	5	0.4	47°39'46.46"N 117°00'59.61"E	47°39'31.93"N 117°00'33.72"E	
10.6.3 - 10.6.2 - 10.6.1	1.29	8	1.032	47°39'27.8"N 117°00'29.54"E	47°39'09.5"N 117°00'02.95"E	47°39'00.06"N 116°59'45.87"E
10.1.1 - 10.7.1	0.76	3	0.228	47°39'07.86"N 117°00'19.38"E	47°39'21.63"N 117°00'38.48"E	
10.8.1 - 10.8.2 - 10.8.3	0.79	4	0.316	47°39'34.91"N 117°01'37.02"E	47°39'24.04"N 117°01'19.88"E	47°39'26.58"N 117°01'12.04"E
10.10.1 - 7.5.4	0.84	4	0.336			
12.1.1 - 12.1.2	0.34	4.1	0.1394	47°38'49.31"N 116°57'20.58"E	47°38'55.96"N 116°57'07.85"E	
12.2.1 - 12.2.2	0.14	4.7	0.0658	47°38'50.76"N 116°57'41.42"E	47°38'55.01"N 116°57'40.21"E	
13.1.1 - 13.1.2	1.24	6.2	0.7688	47°39'11.68"N 117°01'57.05"E	47°39'46.36"N 117°02'25.05"E	
15.1.1 - 15.1.2	0.21	5.1	0.1071	47°39'56.03"N 117°01'56.56"E	47°40'00.05"N 117°02'03.47"E	
15.3.1 - 15.3.2	0.12	5	0.06	47°39'58.67"N 117°02'37.5"E	47°39'55.16"N 117°02'33.8"E	
15.5.1 - 15.5.2 - 15.5.3	0.86	6.1	0.5246	47°39'04.23"N 117°02'51.08"E	47°39'19.06"N 117°02'54.24"E	47°39'09.66"N 117°03'05.29"E
15.5.5 - 15.5.21 - 15.5.2	0.52	5.6	0.2912	47°39'39.24"N 117°02'07.34"E	47°39'37.81"N 117°02'26.02"E	47°39'41.84"N 117°02'23.38"E
15.1.2 - 7.5.3	0.3	6	0.18	47°40'00.05"N 117°02'03.47"E	47°40'07.18"N 117°01'54.71"E	
21.1.1 - 21.1.2	0.57	5.8	0.3306	47°39'38.88"N 116°59'30.42"E	47°39'55.66"N 116°59'19.03"E	
21.2.1 - 21.2.2	0.42	5.4	0.2268	47°39'40.62"N 116°59'33.42"E	47°39'53.63"N 116°59'28.15"E	
21.3.1 - 21.3.21 - 21.3.1	1.17	5.1	0.5967	47°38'31.62"N 116°58'38.13"E	47°38'08.98"N 116°58'58.65"E	
21.4.1 - 21.4.2	0.67	5.4	0.3618	47°39'23.29"N 116°58'39.38"E	47°39'44.43"N 116°58'38.14"E	
21.5.1 - 21.5.2	0.89	5	0.445	47°39'19.93"N 116°58'58.97"E	47°39'40.89"N 116°59'14.64"E	
89.1.1 - 89.1.2 x2	3.6	5.9	2.124	47°40'09.5"N 116°59'31.71"E	47°41'00.67"N 117°00'12.38"E	
camp1 - camp2	1.75	6	1.05	47°38'07.67"N 117°00'33.76"E	47°38'43.07"N 116°59'28.47"E	
shop1 - shop2	0.17	6	0.102	47°39'42.09"N 116°59'08.75"E	47°39'46.99"N 116°59'12.29"E	
shop3 - shop4	0.22	6.2	0.1364	47°39'42.07"N 116°59'20.94"E	47°39'47.56"N 116°59'13.94"E	
hudag1 - hudag2	0.56	5.4	0.3024	47°39'00.62"N 116°59'56.74"E	47°38'42.68"N 116°59'55.71"E	
21.4.2 - 21.4.1.2 - 21.4.1	1.56	5	0.78	47°39'23.29"N 116°58'39.38"E	47°39'39.84"N 116°58'50.37"E	47°39'41.87"N 116°58'50.48"E
<b>НИЙТ</b>	<b>57.26</b>	<b>6.450819672</b>	<b>30.2258</b>			

**Хүснэгт-15. Нийт хагалсан замын координат, байршил**

### 2.5.3. Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж

XXI талбайн бохир ус цэвэршүүлэх байгууламж нь 2014 оны 10 сард ашиглалтад орсон, 2017 онд өргөтгөл хийсэн бөгөөд газар дор булсан 2 тасалгаатай шүүх системтэй (хоногт 250м<sup>3</sup> бохир ус шүүх хүчин чадалтай) тус бүр нь 25м<sup>3</sup>-ийн 10 септик-танк, лаг хаях нэг жижиг далангаас бүрдэнэ. Ахуйгаас гарч буй шингэн хаягдлыг ахуйн бохир хаях түр цэгт хүргэдэг байсан бол 2025 онд стандартын шаардлага хангасан ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийг ашиглалтанд оруулсан.

XXI талбайн ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн барилгын угсралтын ажлыг 2024.08.01-2025.07.31 хооронд “Престиж Инженеринг” ХХК гүйцэтгэсэн. Уг байгууламж нь “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS4943:2015” стандартад нийцүүлэн ахуйн бохир ус цэвэрлэх явдал юм.

Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж нь хоногт 80–120 м<sup>3</sup> хүчин чадалтай, механик болон мембран биореактор (MBR) бүхий биологийн цэвэрлэгээний аргаар цэвэрлэх байгууламж юм.




Зураг-4. Цэвэрлэх байгууламжийн технологийн схем

Механик цэвэрлэгээ : Ахуйн бохир усыг зориулалтын дагуу тоноглогдсон тээврийн хэрэгслээр зөөвөрлөн, цэвэрлэх байгууламжид зөөврийн байдлаар хүргэнэ. Бохир усыг цэвэрлэх байгууламжийн гадна байрлах бохир ус хүлээн авах худгаар дамжуулан системд оруулж, сараалжны сувагт хүлээн авна.

Бохир ус сараалжинд урсгалаар зөөгдөн орж, хог хаягдал, том ширхэглэгүүд сараалжид шүүгдэн тогтоно. Дараа нь бохир ус элс баригчийн өмнөх санд түр хадгалагдаж, өргөлтийн насосоор өргөгдөн элс баригч төхөөрөмжөөр дамжин, жигдрүүлэх санд орно.

Биологийн цэвэрлэгээ: Механик цэвэрлэгээнд орсон бохир ус жигдрүүлэх санд шилжиж, аэроб системийн өмнөх шатны урьдчилсан биологийн боловсруулалтад орно. Улмаар усны түвшинг хянах төхөөрөмжөөр дамжин өргөлтийн насосоор агааргүй (анаэроб) санд шахагдана. Анаэроб санд гидролиз, исэлдүүлэлт, нитрификаци, денитрификацийн биохимийн урвалууд явагдаж, органик бохирдлын агууламж болон аммонийн давс буурна. Дараагийн шатанд бохир ус агааржуулах (аэроб) биологийн санд орж, бичил биетнүүдийн нөлөөгөөр цаашид биологийн урвал явагдан, үлдэгдэл бохирдлууд задрана. Үүний дараа ус мембран биореактор (МБР)-т орж, ууссан болон хөвмөл бохирдлыг нарийн түвшинд шүүж, гүн цэвэрлэгээ хийгдэнэ.

Цэвэршсэн усыг хэт ягаан туяагаар (UV) халдваргүйжүүлж, өвчин үүсгэгч нян, бактери зэргийг устгасны дараа хүрээлэн буй орчинд нийлүүлнэ. Гарсан хаягдал ус нь MNS4943:2015 “Хаягдал ус. Ерөнхий шаардлага”, мөн MNS6734:2018 “Ахуйн хэрэглээний хаягдал усыг дахин ашиглах ерөнхий шаардлага” стандартын шаардлагыг хангасан байх ба цэвэрлэгдсэн усыг биоцөөрөмд нийлүүлэн хуримтлуулна. Биоцөөрөмд хуримтлагдсан ус нь нарны гэрэл, байгалийн агааржуулалт, ургамал, бичил биетний нөлөөгөөр нэмэлтээр шүүгдэн тунана. Энэ явцад үлдэгдэл органик бодис, шим тэжээлт элементүүд задлагдаж, усны байгалийн өөрийгөө цэвэрлэх процесс явагдана. Ингэснээр усны чанар тогтвортой хадгалагдаж, цаашид биоцөөрөмд ууршиж, хөрсөнд шингэхийн зэрэгцээ тодорхой нөхцөлд усыг дахин ашиглах боломжтой нөхцөл бүрдэнэ.



**Зураг-5. Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн схем**

**Ахуйн бохир цэвэрлэх байгууламжийн дотоод хяналтын лабораторийн тоног төхөөрөмж:**

Бохир ус цэвэрлэх байгууламжийн биологийн цэвэрлэгээ хэвийн явагдаж буюуг хянах зориулалтаар бичил биетүүдийн тоо толгойг тоолох ажиглах зориулалттай АЗЗ.1009 нь эмнэлгийн түвшний өндөр үзүүлэлттэй, лабораторийн түвшний LCD дижитал биологийн микроскопыг ашиглаж байна.

Цэвэрлэх байгууламжаар дамжуулан цэвэршүүлсэн бохир усыг байгаль орчинд нийлүүлэх болон дахин ашиглахдаа дараах стандартуудын шаардлагууд нийцүүлэх шаардлагатай байдаг ба үүнд:

- MNS4943:2015 – Хаягдал ус. Ерөнхий шаардлага
  - MNS4586:1998 – Хаягдал усны бохирдлын зөвшөөрөгдөх дээд хэмжээ (ЗДХ)
  - MNS6734:2018–Хаягдал усыг дахин ашиглах. Аж үйлдвэрийн хэрэгцээнд тавих шаардлага
  - MNS4093:2015-Хэрэглээнд тохиромжтой ахуйн зориулалттай дахин боловсруулсан ус
  - MNS900:2005 - Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага ба чанарын хяналт
- Эдгээр стандартын түвшинд цэвэрлэсэн бохир ус хүрч буюуг хянах зориулалтаар дараа багаж тоног төхөөрөмжүүдийг ашиглаж дотоод хяналтыг хөтөлбөрийг сард 4

удаа буюу долоо хоногт нэг удаа дээж авч шинжилгээ хийж байна. Тоног төхөөрөмжийн хувьд:

- Opera EC850 cond, TDS, temp шалгагч төхөөрөмж (усны цахилгаан дамжуулалт, нийт ууссан бодис, температур)
- Apera PC60-Z pH, cond, TDS, resistivity, ORP, temp шалгагч төхөөрөмж (усны хүчил шүлт, цахилгаан дамжуулалт, нийт ууссан бодис, эсэргүүцэл, исэлдэлт, температур)
- Apera SX751 pH, cond, TDS, resistivity, ORP, DO, temp шалгагч төхөөрөмж (усны хүчил шүлт, цахилгаан дамжуулалт, нийт ууссан бодис, эсэргүүцэл, исэлдэлт, усанд ууссан “O”-ийн хэмжээ, температур) гэх мэт

**Дүгнэлт:** Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж нь ашиглалтанд орсноор усны бохирдлыг бууруулж, хүрээлэн буй орчинд нийлүүлэх усны чанарыг стандартын шаардлагад нийцүүлэх нь хөрсний бохирдол болон хүрээлэн буй орчны сөрөг нөлөөллийг бууруулах чухал ач холбогдолтой юм.

#### **2.5.4. Байгаль хамгаалах чиглэлээр хийсэн сургалт, мэдээллийн ажил**

Дэлхийн усны өдрийг тохиолдуулан 2025 оны 02-р сарын 15 өдөр “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний XXI талбайн туслан гүйцэтгэгч ангиудын нийт 3 ангийн 22 ажилтан уг сургалтанд суусан бөгөөд компаний зүгээс байгаль орчны чиглэлээр хийж хэрэгжүүлэх болон хийж хэрэгжүүлсэн ажлууд, байгаль орчинд ээлтэй байдлаар нүхэн жорлонгуудыг шийдвэрлэх, усны тухай, түүний хэрэглээ, хог хаягдлын менежментийн талаар ойлголт мэдээлэл сургалт хийсэн. Уг сургалтыг дараах сэдвээр хийсэн.

- Усны тухай, түүний хэрэглээ, усны эх үүсвэрийг хамгаалсан тухай
- Хөрсний бохирдол, нүхэн жорлон түүний байгальд ээлтэй шийдэл
- Хог хаягдлын менежмент гэх мэт.

### 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний XXI талбайн техникийн нөхөн сэргээлтийг “Люкс даймонд” ХХК, биологийн нөхөн сэргээлтийг “Итгэлт төгөл” ХХК-нууд тус тус хийж гүйцэтгэсэн.

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Хэрэгжилт	Биелэлт
1	Техникийн нөхөн сэргээлт	Өрмийн шаврын хаягдлын санг саармагжуулах	1 ш	100%	“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-н XXI талбайд 1 ширхэг өрмийн шаврын сангийн техникийн нөхөн сэргээлт, 4 ширхэг үйлдвэрлэлийн шингэн хаягдлын сангийн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг “ЛЮКС ДАЙМОНД” ХХК хийж гүйцэтгэсэн. Техникийн нөхөн сэргээлт хийгдэж буй талбайг химийн бодис хийж саармагжуулах, хатаах, шар шороон хөрсөөр дүүргэх, тэгшлэх, засварлах, шимт хөрсөөр хучих ажлуудыг хийж гүйцэтгэсэн.
2		Үйлдвэрийн шингэн хаягдлын санг саармагжуулах	4 ш	100%	
3	Биологийн нөхөн сэргээлт	Хагалсан зам дээр нөхөн сэргээлт хийх	2 га	100%	Ашиглахгүй болсон замыг хагалж техникийн нөхөн сэргээлт хийсэн газар дээрх биологийн нөхөн сэргээлтийн 2.5 га газар хийсэн. Энэхүү ажлыг биологийн нөхөн сэргээлт мэргэжлийн байгууллага болох “Итгэлт төгөл” ХХК хийж гүйцэтгэсэн.
		XXI талбайн тохижилтын ажил	400 ш	100%	

### 3.1. Өрмийн шаврын хаягдлын сангийн техникийн нөхөн сэргээлтийн ажлын тайлан

2025 онд “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-н XXI талбайд 1 ширхэг өрмийн шаврын сангийн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг “ЛЮКС ДАЙМОНД” ХХК хийж гүйцэтгэсэн. Техникийн нөхөн сэргээлт хийгдэж буй санд химийн бодис хийж саармагжуулах, хөрсөөр дүүргэх, хэлбэржүүлэн овоолго хийх, шимт хөрсөөр хучих ажлууд юм.

№	Цооногийн дугаар	N	E
1	T21-36-P33	47 <sup>0</sup> 45'25.66"	117 <sup>0</sup> 5'27.40"

*Хүснэгт-16. Техникийн нөхөн сэргээлт хийсэн өрмийн сан*

2025 оны 07-р сарын 05-ний өдрөөс 2025 оны 08-р сарын 10 өдрийн хооронд техникийн нөхөн сэргээлт хийгдэх өрмийн шаврын сангийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

“Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага” MNS6200:2010 Монгол улсын стандарт, БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ыг удирдлага болгон ажилласан. Дээрх шаардлагад нийцүүлэн аргачлал боловсруулан, дараах үндсэн үе шаттай гүйцэтгэсэн. Үүнд:

Гүйцэтгэсэн ажил	
1	Өрмийн шингэн хаягдлын сангийн шингэний хэмжээг тодорхойлон бодисын орц хэмжээг тодорхойлсон
2	Хамгаалалтын тор шонг хураан авч ажилд бэлтгэсэн
3	Өрмийн сангийн шингэнийг соруулах/ шаардлагатай тохиолдолд
4	Өрмийн санд бодисоо хийж хутгах
5	Бодис хийсний дараа хатааж саармагжуулах
6	Хаталт удаан явагдаж байгаа ӨШХС-д дахин хутгалт хийх, шаардлагатай бол шингэнийг соруулах
7	Өрмийн сан бүрэн хатаж хатуу төлөв байдалд орсны дараа геомембрамаар өлгийдөх
8	Шар шороон хөрсөөр дүүргэлт хийх /В хөрс/ хучих, хэлбэржүүлэх /харьцангуй өндөр нь 50см ихгүй байх/
9	Үржил шимт хөрсөөр хучих /10см багагүй байх/
10	Цооногийн дугаар бүхий пайз байрлуулах /огноо, ТНС хийсэн компаний нэр/
11	Орчны цэвэрлэгээг хийж, гарсан хог хаягдлыг хог хаягдлын нэгдсэн цэгт тушаах /хог хаягдлын маягт бөглөх/

1. Өрмийн шаврын хаягдлын сангийн шингэн, шлагын хэмжээг тодорхойлон хатаах шингээх бодисын орц хэмжээг тогтоох. ӨШХС нь урт нь 20 м, өргөн нь

10 м, гүн нь 3 метрийн хэмжээтэй байх бөгөөд шингэн үл нэвчүүлэх материалаар доторлосон, мал, зэрлэг амьтан, шувуу унахаас сэргийлсэн торыг эргэн тойронд нь бэхэлж өгсөн байдаг.

Өрмийн шаврын хаягдал нь чулуулгийн үртэс, шавар, уснаас голлон үүссэн наалдамхай шингэн юм. Найрлагад нь хүнд металлын ион, шүлт, давс, органик бодисууд байдаг. Газрын тосны өрөмдлөгийн практикт угаалгын шингэнийг 1-2 жил өнжөөн байгалийн аргаар ууршуулах, эсвэл нэмэлт бодисын тусламжтай хоргүйжүүлж, саармагжуулан талстжуулж, маш сайн барьцалдсан хатуу биет болгон газарт дарж булах аргаар нөхөн сэргээлт хийдэг. Өрмийн шаврын сангийн техникийн нөхөн сэргээлтэд хөнгөн цагааны сульфат, магнийн хлорид гэсэн хоёр төрлийн бодисыг ашиглаж байна. Шингэний хаягдлын хэмжээнээс хамааран бодисын орцыг тогтоодог. Ихэнхдээ 100м<sup>3</sup> шингэн хаягдалд /зүмпэнд/ 100-250 кг саармагжуулагч бодис шаардагдана гэж тооцдог. Шингэн хаягдлын сангийн урт, өргөн, гүний хэмжээ, шингэн хаягдлын байдлыг хэмжиж үзээд 1000 кг бодис хийхээр тооцоологдсон. Өрмийн хаягдлын сангийн шингэн хаягдал, шламны гүнийг метрийн хэмжээтэй модоор хатган хэмжиж эзлэхүүнийг тогтоосон.

2. Шингэнийг соруулах. Газрын тосны өрөмдлөгийн практикт угаалгын шингэнийг 1-2 жил өнжөөн байгалийн аргаар ууршин, ус болон шингэн фракц нь дээр тунасан лаг шавар тостой барьцалдсан фракц нь доороо тунадаг. Иймээс усыг соруулж тунасан лаг шавар, тостой холилдсон хэсгийг саармагжуулахаар бодис хийн хутгадаг ингэснээр хорыг саармагжуулж хатууруулах үйл явцыг хурдасдаг.

3.Саармагжуулалт хийж экскаватороор хутгаж хатаах үе. Хатааж саармагжуулах бодисыг химийн бодис импортлох тусгай зөвшөөрөл бүхий “Эм Жи АР УРБАН” ХХК-иас худалдан авсан. Магнийн хлорид 500 кг, Хөнгөнцагааны сульфат 500 кг нийт 1000 кг бодисыг нөхөн сэргээлтэд зарцуулсан. Нүхэн дэх шингэн хаягдал, шламны хэмжээг тогтоосны дараа 1 м.куб шингэн хаягдалд 1.5-2 кг саармагжуулан хатаах бодис ноогдохоор тооцоолон орцыг тогтоосон. Жишээ нь: 20 м урт, 10 м өргөн, 3 м гүн шингэн хаягдалтай нүхний нийт шингэн хаягдал 460 м.куб болно. Тэгвэл энэхүү нүхэнд 920 кг бодис хийж хутгалт явуулна. Нэг нүхэнд 1000 хүртэл кг буюу 20 уут бодис хийж саармагжуулах, хатаах үйл ажиллагааг явуулж байв. Хатааж шингээх бодис хийх үйл явцыг захиалагч компанийн байгаль орчны ажилтнуудыг байлцуулан хяналт нь доор гүйцэтгэсэн. Саармагжуулах үйл явц буюу нүхэнд бодис хийх ажилд хөндлөнгийн хяналтаар орон нутгийн захиргаа,

иргэдийн төлөөлөл оролцсон. Энэхүү үйл ажиллагааг фото зургаар баримтжуулсан болно.

4. Геомембрамаар өлгийдөх: Шингэн хаягдлын сан бүрэн хатаж хатуу төлөв байдалд орсны дараа геомембрамаар өлгийдөх ажлыг гүйцэтгэсэн.

5. Шороон овоолгыг зөөж нүхэнд дүүргэлт хийх: Хатуу төлөв байдалд орсон шламтай нүхийг хулдаасан материалаар хулдан, шороогоор дүүргэн, 1 м<sup>2</sup> талбайд 7 тонн-оос багагүй даралт үзүүлэхийн тулд экскаватор, ковшоор гишгүүлэн нягтшуулж, хэлбэржүүлэх ажил хийгдсэн.

6. Үржил шимт хөрсөөр хучих: Хэлбэржүүлсэн шороон дээр тусгайлан хурааж овоолсон хүрэн хөрсөөр ойролцоогоор 10 см зузаантай жигд хучилт хийж биологийн нөхөн сэргээлт хийх бэлтгэл ажлыг гүйцэтгэсэн.

7. Хүлээлгэн өгөхөд бэлтгэх: Нөхөн сэргээлт хийж дууссан талбайг гар ажиллагаагаар засварлаж, хог хаягдлыг цэвэрлэн ажилласан. Дээрх бүхий л үе шатны ажил, ялангуяа хутгалт хийх, дарсан нүхийг тэгшлэн индүүдэх, хүрэн хөрсөөр хучих явцад талбайн инженер хяналт тавьж, аргачлалыг мөрдүүлэх, стандартад нийцүүлэн ажилласан.

### 3.2. Үйлдвэрлэлийн шингэн хаягдлын сангийн техникийн нөхөн сэргээлтийн ажлын тайлан

XXI талбайд үйлдвэрийн шингэн хаягдлын 4 ширхэг санд техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг “ЛЮКС ДАЙМОНД” ХХК 2025 оны 07-р сарын 04-нөөс 2025 оны 08-р сарын 14-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн. Техникийн нөхөн сэргээлт хийх үйлдвэрийн шингэн хаягдлын дугаар, координат нь:

№	Үйлдвэрийн шингэн хаягдлын сангийн нэр	N	E
1	ҮШХС-2022-21-5	47°37'0.87"	11702'0.15"
2	ҮШХС-2022-21-6	47°37'0.86"	117°2'1.97"
3	ҮШХС-2023-21-1	47°37'0.90"	117°2'7.34"
4	ҮШХС-2023-21-5	47°37'0.89"	117°2'11.50"

*Хүснэгт-16. Техникийн нөхөн сэргээлт хийсэн үйлдвэрийн шингэн хаягдлын сангууд*

“Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага” MNS6200:2010 Монгол улсын стандарт, БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ыг удирдлага болгон ажилласан. Үйлдвэрлэлийн шингэн хаягдлын сангийн техникийн нөхөн сэргээлтийг өрмийн шингэн хаягдлын сангийн техникийн нөхөн сэргээлтийн зарчмаар хийнэ.

### 3.3. Биологийн нөхөн сэргээлтийн ажлын тайлан

Тайлант жилд биологийн нөхөн сэргээлтийн сонгон шалгаруулалтанд газрын хэвлийн нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллага болох “Итгэлт төгөл” ХХК нь шалгарч гэрээ байгуулан “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний XXI талбайд 2.0 га газарт биологийн нөхөн сэргээлт хийсэн.

XXI талбайн олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагааны улмаас нөлөөлөлд өртсөн газруудад техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийсний дараа биологийн нөхөн сэргээлт хийхдээ дараах дарааллын дагуу хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- *Биологийн нөхөн сэргээлт хийх газрын нөхцөл байдал нь:* Газрын тосны олборлолтын үйл ажиллагааны нөлөөллөөр эвдэрсэн газар болох ашиглахгүй болсон зам талбай
- *Хөрс боловсруулалт:* Газрын тосны олборлолтын үйл ажиллагааны нөлөөллөөр эвдэрсэн газар болох ашиглахгүй болсон зам буюу 2.0 га талбайд ротор сийрүүлэгч ашиглан буталж сийрүүлж хөрсний боловсруулалтыг хийж гүйцэтгэсэн. Хөрсийг 18-20 см гүнд 3см\*3см\*3см хэмжээтэйгээр сийрүүлэлт
- *Ургамал тариалалт:* MNS5918:2023 буюу Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага стандартын дагуу уулын ойт хээрийн бүслүүрт хамаарах өвслөг ургамал хошоон, согоовор, хээрийн бүсийн өвслөг ургамал царгас, ёрхөг ургамлуудыг тариалсан. 2025 оны 06 сарын 27-29 хооронд биологийн нөхөн сэргээлтийн ургамал тариалалтыг хийж гүйцэтгэсэн. Олон наст ургамлыг энгийн мөрөөр буюу 1.5 см зайтай, хольж тариалсан. 2.0 га талбайд царгас 16 кг, ерхөг 15 кг, хошоонгор 12 кг, согоовор 25 кг үрийг холин тариалалт хийсэн ба 2.0 га талбайд 68 кг үрийг тариалсан. Тухайн үед хөрсний чийг ургамал тариалахад нэн тохиромжтой байсан.

#### Ургамлын ургалтын үйл явц:

- 2025 оны 07-р сарын 01-ноос 07-р сарын 30 өдөр хүртэл сарын хугацаанд хошоон, согоовор, ерхөг, царгасны үр нь соёолж, ургалтын хэмжээ нь 1-5 см хүрсэн байна. /Хавсралтаар зураг оруулав/
- 2025 оны 08-р сарын 03-ний өдрийн байдлаар 8-10 см хүрсэн байсан.

№	Ургамлын нэр	Биологийн онцлог	Тарих үрийн норм	Тариалсан үрийн норм	Гүн, см	Ургалтын хугацаа, хоног
1	Царгас	Буурцагтны овгийн, өвслөг, олон	14-16	16 кг	1-2	120-180

		наст ургамал царгас нь хөрсний үржил шимийг нөхөн сэргээхэд онцгой ач холбогдолтой таримал ю				
2	Ерхөг	Ганд тэсвэртэй, өвөлжих чадвартай, хүйтнийг даахдаа онцгой сайн бутлалтаас түрүүлэлт хүртэл маш хурдан ургадаг	13-15	15 кг	2.5-3.0	88-95
3	Хошоон	Хошоонгор нь 2 настай, буурцагт ургамал юм. Ган, хүйтэнд тэсвэртэй, тэжээлийн ач холбогдолтой ургамал юм. Ургах нөхцөл: Үр нь 2-5 хэмд ургаж эхлэх ба соёололт 10-18 хэмд эрчимтэй ургадаг. Намар салалтынхаа үе шатанд 5 найлзууртай 22-26 см өндөрт өвөлжилтөд шилжинэ.	10-12	12 кг	1.5-4.0	102-104
4	Согоовор	Согоовор нь бэлчээр, хадлангийн талбайг сайжруулж, таримал хадлан бий болгоход ашигладаг.	20-22	25 кг	2.5-5.0	95-111

**Хүснэгт-17. Биологийн нөхөн сэргээлтэнд ашигласан ургамлууд**

**Ногоон байгууламж болох мод тариалалт:**

Уг ажлыг биологийн нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллага болох “Итгэлт төгөл” ХХК хийж гүйцэтгэсэн. Олборлолтын үйл ажиллагаанд ашигладаг дотоод замын хоёр талаар нийт 400 ширхэг 2м өндөртэй 2 настай улиас модыг суулгасан.

- **Тариалах модны мэдээлэл:** Мод тариалалтанд хэрэглэх 2 метрийн өндөртэй 2 настай улиас модыг “Ургамлын далай” ХХК-ний мод үржүүлгийн газраас MNS 6140:2010 (Мод сөөгний тарьц. Техникийн шаардлага)-ын дагуу авч төслийн талбай руу тээвэрлэсэн.
- **Модны нүх бэлтгэх:** 2025 оны 06-р сарын 27-ны өдрүүдэд модны нүхийг 60 см диаметр, 40 см гүнтэйгээр ухаж, мод хоорондын зайг 2 метр байхаар тариалалтанд бэлтгэсэн.
- **Мод тариалалт:** 2025 оны 10-р сарын 31-ээс 11-р сарын 01 өдөр модны үндсийг жигд салаалуулан, ухаж бэлтгэсэн нүхний голд тэгш хэмтэй барьж, боловсруулсан хөрсөөр тогооны ирмэгээс доош 20 см хүртэл дүүргэв. Мод суулгасны дараагаар жигд сайн гишгэж хөрсийг дагтаршуулан тогоог дүүртэл усалгаа хийсэн.
- **Модны усалгаа:** Мод тариалахаас өмнө модны нүхийг дүүртэл усалж мод тариалсны дараагаар дахин усалгаа хийж гүйцэтгэсэн. 1 модыг 90-100 литр усаар усалсан бөгөөд нийт 400 модыг 40 тонн усаар усалсан. Намар болон хаврын цэнэг усалгаанд 1 модыг 60-80 литр усаар услах төлөвлөгөөтэй байна.

№	Модны нэр	Модны усалгааны хуваар				
		Хийгдсэн усалгаа		Төлөвлөгөөт усалгаа		
1	Улиас	Мод тариалахаас өмнө	Мод тариалсан дараа	Намрын цэнэг усалгаа	Хаврын цэнэг усалгаа	Улирлын усалгаа
		2025 оны 10 сар	2025 оны 10 сар	2025 оны 10 сар	2026 оны 5 сар	2026 оны 7 сар

Хүснэгт-18. Мод усалгааны хуваарь

#### 4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний XXI талбайн хувьд Матад, Халхгол сумын хилийн заагт төслийн талбайгаас баруун хойшоо 15-30 км орчим зайд байрлах тэгш талархаг газар бүхий “Мэнэнгийн цагаан хоолой” гэх газрын 10555.06 га талбайд дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө хэрэгжүүлэхээр болсон боловч уг газар нь Монгол улсын хилийн бүсийн хамгаалалтын зурваст байрлаж байгаа нь тус талбайд дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаатай холбоотой ажил явуулахад хил хамгаалах байгууллагын зүгээс байнгын зөвшөөрөл авах, дижитал камерийн дата мэдээллүүдийг авахад дахин зөвшөөрөл авах гэх мэт хүндрэлтэй байдал үүсч байсан тул тус талбайг шилжүүлэх саналыг Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Буйр нуур Мэнэнгийн талын сав газрын захиргаа, Буйр нуурын экосистемийг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх төвийн мэргэжилтэнгүүдтэй уулзалт хийж санал солилцож дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааг Буйр нуурын орчимд хэрэгжүүлэхээр тогтож 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг 2024 оны 10-р сарын 02-ны өдрийн 417 тоот албан тоотоор шилжүүлсэн.

2023-2027 оны Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр сонгон авсан талбайг өөрчлөх болсонтой холбоотойгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

XXI талбайн биологийн олон янз байдлын судалгаа, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөнд 2025 онд хийж хэрэгжүүлсэн ажлыг дараах байдлаар гүйцэтгэсэн. Үүнд:



Зураг-6. Дүйцүүлэн хамгаалахын тайлан

**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Хэрэгжилт
	1	2	3	4	6
<b>Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ 1</b>					
1	Сөрөг нөлөөллийг бууруулах	Цахилгаан хангадаг түгээх шугамын хүчдэл хуваарилах зангилаанд хэт авианы шувуу үргээгч байршуулах	Төслийн талбай	-	Энэхүү ажил нь 2023-2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан.
2		Ашиглахгүй болсон автозам болон тээврийн зам дагуу үүссэн олон салаа замыг хааж, хагалж сийрэгжүүлэх	Төслийн талбай	30 га	2025 оны БОМТөлөвлөгөөний сөрөг нөлөөллийн ажлын тайланд дэлгэрэнгүй тусгасан болно.
<b>Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ 2</b>					
3	Хяналт шалгалтын сүлжээ байгуулах, орон нутгийн удирдах байгууллага болон төсөл хэрэгжүүлэгч хоорондын харилцаа холбоог сайжруулах	Идэвхтэн байгаль хамгаалагч ажилуулах	Халхгол сумын Ялалт багийн иргэн	1	Орон нутгийн удирдлагуудын санал болон иргэний хүсэлтийг харгалзан Халхгол сумын Ялалт багийн иргэн Банзрагч овогтой Энхтайван-ийг идэвхтэн байгаль хамгаалагчаар сонгосон Дорнод аймгийн байгаль орчны газраас идэвхитэн байгаль хамгаалагчийн үнэмлэх гаргуулж, сар бүрийн цалин өгч ажиллуулж байна.
4		Идэвхтэн байгаль хамгаалагчийг чадавхижуулах сургалтад хамруулах	Идэвхтэн байгаль хамгаалагч	1	Сонгосон идэвхитэн байгаль хамгаалагчид байгаль орчны чиглэлээр сургалт өгч холбогдох ном, судалгааны мэдээ материалаар хангаж ажилласан болно.

**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

5		Дүйцүүлэн хамгаалах талбайд орон нутгийн болон отрын мал нутаглуулахгүй байхаас гадна хадлангийн газар олгохгүй байх сум орон нутагтай хамтран ажлаж гэрээ байгуулах	Дүйцүүлэн хамгаалах талбай	1	Дүйцүүлэн хамгаалах талбайг Буйр нуурт шилжүүлсэнтэй холбоотойгоор 2024 оны дүйцүүлэн хамгааллын тайлангийн хэрэгжилтэд тусгасны дагуу Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр Ялалт багийн засаг даргатай хамтран ажиллах санамж бичгийг 2025 онд дахин шинэчлэн байгуулсан.
<b>Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ 3</b>					
6	Буйр нуурын эрэг дагуух элсний нүүдлийг сааруулах	Техникийн тусламж, дэмжлэг үзүүлэх	Буйр нуур орчимд мод тариалж буй Халхгол сум дахь ойн ангид	1	Техникийн тусламж, дэмжлэг үзүүлэх гэсэн ажлын хүрээнд намрын мод тариалах, ажиллах хүчнийг цалинжуулахаар 5 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн.
			Дүйцүүлэн хамгаалах талбай, Дорнод аймгийн Халхгол сумын нут аг, Буйр нуур	5000 ш суулгац	2025 оны 09-р сарын 25 өдөр Халхгол сумын сум дундын ойн ангид 9000ш хайлаас мод, 1000ш аг модны суулгац хүлээлгэн өгсөн. Мөн ойн ангийн үйл ажиллагааг дэмжээд ойн ангиас 1000ш бургас суулгац авч тариалсан.
			5 га газрын хашаажуулах	2000м хашаа	2025 оны 10-р сарын 24 өдөр Халхгол сумын сум дундын ой ангид 5 га газрыг хашаажуулах хашаа хайс хүлээлгэн өгсөн.
<b>Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ 4</b>					
7	Биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх	Цаг хүндэрсэн байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон үед зэрлэг амьтдад өвс тэжээл, хужир шүү тавьж өгөх	Дүйцүүлэн хамгаалах талбайн хэмжээнд	2	Биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилгоор 500 боодол өвс авч нөөцлөв.
<b>Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ 5</b>					
8	Сургалт сурталчилгааны явуулах	Ялалт багийн сургуулийн сурагчдад нутгийн ургамлын үр	Ялалт багийн иргэд	1	2025 оны 09-р сарын 16-ны өдөр сургалт сурталчилгааны ажил явуулах замаар иргэдийн экологийн боловсролын түвшинг дээшлүүлэх

**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

	замаар иргэдийн экологийн боловсролын түвшинг дээшлүүлэх	түүх, Буйр нуур орчмын экосистемийг хамгаалах хээрийн аялал сургалт зохион байгуулах.			зорилгоор Ялалт багийн ЕБС-ын ахлах дунд ангийн сурагчдаас 15 хүүхэд, 2 багш, эцэг эхийн төлөөллийг хамруулан “Нутгийн ургамлын үр түүх, Буйр нуур орчмын экосистемийг хамгаалах” сэдвээр хээрийн аялал, сургалт зохион байгуулсан.
9		Буйр нуур орчимд мэдээлэл сурталчилгааны самбар байршуулах	Дүйцүүлэн хамгаалах талбайн хэмжээнд	2	2025 оны 10-р сарын 25 өдөр Буйр нуур орчмын экосистемийн мэдээлэл, жуулчны баазын мэдээллийг нэгтгэсэн 1ш, усны сан бүхий онцгой энгийн хамгаалалтын бүсийн мэдээллийн самбар 1ш байрлуулсан.
<b>Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ 6</b>					
10	Судалгаа, мониторингийн арга хэмжээ хэрэгжүүлэх	Буйр нуур орчимд ургамлан нөмрөг болон ховор ашигт ургамлын талаарх мониторинг хэрэгжүүлэх.	Дүйцүүлэн хамгаалах талбайн хэмжээнд	1	2025 оны 09-р сарын 17-ны өдөр “Буйр нуур орчимд ургамлан нөмрөг болон ховор ашигт ургамлын талаарх мониторинг хэрэгжүүлэх” зорилгоор Буйр нуур орчмын ургамлын мониторингийн судалгааг буйр нуурын зүүн эрэг дагуух 10 цэгт хийж гүйцэтгэсэн.

XXI талбайн биологийн олон янз байдлын судалгаа, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөнд хийж хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагаар болох “Цавчирын хөндий” ХХК-иар гүйцэтгүүлсэн.

2025 оны XXI талбайн дүйцүүлэн хамгааллын ажлыг эхлүүлэхийн өмнө 7 дугаар сард Дорнод аймгийн Байгаль орчны газрын Биологийн төрөл зүйл, ТХГН хариуцсан мэргэжилтэн О.Ганболдтой уулзаж дүйцүүлэн хамгааллын хүрээнд хийгдэх ажлуудыг танилцуулж аймгийн байгаль орчны газрын саналыг авч гүйцэтгэлийн ажлыг эхлүүлсэн.

Дорнод аймгийн Халхгол сумын Ялалт багийн 2025 оны 9 дүгээр сарын Иргэдийн Нийтийн Хурлын үеэр Тамсаг XXI дүгээр талбайн 2025 оны дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө, хэрэгжилтийн үйл явцын талаар танилцуулсан.

- XXI талбайн дүйцүүлэн хамгааллын үйл ажиллагааны хүрээнд орон нутгийн удирдлагуудын санал болон иргэний хүсэлтийг харгалзан Халхгол сумын Ялалт багийн иргэн Банзрагч овогтой Энхтайванийг идэвхитэн байгаль хамгаалагчаар сонгосон. Сонгосон идэвхитэн байгаль хамгаалагчид Дорнод аймгийн байгаль орчны газраас идэвхитэн байгаль хамгаалагчийн үнэмлэх гаргуулж, сар бүрийн төслийн санхүүжилтээр цалин өгч ажиллуулж байна.

- Сонгосон идэвхитэн байгаль хамгаалагчид

- 1) Монгол улсын байгаль орчны тухай хуулиудын хүрээнд эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх,
- 2) Идэвхитэн байгаль хамгаалагчийн хэрэглэх тоног төхөөрөмжүүд, тэдгээрийг хэрхэн ашиглах тухай (газрын зураг, луужин, байршил тогтоогч (GPS), автомат камерийн бүтэц, ажиллах зарчим, хэрэглэх заавар),
- 3) Ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, тайлагнал,
- 4) Бийологийн олон янз байдал ба судалгаа мониторинг,
- 5) Тамсаг XXI талбайн дүйцүүлэн хамгааллын талбай болох Буйр нуур, түүний орчны биологийн олон янз байдлын танилцуулга,
- 6) Идэвхитэн байгаль хамгаалагчийн эрх, үүрэг зэрэг сэдвүүдээр сургалт өгч холбогдох ном, судалгааны мэдээ материалаар хангаж ажилласан болно.

- Дүйцүүлэн хамгаалах талбайг Буйр нуурт шилжүүлсэнтэй холбоотойгоор 2024 оны дүйцүүлэн хамгааллын тайлангийн хэрэгжилтэд тусгасны дагуу Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр Ялалт багийн засаг даргатай хамтран ажиллах санамж бичгийг 2025 онд дахин шинэчлэн байгуулсан.

- Цаг хүндэрсэн байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон үед зэрлэг амьтдад өвс тэжээл тавих зорилгоор 2025 оны 10-р сард биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилгоор 500 боодол өвс авч нөөцлөв.
- 2025 оны 09-р сарын 16-17-ны өдрүүдэд Халхгол сумын сум дундын ойн ангийн Л.Үржиндорж даргатай уулзаж, ойн ангийн нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн 5 хэсэг талбайн өнөөгийн нөхцөл байдал, үйл ажиллагаатай танилцаж, “Буйр нуур орчимд мод тариалж буй Халх гол сум дахь ойн ангид техникийн тусламж үзүүлэх, тарьц суулгац нийлүүлэх” дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд 5 га талбайг хашаажуулах, бургас болон хайлаасны суулгац нийлүүлэх ажлын талаар санал солилцож, зөвшилцөлд хүрсэн. Үүний дагуу Буйр нуур орчимд мод тариалж буй Халхгол сум дахь ойн ангид 2025 оны 9-р сарын 22-25-ны өдөр 9000 ш хайлаас, 1000 ш агч мод, мөн ойн ангийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 1500 ш бургасны суулгац хүлээлгэн өгч суулгацыг суулгах хүн хүч ажиллуулахад дэмжлэг үзүүлсэн. Мөн 5 га суулгацын талбайг хашаалах хашааны материал, 5 га талбайг туулайнаас хамгаалах тор зэргийг нийлүүлсэн.
- Буйр нуурын эрэг орчимд өмнөх онд ургамлан нөмрөгийн мониторинг хэрэгжүүлсэн байршлуудын дагуу ургамлын мониторинг судалгааг хийж дүйцүүлэн хамгаалах ажлын тайланд тусгав.
- Ялалт багийн Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн хүүхдүүдэд байгаль хамгаалал, Буйр нуурын эрэг дагуух нутгийн ургамал, тэдгээрийн үрийг түүж бэлтгэх талаар сургалт явуулсан
- Буйр нуурын эрэг дагуу 2024 онд мэдээлэл сурталчилгааны самбарууд байршуулсан тул ажлыг давхардуулж хийхгүй байх, Буйр нуур руу ирж буй аялагчдад нуурын талаар мэдээлэл өгөх, олон салаа зам гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор нуурлуу салдаг олон замын уулзварт Буйр нуурын танилцуулга мэдээлэл, нуурын эрэг дагуух томоохон амралтын газруудын байршил, чиглэлийн талаарх мэдээлэл бүхий самбар, энгийн болон онцгой хамгаалалттай бүсийг анхааруулсан самбар, Байгаль орчноо хайрлан хамгаалаа бичигтэй самбар нийт 4 ш самбарыг байршуулав.

## **5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн 41.1-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна.” гэж заасан байдаг. Бүтээгдэхүүн хуваах гэрээт XXI талбайн хэмжээнд худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлс байршдаггүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олгох арга хэмжээний төлөвлөгөө гаргаж ажиллах шаардлагагүй болно.

## **6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Манай компани нь 2010-2011 онуудад Шинжлэх ухааны академи, Археологийн хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээ байгуулан гэрээт XIX, XXI талбайд хайгуул судалгааны ажлыг гүйцэтгүүлсэн.

Төсөл хэрэгжүүлж буй газар нь нам дор, тэгш хавтгай талбайд орших бөгөөд байгалийн өвөрмөц онцлогоос шалтгаалан БХГэрээт Тамсаг XXI талбайн ашиглалтын талбайд хийсэн хайгуулын явцад ямар нэгэн түүх соёлын дурсгал илрээгүй болно. Иймд түүх соёлын дурсгалыг авран хамгаалах төлөвлөгөө тусгайлан боловсруулах шаардлагагүй юм.

2025 оны үйл ажиллагааны турш ямар нэгэн түүх, соёлын өв олдоогүй болно.

7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжилт
1	Хүчтэй цасан болон шороон шуурга, салхи	Зарлан мэдээлэх, ажилчдын аюулгүй байдлыг хангах	XXI талбайн хэмжээнд холбогдох төрийн байгууллага	Дорнод аймгийн Ус цаг уур, Орчны шинжилгээний төв, мэдээлэл үйлчилгээний хэлтсээс анхааруулсан цаг агаарын мэдээллийг үндэслэн гадаа ажилладаг хэлтэс цех, туслан гүйцэтгэгч компаниудад анхааруулах, сануулах, байгаль цаг уурын онц ноцтой үзэгдлийн үед анхаарал болгоомжтой замын хөдөлгөөнд оролцох, ажил гүйцэтгэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдалд анхаарч ажиллах талаар цаг тухай бүрт нь мэдээлэн ажилладаг.
2	Объектын болон хээрийн түймэр	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, багаж төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг дагаж мөрдөх, зарлан мэдээлэх	XXI талбайн хэмжээнд холбогдох төрийн байгууллага	XXI талбайн хэмжээнд ТА-2 нэгдсэн байгууламж, бусад объектууд болон туслан гүйцэтгэгч ангиудаар дотоод хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулан, галын аюулгүй байдлыг сахин хамгаалах, ил задгай цахилгааны утас, гал түймрийн эрсдэлтэй хүчин зүйл байгаа эсэх гэх мэт зөрчил дутагдлыг цаг тухай бүрд нь арилгуулан ажиллаж байна. Нийт ажилчдад объектын болон хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, галын аюулгүй байдал, гал унтраах сургалтыг танхимын болон практик сургалтуудыг улирал тутам зохион байгуулаж ажиллаж байна.
3	Ган зуд	Ажиглалт хийх, зарлан мэдээлэх	XXI талбайн хэмжээнд холбогдох төрийн байгууллага	2025 оны зуны цаг агаарын байдал харьцангуй хуурайшилт багатай бороо хуртэй байсан ба ган болоогүй.
4	Зам тээврийн осол	Аюулгүй байдлын журам дүрмийг чанд сахих, хяналт тавих, зарлан мэдээлэх	XXI талбайн хэмжээнд холбогдох төрийн байгууллага	“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний үйл ажиллагаанд ашиглаж байгаа дотоод болон экспортын тээврийн компаниудын авто тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалтыг улирал бүр тогтмол хийж, бүрэн бус тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгуулан, байнгын хяналт тавьж ажилладаг.

**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

5	Халдварт өвчин	Ажиглалт хийх, зарлан мэдээлэх, ариутгад халдваргүйтгэл хийх	XXI талбайн хэмжээнд холбогдох төрийн байгууллага	XXI талбайн үйлдвэрлэлийн баазад ариутгал халдваргүйжүүлэлтийн ажил гүйцэтгэх ахуйн шавж, мэрэгчгүйтгэл, халдваргүйтгэлийн ажлыг “Улаанбаатар ариутгал” ХХК нь 2025 оны 06 сарын 17 өдөр, намрын ажлыг 2025 оны 09 сарын 06-10 өдрүүдэд зохион байгуулсан.
6	Химийн бодисын асгаралт	Аюулгүй ажиллагааны журам, дүрмийг чанд сахин мөрдөх, зарлан мэдээлэх	XXI талбайн хэмжээнд холбогдох төрийн байгууллага	“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний XXI талбайд “Химийн бодисын болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө”-г Зүүн бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газраар шинэчлэн батлуулж мөрдлөг болгон ажиллаж байна. ТА-2 нэгдсэн байгууламж дээр хэрэглэгдэг химийн бодис ашигладаг ажилчдад сургалт орсон. Мөн химийн бодисын агуулахад нэмэлт ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

## 7.1. Хүчтэй цасан болон шороон шуурга

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний ХХI талбайд 2025 оны байдлаар: Дорнод аймгийн Ус цаг уур, Орчны шинжилгээний төв, мэдээлэл үйлчилгээний хэлтсээс анхааруулсан цаг агаарын мэдээллийг үндэслэн гадаа ажилладаг хэлтэс нэгж, туслан гүйцэтгэгч компаниудад анхааруулах, сануулах, байгаль цаг уурын онц ноцтой үзэгдлийн үед анхаарал болгоомжтой замын хөдөлгөөнд оролцох, ажил гүйцэтгэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдалд анхаарч ажиллах талаар заавар зөвлөгөө өгч ажилласан.

- 2025 оны 02-р сарын 22-ний өдөр цас орж, цасан шуурга шуурч, зам талбайд халтиргаа гулгаа үүсэж, үзэгдэх орчин хязгаарлагдал болохыг анхааруулан, замын хөдөлгөөнд оролцохдоо анхаарал болгоомжтой явах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг экспортын тээврийн ангиуд болон дотоод тээврийн ангиудад утсаар сануулан зааварчилгаа өгч ажилласан.
- 2025 оны 05-р сарын 28 өдөр нийт нутгаар халж +30...+35 градус дулаан, салхи баруун өмнөөс секундэд 8-13 метр хүрч ширүүсэх тул түймрийн болзошгүй эрсдлээс сэрэмжлэх, галын аюулгүй байдлыг сахихыг бүх туслан гүйцэтгэгч ангиудад утсаар сануулан анхааруулж ажилласан.

дорнод аймгийн уцшоштөв, мэдээлэл үйлчилгээний хэлтэс  
ЦАГ АГААРЫН АНХААРУУЛАХ МЭДЭЭ



**МАЛЧИД, ТЭЭВЭРЧИД  
ИРГЭДИЙН АНХААРАЛД**

**24-НД ИХЭНХ НУТГААР, 25-НД НУТГИЙН  
ЗҮҮН ХЭСГЭЭР ЦАС ОРЖ, ЦАСАН  
ШУУРГА ШУУРЧ, ЗАМ, ДАВАА, ГҮВЭЭНД  
ХАЛТИРГАА ГУЛГАА ҮҮСЭЖ, ҮЗЭГДЭХ  
ОРЧИН ХЯЗГААРЛАГДАХЫГ ОНЦГОЙЛОН  
АНХААРУУЛЖ БАЙНА.**

Мэдээ гаргасан огноо: 2025.02.22



**МАЛЧИД, ИРГЭД, ТЭЭВЭРЧИЙН  
АНХААРАЛД**

Дорнод аймгийн нутгаар:

3-наас 4-нд шилжих шөнө ихэнх нутгаар, 4-нд Матад, Халхголын сав нутгаар нойтон цас, цас орж, салхи баруун хойноос секундэд 9-14 метр, зарим нутгаар секундэд 16-18 метр хүрч ширүүсэж, цасан шуурга шуурч, хүйтэрч, үзэгдэх орчин хязгаарлагдаж, зам, даваа гүвээнд халтиргаа гулгаа, мөстөлт үүсэхийг онцгойлон анхааруулж байна.

ДОРНОД УЦШОШТ  
2025.04.03



**МАЛЧИД, ИРГЭД, ТЭЭВЭРЧИЙН  
АНХААРАЛД**

Дорнод аймгийн нутгаар:

Өнөөдөр өдөртөө нийт нутгаар халж +30...+35 градус дулаан, салхи баруун өмнөөс секундэд 8-13 метр, нутгийн хойд хагаст секундэд 18-20 метр, зарим нутгаар секундэд 24 метр хүрч ширүүсэх тул ард иргэд та бүхнийг түймрийн болзошгүй эрсдэлээс сэрэмжтэй байж аюулгүй байдлын дүрмийг чанд баримтлахыг зөвлөж байна.

ДОРНОД УЦШОШТ  
2025.05.28



**МАЛЧИД, ИРГЭД, ТЭЭВЭРЧИЙН  
АНХААРАЛД**

Дорнод аймгийн нутгаар:

Маргааш өдөртөө зарим нутгаар ялимгүй хур тунадас орж, салхи баруун хойноос секундэд 8-13 метр, зарим нутгаар секундэд 16-18 метр хүрч ширүүсэж, нийт нутгаар хүйтрэхийг онцгойлон анхааруулж байна.

ДОРНОД УЦШОШТ  
2025.10.24

Зураг-7. Цаг агаарын онц үзэгдэл болох тухай мэдээлэл

## **7.2. Объект болон хээрийн түймэр**

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний XXI талбай нь 2025 онд галын аюулгүй байдлын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Галын аюулгүй байдлын систем: Барилга байгууламжуудын галын аюулгүй байдлын систем, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг улирал тутам газар дээр нь шалгаж, бэлэн байдлыг хангах буюу хэвийн ажиллагаатай байгаа нь баталгаажуулдаг. Ажиллахгүй байгаа тоног төхөөрөмж тухай бүрд нь солих, галын хоруудыг ашиглалтын карт дээр нь тэмдэглэл хөтлөн ажилладаг. 2025 онд галын аюулгүй байдлын шалгалтыг нийт 4 удаа шалган ажилласан байна. /Галын хор болон цахилгааны аюул/

- Хяналт шалгалтын ажлын хүрээнд: 2025 онд XXI талбайн хэмжээнд ТА-2 нэгдсэн байгууламж, бусад объектууд болон туслан гүйцэтгэгч ангиудаар дотоод хяналт шалгалтыг нийт 4 удаа зохион байгуулан, галын аюулгүй байдал, ил задгай цахилгааны утас болон бусад галын эрсдэлтэй зөрчил дутагдлыг цаг тухай бүрд нь арилгуулан ажилласан.



***Зураг-8. Дотоод хяналт шалгалтыг үеэр***



***Зураг-9. Дотоод хяналт шалгалтыг үеэр***

**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

- Галын аюулгүй байдлын сургалт: Нийт ажилчдад объектын болон хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, галын аюулгүй байдал, гал унтраах сургалтыг танхимын болон практик сургалтуудыг улирал тутам зохион байгуулан ажиллаж байна. 2025 оны 06 сарын 14 өдөр практик сургалтыг зохион байгуулсан бол танхимийн сургалтыг 2025 оны 05 сарын 05 өдөр зохион байгуулсан.



**Зураг-10. Галын аюулгүй байдлын танхимын сургалт**



**Зураг-11. Галын аюулгүй байдлын практик сургалт**



**Зураг-12. Галын аюулгүй байдлын практик сургалт**

### **7.3. Ган болон зуд**

2025 онд зуны цаг агаарын байдал харьцангуй хуурайшилт багатай бороо хуртай байсан ба ган болоогүй.

### **7.4. Зам тээврийн осол**

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний XXI талбайн үйл ажиллагаанд ХАБЭАБО хэлтсээс дотоод болон экспортын тээврийн хэрэгслүүдэд улирал тутам, дотоод хяналт шалгалт хийдэг. Дотоод хяналт шалгалтыг дараах байдлаар шалган ажиллаж байна. Үүнд:

- Сургалт: XXI талбайн экспорт болон дотоод тээвэрт ажилладаг жолооч нарт аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулсан.



*Зураг-13. Жолооч нарын сургалт*

- GPS систем /аяллын маршрут хянах: Экспортын тээврийн хэрэгслүүдэд GPS систем суурилуулан үйлдвэрлэлийн баазаас очих цэг хүртэл маршрутыг хянах ба зөвхөн зөвшөөрөгдсөн замаар жолоодлого хийж, хурдны хязгаарыг барин жолоодлого хийснээр авто тээврийн аливаа осол эрсдлээс урьдчилан сэргийлэх юм. Мөн дотоод хяналт шалгалтаар GPS системийг бүрэн ажиллагаатай эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.



*Зураг-14. Экспортын тээврийн дотоод хяналт шалгалт*

- Хурдны хязгаар: XXI талбайд хурдны хязгаарыг дээд тал нь 60км/цаг хурдтай явах, төв зам болон дөрвөн замын уулзвар дээр 20км/цаг хурдтай явах хүртэл хязгаарлалт тогтоосон. Хурдын хязгаарыг мөрдөж буйг хянахдаа санамсаргүй байдлаар хяналт шалгалтыг хийдэг ба гарсан зөрчлийг тухай бүрд нь анхааруулан ажилладаг.

### **7.5. Халдварт өвчин**

Ариутгал халдваргүйтгэлийн ажил: XXI талбайн үйлдвэрлэлийн баазад “Улаанбаатар ариутгал” ХХК /9011339113/ мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх АҮХ-17/22/3594 тоот тусгай зөвшөөрөлтэйгээр ахуйн хортон шавьж, мэрэгч устгал, халдваргүйтгэлийн үйлчилгээний чиглэлээр үйлчилгээ үзүүлсэн.

Ариутгал халдваргүйтгэл, шавжгүйтгэл, мэрэгчгүйтгэлийн хаврын ажлыг 2025 оны 06 сарын 25-26 өдөр, намрын ажлыг 2024 оны 09 сарын 14 өдрүүдэд зохион байгуулсан.

Халдваргүйтгэлд: хлорын шохой 1м<sup>2</sup> 300гр шохойг 2см зузаантай нунтаг хэлбэрээр хэрэглэсэн, ДП-2Т 0.02%, тунгаар гадна халдваргүйтгэлд тус тус найруулж уусмал бэлтгэн усан буу, мотор, компрессор ашиглан шүршиж хэрэглэсэн.

Шавжгүйтгэлд: гадна талбайд карате /лямбадацигалотрин/ бодисыг гадна орчинд, шавж авгалдайн устгалд, жилью, дихлофос гель, ФАС зэргийг дотор орчинд тус шавжгүйтгэлд хэрэглэсэн.

Мэрэгчгүйтгэлд: Өгөөш (бромадиолон 0.5%-аар 30 кг) открьс, ЭФА наалдуулагчийг хавсран хэрэглэсэн. Уг ажлыг гүйцэтгэхдээ явах замын дагуу болон нүх сүвэнд хийж 1 метрийн зайтай тавьсан.

Халдваргүйтгэл, мэрэгчгүйтгэл, шавжгүйтгэл хийх ажлыг доорх байгууламж бүхий газруудад хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Нийт оффисын өрөөнүүд /37 оффис/
- Ажилчдын орон сууц /57 сууц/, Агуулахын өрөө
- ТА-2 нэгдсэн байгууламжийн оффис, хурлын өрөө, бичиг хэргийн өрөө
- ТА-2 оффисын эмэгтэй бие засах газар, эрэгтэй бие засах газар
- Лабораторийн өрөө
- Шахалтын жижүүрийн өрөө
- Бохир усны жижүүрийн өрөө
- Ачилтын жижүүрийн өрөө, Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн өрөө
- Эмнэлэг
- Кемпийн хогийн түр цэг, төвлөрсөн цэг

- Хүнсний агуулах, монгол болон хятад ажиллагсдын хоолны заал болон хоол үйлдвэрлэлийн танхимд мэрэгчгүйтгэл, шавжгүйтгэл, гадна талбайд хөрсийг суллаж хлоржуулан ариутгах арга хэмжээг авч ажилласан.

**7.6.Химийн бодисын асгаралт**

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний XXI талбайд “Химийн бодисын болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө”-г Зүүн бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын Улсын хяналтын байцаагч, ахмад Н.Хатанбүүвэйгээр хянуулан 2025 оны 04 сарын 11 өдөр шинэчлэн батлуулан мөрдлөг болгон ажиллаж байна.

XXI талбай дээр “Химийн хорт болон аюултай бодисын ашиглах, хадгалах, тээвэрлэх үеийн аюулгүй ажиллагаа”-ны дотоод дүрмийг боловсруулан Дорнод аймгийн Байгаль орчны газрын улсын байцаагч Билгүүнзаяаар батлуулан мөрдлөг болгон ажиллаж байна.

- ТА-2 нэгдсэн байгууламж болон бусад хэсэгт химийн бодистой харьцан ажилладаг 9 ажилтанд 2025 оны 04-р сарын 23 өдөр сургалт зохион байгуулан ажилласан. Сургалтаар химийн бодисын ерөнхий ойлголт, ТА-2 нэгдсэн байгууламж дээр хэрэглэдэг химийн бодисууд, хор аюулын лавлах мэдээлэл /ХАЛМ/ гэх мэт сэдвүүдийн хүрээнд хийгдсэн.



**СУРГАЛТЫН БҮРТГЭЛ**


№	Овог нэр	Албан тушаал	Сургалтын сэдэв	Гарын үсэг	Сургалт явуулсан хүний гарын үсэг
1	Дорнод	Оператор	Химийн бодисын талаарх ерөнхий мэдээлэл	[Signature]	[Signature]
2	Дорнод	Оператор		[Signature]	
3	Дорнод	Оператор		[Signature]	
4	Б.Батбаяр	Оператор		[Signature]	
5	З.Батбаяр	Оператор		[Signature]	
6	Б.Батбаяр	Оператор		[Signature]	
7	А.Батбаяр	Оператор		[Signature]	
8	У.Батбаяр	Оператор		[Signature]	
9	А.Батбаяр	Оператор		[Signature]	
10	А.Батбаяр	Оператор		[Signature]	

**Зураг-15. Химийн бодисын сургалтын үеэр**

**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

- XXI талбайн ТА-2 нэгдсэн байгууламж дээр хэрэглэдэг химийн бодисын агуулахыг 2023 онд ашиглалтанд оруулсан ба 2025 онуудад нэмэлт шаардлагатай хэд хэдэн ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Химийн бодис арьс салстанд хүрсэн, нүдэнд орсон нөхцөлд хугацаа алдалгүй угаах тосгуур байршуулсан.



**Зураг-16. Химийн бодисын агуулахад байршуулсан тосгуур угаалтуур**

- Химийн бодис асгарсан нөхцөлд тусгаарлах материал, хэрэглэгдэхүүнийг агуулахад байршуулсан. Химийн бодисын шинж чанараас хамаараад савтай элс, арчих материалуудыг байршуулсан.



**Зураг-17. Химийн бодис асгарсан тохиолдолд элс болон арчих материалууд байршуулсан.**

**8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт
1	Ахуй	Дарж булах	XXI талбай, нэгдсэн хогны цэг	XXI талбайн хатуу хог хаягдлын төвлөрсөн цэгт 2025 онд ахуйн болон үйлдвэрлэлийн хатуу хог хаягдлыг тээвэрлэх, устгах, булшлах үйл ажиллагааг мэргэжлийн байгууллага болох “Экоцикл” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.
2	Үйлдвэрлэл	Ангилан ялгах	XXI талбай, нэгдсэн хогны цэг	
		Шатаах		
		Дахин ашиглагдах хог хаягдлыг тээвэрлэх		
3	Аюултай	Шуудай, хуванцар болоод төмөр савыг овор хэмжээг багасган хадгалах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх	XXI талбай, нэгдсэн хогны цэг	Аюултай хог хаягдал устгах эрхтэй “Түмэн эгшиг” ХХК-д 2025 оны 4, 11 дүгээр саруудад үйл ажиллагаанаас гарсан аюултай хог хаягдлыг шилжүүлээд байна.

### 8.1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хог хаягдлын менежментийн зорилго нь газрын тос олборлох төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн хог хаягдлыг дахин ашиглах боломжоор нь эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, боловсруулах цэгт хүргэх, дахин ашиглах боломжгүй хог хаягдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргэж, хог хаягдлыг хамгийн бага гаргах, байгаль орчинд тархахаас сэргийлэх, хоргүй, аюулгүй хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаа юм.

XXI талбайн хог хаягдлын төвлөрсөн цэг нь 2012 онд ашиглалтанд орсон бөгөөд хатуу хог хаягдлыг ангилан ялгаж төрөлжүүлэх, хадгалах зориулалт бүхий 100 метрийн урттай, 80 метрийн өргөн төмөр хийц бүхий хашаатай байгууламж юм. Тус хашаа нь 18 тасалгаатай, тасалгаа бүр нь хог хаягдлыг төрөлжүүлэн буулгах хаягтай, хөрс бохирдохоос сэргийлсэн бетон хучилттай.

Ахуйн ангилан ялгах боломжгүй хог хаягдлыг ландфилийн нүхэнд хийн булшилж байна. Одоогийн ашиглаж буй 1350м<sup>3</sup> эзэлхүүн бүхий ландфиль нүхний эзэлхүүний 35 хувийг ашиглаад байна.

Төв кемпээс ахуйн хог хаягдал, туслан гүйцэтгэгч ангиудаас үйлдвэрлэлийн хатуу хог хаягдлыг хүлээн авч тухай бүр нэр төрөл, шинж чанараар ангилан ялгалт хийж, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг савлаж нягтаршуулан хадгалж хоёрдогч түүхий эдийн цэгт хүргэх, ашиглах боломжгүйг шатаах, ландфиллын нүхэнд булах зэргээр устгаж байна.

Уг байгууламж дээр дараах байдлаар ангилан ялгалт хийж хадгалдаг.

№	Хог хаягдлын төрөл, ангилан ялгалт	
1	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гарсан хаягдал	Төмөр, резин, трос, хуванцар, дугуй, мод- модон материал, шил, барилгын материал, цаасан хайрцаг
2	Ахуйн үйл ажиллагаанаас гарсан хаягдал	Хоолны үлдэгдэл, шил лааз, хуванцар, цаас, цаасан хайрцаг, хуучин хувцас, гутал, ахуйн хэрэглээний хог хаягдал
3	Аюултай хог хаягдал	Химийн бодисын сав баглаа боодлыг тусгайлан байршуулсан контейнерт хураан хадгалдаг.

*Хүснэгт-19. Хог хаягдлын ангилан ялгалтын төрөл*

### 8.2. Үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдал

XXI талбайн хатуу хог хаягдлын төвлөрсөн цэгт 2025 онд хуримтлагдсан ахуйн болон үйлдвэрлэлийн хатуу хог хаягдлыг тээвэрлэх, устгах, булшлах үйл ажиллагааг хог хаягдлын мэргэжлийн байгууллага болох “ЭКОЦИКЛ” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Уг ажлын хүрээнд нь дараах ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн.

## XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

### Дахин ашиглах

- Дотоод хэрэгцээнд ашиглах боломжтой хог хаягдал

### Шилжүүлэх

- Аюултай хог хаягдал, хуванцар сав, шил лааз, төмөр гэх мэт

### Булшлах

- Ашиглах боломжгүй хог хаягдал

“Петрочайна Дачин тамсаг” ХХК-н XXI талбай болон туслан гүйцэтгэгч компаниуд тайланд онд нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлсэн хог хаягдлын хэмжээг доор хүснэгтээр харуулав.

№	Хог хаягдлын нэр төрөл	Хэмжээ тн	Устгах аргачлал	Гүйцэтгэл
<b>Энгийн хог хаягдал</b>				
1	Төмөр, трос	10	Төмөр авах цэгт хүргэх	2025 оны 10 дугаар сард Багануур дүүрэг дэх төмөрлөгийн үйлдвэрийн төмрийн хаягдал авах цэгт 10 тн төмөр хүргэсэн.
2	Хуванцар, шил, лааз	2.8	Хоёрдогч түүхий эд авах цэгт хүргэх	11 дүгээр сард 0.8 тн хуванцар хаягдлыг хүргэсэн.
3	Цаас, цаасан хайрцаг	7.7	Шатааж устгах	10 дугаар сарын 20-ий өдрийн байдлаар нийт 7.7 тн цаасны хаягдлыг төмөр зууханд шатааж устгасан байна.
4	Мод, модон материал	1.7	Шатааж устгах	Зууханд шатааж устгасан байна.
5	Арчих материал	1.25	Шатааж устгах	Зууханд шатааж устгасан байна.
6	Ангилгдахгүй ахуйн хог	91.8	Ландфиль нүхэнд булах	Ажилчдын сууц, оффис, гал тогооны хаягдал болох ангилгдахгүй хаягдлыг ландфиль нүхэнд хийж булшилж байна.
<b>Нийт</b>		<b>115.25 тн</b>	<b>Үлдэгдэл</b>	<b>115.25 тн</b>
<b>Аюултай хог хаягдал</b>				
1	Цементний уут	30	Мэргэжлийн байгууллагад шилжүүлэх	Тээвэрлэх, устгах эрх бүхий мэргэжлийн байгуулага болох “Түмэн Эгшиг” ХХК-д шилжүүлсэн.
2	Эрээн хучлага	2		
3	Галын хор	0.3		
4	Хуванцар торх	0.5		
5	Хаягдал тос	0		
6	Ремень, дугуй	40		
<b>Нийт</b>		<b>72.8 тн</b>		Хуримтлагдаж байна

*Хүснэгт-20.2025 онд хог хаягдлын ангилан ялгалт, шилжүүлсэн, устгасан тоо хэмжээ*

Төмөр, тросны хаягдал: Эвдэрсэн хашаа, агаар шүүрний төмөр, бүслүүр төмөр, ор, яндан, нимгэн төмрийн хаягдал гэх мэт төмрийн хаягдал 10 тн орчим хуримтлагдаж байна. Төмрийн хаягдлыг 2025.10.13 өдөр 10 тн төмрийг хоёрдогч түүхий эд авах цэгт хүргэсэн.

Хуванцар, шил, лааз: Ахуйн болон бусад хогтой холилдон ирж буй хуванцар, шил, лаазыг ялган авч 1 тоннын шуудайнд хийн байршуулж байна. Дорнод аймаг дахь

хоёрдогч түүхий эд авах цэг /Хэрлэн сум, 1-р баг, Нуурын 18-1803 тоот/-ийн шаардлагын дагуу 2,8 тн хуванцарын хаягдлыг шахаж овор хэмжээг багасгалгүйгээр хүргэсэн.

Цаас, цаасан хайрцаг: Ангиудаас ирж буй цаасан хаягдлыг шатаах зуухны дэргэд буулгадаг. Төв кемпээс ирж буй хог хаягдлаас цаас, цаасан хайрцаг, мод зэргийг ялган авч шатаах зуухруу зөөвөрлөн өдөр бүр шатааж устгаж байна. Өдөрт 2м<sup>3</sup> цаасан хаягдлыг зориулалтын зууханд шатааж устгаж байна.

Ахуйн хог хаягдал: Ажилчдын суурингийн сууц, гал тогоо, ахуйн хэрэглээнээс үүсч буй ангилан ялгах боломжгүй хаягдлыг ландфилийн нүхний дэргэд буулгуулж цаас, төмөр, хуванцар, шил, лаазыг зэргийг ялган авч үлдсэн хаягдлыг нүхэнд хийн булшилж байна. Хаягдлын овор хэмжээ нүхний дээд ирмэгт ирэх үед шороогоор дарж булж байна. Одоогийн ашиглаж буй нүх нь дахин 1 жил ашиглаад бүрэн дүүрэх төлөвтэй байгаа бөгөөд бүрэн дүүрсний дараа техник ашиглан шороогоор дарж, шимт хөрсөөр хучна.

Аюултай хог хаягдал: Эрээн хучлага, ремен, дугуй, химийн бодисын сав, шуудай, торхтой тос, галын хор зэргийг тогтсон тасалгаа бүрт буулгуулан цэгцтэй хадгалж байна. Аюултай хог хаягдлыг аюултай хог хаягдал устгах эрх бүхий байгууллагад шилжүүлдэг.

### 8.3. Аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад шилжүүлсэн

2025 онд аюултай хог хаягдлыг тээвэрлэх, устгах үйл ажиллагаа явуулах сонгон шалгаруулалтанд аюултай хог хаягдлыг устгах тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага болох “Түмэн эгшиг” ХХК-тай хамтран ажилласан. 2025 оны 4 болон 11 дүгээр сард дараах хог хаягдлыг шилжүүлсэн.

№	Аюултай хог хаягдлын нэр	Аюулын ангилал	Хэмжээ	Нэгж, (кг, л)	Аюултай хог хаягдлын код
4 дүгээр сард					
1	Ремень, дугуй	Х	50	м <sup>3</sup>	200115*
2	Химийн бодисын хуванцар сав	Х	200л 65	ш	150109*
3	Химийн бодисын хуванцар сав	Х	25л 171	ш	150109*
4	Тусгаарлагч материал /эрээн хучлага/	Х	70	м <sup>3</sup>	150109*
11 дүгээр сард					
1	Цементний уут	Х	40	тн	150109*
2	Эрээн хучлага	Х	3	тн	150109*
3	Галын хор	Х	85	ш	160501*
4	Хуванцар торх	Х	200л 17	ш	150109*
5	Хаягдал тос	Х	0	л	
6	Ремень, дугуй	Х	40	тн	200115*

*Хүснэгт-21. 2025 онд аюултай хог хаягдал шилжүүлсэн тоо хэмжээ*

**Дүгнэлт:** 2025 онд нийт 185.05 тн хог хаягдал үүссний 115.25 тн нь энгийн хог хаягдал, 72.8 тн нь аюултай хог хаягдал байна. Энгийн хаягдлыг өдөр бүр ангилан ялгаж, савлаж, шатаахын зэрэгцээ хоёрдогч түүхий эд авах цэгрүү шилжүүлснээр 2 тн төмөр, 0.8 тн шилны хаягдал үлдээд байна. Мөн энгийн хог хаягдал шатаах зуухыг засварлан шинэчилсэн.

### 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Газрын тос олборлох үйл ажиллагааны явцад агаар, хөрсөн бүрхэвч, усан орчин, амьтан, ургамлан нөмрөгт үзүүлж буй сөрөг нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтүүдийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүн, цаашид авах арга хэмжээг төлөвлөх зорилгоор энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Энэхүү ажлыг “Цавчирын Хөндий” ХХК-тай гэрээ байгуулан, хээрийн судалгааг нийт 3 удаагийн давтамжтай 2025 оны 06-р сарын 15-16, 2025 оны 08-р сарын 01-02, 2025 оны 09-р сарын 01-03 өдрүүдэд хийж гүйцэтгүүлсэн.

№	Байгаль орчны бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хэрэгжилт
1	Агаар	Нийт тоосонцор (TSP), PM10, хүхэрлэг хий SO <sub>2</sub> , азотын давхар исэл NO <sub>2</sub> , тоосонцор дахь SO <sub>4</sub> , NO <sub>3</sub> , CL, дуу чимээ, цацраг идэвхийн түвшин, цаг уурын үзүүлэлтүүд: даралт, температур, салхины хурд ба чиглэл	Төслийн талбайн хайгуул, олборлолтын цооногуудын каротажийн ажил, олборлолт явагдаж буй хэсгүүдэд ажлын үед, мөн цацраг идэвхт үүсгүүр, химийн бодис болон нефтийн бүтээгдэхүүний агуулах, тос тээвэрлэх зам дагуу, ажилчдын хотхон, нэгдсэн байгууламж, ахуйн болон үйлдвэрлэлийн хатуу, шингэн хог хаягдлын цэг, орон нутгийн зам дагуу	Төслийн талбайд хэмжсэн агаарын чанарын хэмжилтийн үр дүнгээс харахад 15цэгт агаар дахь нийт тоос /TSP/, нарийн ширхэглэгт тоосонцор /PM <sub>2.5</sub> /, том ширхэглэгт тоосонцор /PM <sub>10</sub> /, хүхэрлэг хий, азотын давхар ислийн хэмжээ нь Монгол Улсын “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага”MNS4585:2016 стандартаас бага буюу бохирдолгүй байна.
2	Дуу чимээ	Дуу чимээний хэмжээ (Дуу чимээ, чичиргээ доргионоос ажилчдын амьдрах орчин болон зэрлэг амьтдын амьдрах орчны хэвийн байдлыг алдагдуулах нөлөөлөл)	Өрөмдлөг, олборлолт явагдаж буй хэсгүүдэд ажлын үед, тос тээвэрлэх зам дагуу, ажилчдын хотхон, нэгдсэн байгууламж, орон нутгийн зам дагуу	Орчны дуу чимээний 15 цэгээс 20 минутын хугацаатай шинжилсэн. Агаарын чанар. Ерөнхий шаардлага MNS4585:2016 стандарт Харьцуулалт хийсэн. Дэлгэрэнгүйг тайланд тусгав.
3	Хөрс	Анхан шатны боловсруулалт,	Өрөмдлөг, олборлолт явуулж буй	Нийт 33 цэг дээр хөрсний органик

XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

		агрехими /рН, чийг, ялзмаг, NO <sub>3</sub> , SO <sub>4</sub> , P <sub>2</sub> O <sub>5</sub> /, хүнд металл /Pb, Cu, Zn, Cd/, нефть, цацраг идэвхийн фон	талбай, шатахууны агуулахын буулгах ба түгээх талбай, засварын газар, химийн бодис, цацраг үүсгүүрийн агуулах, тээврийн хэрэгслийн зогсоолууд, тос тээвэрлэх зам дагуу, ажилчдын хотхон, нэгдсэн байгууламж, ахуйн болон үйлдвэрлэлийн хатуу, шингэн хог хаягдлын цэг, орон нутгийн зам дагуу	нүүрстөрөгч (C), агро-хими ба ус-физик шинж чанар, хүнд металл зэрэг 22-н үзүүлэлтээр тодорхойлуулсан. Хөрсний хүнд металлуудын мониторинг цэгүүдэд Cd, Mo, Sn As, Pb, Cr, Co, Cu, Ni, Sr, V, Zn гэсэн тодорхойлсон ба хөрсний шинжилгээний тайланд дэлгэрэнгүй үзүүлэв.
4	Ус	Гадаргын ба гүний ус: г ол и онууд / Ca, Mg, Na+K, Cl, SO <sub>4</sub> , HCO <sub>3</sub> /, биогенийн бодисууд /NH <sub>4</sub> , NO <sub>2</sub> , NO <sub>3</sub> , PO <sub>4</sub> , Si/, органик бодис /ПИЧ, БХХ5/, хүнд металл / Pb, Zn, Cu, Fe/, нефть Хаягдал ус: рН, органик бодис /БХХ5/, хүнд металл /Pb, As, Cu, Zn, Ni, Fe/ Гүний усны түвшин	Усны худгууд: T21-W1, T21-W2, T21-W3, T21-W4, T21-W5, T21-W6, TW-21-S3, TW-21-4, TW-21-3, TW-21-8, Халхгол- Буйр нуур,	Усан орчны хяналт шинжилгээ дээр нийт 16 цэгээс дээж авсан. Усан орчны ерөнхий хими-физикийн үзүүлэлт, хүнд металлын үзүүлэлтүүдийг шинжлүүлсэн. Усны шинжилгээний дүнг усны тайланд дэлгэрэнгүй үзүүлэв.
5	Ургамлын аймаг	Ургамлын нягтрал, ургамлын аймгийн төрөл зүйл ба бэлчээрийн ургац	Ашиглалтын талбайн нөлөөлөлд өртсөн болон талбайн гаднах нөлөөлөлд өртөөгүй орчноос биомассын дээж авах	Геоботаникийн бичиглэлийн нийт 25 цэгт хийсэн. Шинжилгээний дүнг ургамлан нөмрөгийн тайланд дэлгэрэнгүй үзүүлэв.

### 9.1. Агаар орчны хяналт шинжилгээ

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний Дорнод аймгийн Халхгол, Матад сумын нутагт байрлах Газрын тосны XXI талбай дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, агаарын нийт тоосны агууламж нь MNS4585:2025 “Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага” стандартад нийцэж буй эсэхийг тодорхойлоход оршино.

Судалгааны аргазүй: Монгол Улсын агаарын чанарын Агаар мандал Сорьц авах ерөнхий шаардлага MNS3384:82, Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга MNS17.2.5.11-88, Агаар дахь хүхрийн хийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга MNS17.2.5.12-88 стандартын дагуу нэг агшны хөндлөн огтлолт судалгааны загвараар тухайн нөхцөл дэх уртраг, өргөргийн тодорхой солбилцолд тоосны хэмжилтийг 6-р сард TSI DustTrak 8520 багажаар, 8-р сард DUSTTRAK II Aerosol Monitor DRX багажаар нийт тоос /TSP/, нарийн ширхэглэгт тоосонцор /PM2.5/, том ширхэглэгт тоосонцор /PM10/ үзүүлэлтээр хэмжилтийг хийсэн.

Хүхэрлэг хий болон Азотын давхар ислийг SIBATA Mimirump MP-ΣNII багажуудаар 20 минут хэмжсэн. Дээжийг лабораторийн орчинд азотын давхар исэл /NO<sub>2</sub>/-ийг нэг удаагийн агууламжийг шингээгч гуурсанд 0.25 л/мин-ын хурдтай 20 спектрофотометрийн аргаар, хүхэрлэг хий /SO<sub>2</sub>/-г нэг удаагийн агууламжийг шингээгч гуурсанд 0.5 л/мин-ын хурдтай 20 минутын турш соруулж тетрахлормеркурат /ТХМ/ натрийн аргаар тодорхойлсон. Судалгааны үр дүнг агаарын чанарын стандарт (MNS 4585:2025)-тай харьцуулж дүгнэлт өгсөн.

Хээрийн судалгаа: 2025 оны агаарын чанарын орчны хяналт шинжилгээний хээрийн ажлыг 06 сарын 15-16 болон 08 сарын 01-02-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.

Хэмжилт, дээжлэлтийг 15 цэгт хийж гүйцэтгэсэн бөгөөд нарийн ширхэглэгт тоосонцор /PM2.5/, том ширхэглэгт тоосонцор /PM10/ үзүүлэлтийг MNS4585:2025 стандартын дагуу 24 цагийн хэмжилт хийх шаардлагатай байдаг тул Баянхошуу экспортын зам дагуу, Чойбалсан явах зам дагуу, 19-р талбай явах зам дагуу гэсэн 3 цэгт хэмжсэн.

6-р сарын агаарын хэмжилтийн үед орчны байдал салхи ихэнх хугацаанд 3-7 м/сек орчим, агаарын температур 21-24°C, газрын гадарга чийглэг байсан ба 1,2,7,10-р цэгээс дээж авах хугацаанд машины хөдөлгөөн ихтэй байсан. 3, 4, 5, 6, 8, 11 болон 12-р цэгт хөдөлгөөн бага байсан. 8-р сарын агаарын хэмжилтийн үед орчны байдал салхи ихэнх хугацаанд 2-7 м/с орчим, температур 28-30°C, үүлэрхэг, бага зэрэг бороотой байсан. 5, 6, 12, 13-р цэгүүдэд хэмжилт хийх хугацаанд газрын

**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

гадарга нойтон байсан ба 3, 4, 11-р цэгүүдэд автомашины хөдөлгөөн харьцангуй их байсан. Хатуу хог хаягдлын цэгт хэмжилт хийх үед огцом үнэртэй байсан бол ахуйн бохирын цэг дээр хөдөлгөөн болон үнэр бага байсан.

№	Цэгийн нэр	Нэр	Уртраг	Өргөрөг
1	21М-А-1	Төв кемпийн хашаан дотор	116° 59' 23.08"	47° 38' 44.78"
2	21М-А-2	Туслан гүйцэтгэгч анги-1	116° 59' 29.19"	47° 39' 8.20"
3	21М-А-3	ТА-2 Ачилтын талбай	116° 58' 57.42"	47° 38' 53.76"
4	21М-А-4	ТА-2 Шингэн хаягдлын сан	116° 58' 38.36"	47° 38' 58.63"
5	21М-А-5	Цооног N440-84	117° 5' 19.7"	47° 43' 48.2"
6	21М-А-6	Цооног N488-168	117° 1' 28.6"	47° 40' 57.3"
7	21М-А-7	Ахуйн бохир	116° 58' 36.75"	47° 37' 49.42"
8	21М-А-8	Хатуу хог хаягдал	116° 53' 47.67"	47° 32' 50.16"
9	21М-А-9	Үйлдвэрлэлийн шингэн хаягдал сан	116° 53' 49.2"	47° 32' 22.8"
10	21М-А-10	Өрөмдлөгийн талбайн	116° 57' 33.69"	47° 38' 43.19"
11	21М-А-11	Цацрагийн агуулах	116° 59' 48.50"	47° 39' 9.2"
12	21М-А-12	Экспортын зам дагуу (Баянхошуу боомт)	117° 01' 36.5"	47° 38' 58.7"
13	21М-А-13	Байгалийн горим	116° 58' 56.89"	47° 42' 12.47"
14	21М-А-14	Чойбалсан явах зам дагуу	116° 56' 39.3"	47° 39' 55.8"
15	21М-А-15	19-р талбай явах зам дагуу	116° 51' 28.9"	49° 26' 22.8"

**Хүснэгт-22. Агаарын мониторингийн цэгүүдийн ерөнхий мэдээлэл**

№	Цэгийн нэр	Температур, °C		Салхины хурд м/с		Дуу чимээ, дБа		MNS 4585: 2025
		6-р сар	8-р сар	6-р сар	8-р сар	6-р сар	8-р сар	
1	21М-А-1	22	23	2.4	3.2	44.6	41.9	60
2	21М-А-2	21	25	0.8	0.8	51.1	48.4	60
3	21М-А-3	19	26	1.7	2.5	36.9	34.2	60
4	21М-А-4	23	20	1.9	2.7	50.4	47.7	60
5	21М-А-5	22	24	0.7	1.5	42.3	39.6	60
6	21М-А-6	21	27	4	4.8	50	47.3	60
7	21М-А-7	24	27	2.7	3.5	48.7	46	60
8	21М-А-8	20	25	4.1	4.9	39.8	37.1	60
9	21М-А-9	22	22	1.7	2.5	37.2	34.5	60
10	21М-А-10	13	19	2.6	3.4	51.8	49.1	60
11	21М-А-11	12	30	1.8	1.8	50	47.3	60
12	21М-А-12	23	23	5.7	6.2	53.4	50.7	60
13	21М-А-13	21	21	1.4	2.7	33.9	31.2	60
14	21М-А-14	15	20	2.5	3.1	37	34.3	60
15	21М-А-15	23	26	5.9	6	51.4	48.7	60

**Хүснэгт-23. Хэмжилт хийх үеийн цаг агаарын төлөв байдал**

**Орчны дуу шуугиан судалгааны үр дүн:** Орчны дуу шуугианы хэмжилтийг мониторингийн цэгт 20 минутын хугацаатай хийсэн бөгөөд хэмжилтийн үеийн утга 31.2-53.4 дБа байна. Энэ нь Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS4585:2025 стандартын Өдрийн цаг (07-22 цаг) дуу шуугианы стандарт 60 дБа-аас хэтэрсэн үзүүлэлт байхгүй.




График-7. 2021-2025 оны дуу шуугианы хэмжилтийн дүн, дБа

2021-2025 оны дуу шуугианы хэмжилтээр 30-63.6 дБа байна. 2021 оны хэмжилтээр 21M-A-8 (Хатуу хог хаягдал) цэгт 63.6 дБа утгатай байсан нь Агаарын чанар. Ерөнхий шаардлага MNS4585:2025 стандарт өдрийн цаг (07-22 цаг)-ын 60 дБа-ын утгыг давсан ба энэ нь хэмжилт хийх үед тухайн цэг орчимд автомашины хөдөлгөөн харьцангуй ихтэй байсантай холбоотой. Харин бусад мониторингийн цэгийн хэмжилтээр агаарын чанарын стандарт давсан утга байхгүй.

2021-2025 оны дуу шуугианы хэмжилтийн дүн, дБа							
№	Мониторингийн цэг	2021	2022	2023	2024	2025 (8-р сар)	MNS 4585:2025
1	21M-A-1	55.5	45.6	55	41.9	41.9	60
2	21M-A-2	43.1	52.5	35	48.4	48.4	60
3	21M-A-3	52.1	43.7	32	34.2	34.2	60
4	21M-A-4	58.1	48.8	40	47.7	47.7	60
5	21M-A-5	55.2	51.6	35	39.6	39.6	60
6	21M-A-6	42.5	44.5	45	47.3	47.3	60
7	21M-A-7	55.7	55.4	30	46	46	60
8	21M-A-8	63.6	57.3	35	37.1	37.1	60
9	21M-A-9	58.4	50.5	35	34.5	34.5	60
10	21M-A-10	57.2	52	45	49.1	49.1	60
11	21M-A-11	44.3	48.2	40	47.3	47.3	60
12	21M-A-12	43.7	45.4	50	50.7	50.7	60
13	21M-A-13	53.9	42.8	35	31.2	31.2	60
14	21M-A-14	54.8	48.0	30	34.3	34.3	60
15	21M-A-15	51.4	56.2	31	48.7	48.7	60

Хүснэгт-24. 2021-2025 оны дуу шуугианы хэмжилтийн дүн, дБа

**Агаар дах тоосжилтын хэмжилтийн үр дүн:** Төслийн талбайд хэмжсэн 2024 оны агаар дахь тоосны хэмжилтийн үр дүнгээс харахад нийт тоосны хэмжээ 6-р сард 0.007-0.104 мг/м<sup>3</sup> байсан ба 8-р сард 0.006-0.091 мг/м<sup>3</sup>-ийн хооронд буюу “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS4585:2025 стандартаас бага байна (График-8).




График-8. 2021-2025 оны нийт тоосонцрын агууламж

Орчны хяналт шинжилгээний 2021-2025 оны тайлангийн агаарын шинжилгээний үр дүнг харьцуулж үзэхэд нийт тоосонцрын агууламж 0-0.148 мг/м<sup>3</sup> хооронд хэлбэлзэж байсан ба энэ нь Агаарын чанар.Техникийн ерөнхий шаардлага MNS4585:2025 стандартын агаар дахь нийт тоосонцрын 0.5 мг/м<sup>3</sup> агууламжийн утгаас бага буюу бохирдолгүй байгааг илтгэж байна.

№	МЦ	2025 он		MNS 4585:2025
		6-р сар	8-р сар	
1	21M-A-1	0.102	0.007	0.5
2	21M-A-2	0.09	0.019	0.5
3	21M-A-3	0.025	0.091	0.5
4	21M-A-4	0.028	0.082	0.5
5	21M-A-5	0.044	0.012	0.5
6	21M-A-6	0.033	0.007	0.5
7	21M-A-7	0.08	0.011	0.5
8	21M-A-8	0.028	0.017	0.5
9	21M-A-9	0.012	0.018	0.5
10	21M-A-10	0.104	0.021	0.5
11	21M-A-11	0.025	0.049	0.5
12	21M-A-12	0.038	0.006	0.5
13	21M-A-13	0.009	0.009	0.5
14	21M-A-14	0.007	0.02	0.5
15	21M-A-15	0.011	0.024	0.5

Хүснэгт-25. 2025 оны нийт тоосонцрын агууламж

2025 оны PM10 болон PM2.5 тоосонцрын агууламжийн хувьд Баянхошуу экспортын зам дагуу 6-р сард Pm10 0.008 мг/м<sup>3</sup>, Pm2.5- 0.006, 8-р сард Pm10 0.005 мг/м<sup>3</sup>, Pm2.5- 0.003 мг/м<sup>3</sup>, Чойбалсан явах зам дагуу 6-р сард Pm10 0.002 мг/м<sup>3</sup>, Pm2.5- 0.001, 8-р сард Pm10 0.003 мг/м<sup>3</sup>, Pm2.5- 0.001 мг/м<sup>3</sup> байсан бол 19-р талбай явах зам дагуу дагуу 6-р сард Pm10 0.006 мг/м<sup>3</sup>, Pm2.5- 0.003, 8-р сард Pm10 0.004 мг/м<sup>3</sup>, Pm2.5- 0.001 мг/м<sup>3</sup> буюу MNS 4585:2025 стандартаас бага байна (Хүснэгт-26).




График-9. 2021-2025 оны PM10 тоосонцрын агууламж




График-10. 2021-2025 оны PM2.5 тоосонцрын агууламж

Орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд нарийн ширхэгт тоосонцрын 2021-2025 оны хэмжилтийн дүнг (График-9) болон (График-10)-д үзүүллээ. Тухайн жилийн хээрийн хэмжилтээс шалтгаалан мониторингийн зарим цэгүүд дээр нарийн ширхэгт тоосонцор хэмжигдээгүй байна. 2021-2025 оны мониторингийн цэгүүдийн хэмжилтийн утга PM10 тоосонцрын утга 0.001-0.047 мг/м<sup>3</sup> буюу Агаарын чанарын стандарт 0.1 мг/м<sup>3</sup> утгаас 2.1 дахин бага, PM2.5 тоосонцрын утга 0.001-0.023 мг/м<sup>3</sup> буюу Агаарын чанарын стандарт 0.0375 мг/м<sup>3</sup> утгаас 1.6 дахин бага буюу бохирдолгүй байгааг илтгэж байна.

№	МЦ	Нэр	PM <sub>10</sub> тоосонцор		PM <sub>2.5</sub> тоосонцор	
			6-р сар	8-р сар	6-р сар	8-р сар
1	21М-А-12	Экспортын зам дагуу (Баянхошуу боомт)	0.008	0.005	0.006	0.003
2	21М-А-14	Чойбалсан явах зам дагуу	0.002	0.003	0.001	0.001
3	21М-А-15	19-р талбай явах зам дагуу	0.006	0.004	0.003	0.001

Хүснэгт-26. 2025 оны PM10 болон PM2.5 тоосонцрын агууламж

**Агаар дахь хийн хэмжилтийн үр дүн:** Хүхэрлэг хий (SO<sub>2</sub>): Хүхэрлэг хий нь хүхэр агуулсан түлшний шаталтын бүтээгдэхүүн бөгөөд хүрээлэн буй орчныг бохирдуулагч хортой хий юм. Хүхэрлэг хий нь нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станц, усан халаалтын зуух, үйлдвэрүүд, металлын хүдэр боловсруулалт, тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас ихэвчлэн үүсдэг. Нефтийн хий агуулагдах хүхэр нь хүхэрлэг хийн гол эх үүсвэр болно. Хүхэрлэг хий нь хортой хий бөгөөд өндөр агууламжтай үед амьсгал давчдах зэрэг шинж тэмдгүүд илрэх ба гол нөлөө нь амьсгалын замыг гэмтээдэг.

Төслийн талбай дахь хүхэрлэг хий (SO<sub>2</sub>) хэмжилтийн 2025 оны хэмжилтийн үр дүнгээс харахад 6-р сард 0.002-0.019 мг/м<sup>3</sup>, 8-р сард 0.003-0.016 мг/м<sup>3</sup> хооронд буюу “Агаарын чанар.Техникийн ерөнхий шаардлага” MNS4585:2025 стандартаас бага байна (График-26).

2021-2025 оны Агаарт агуулагдах хүхэрлэг хийн агууламжийг (График-11)-д үзүүлээ. Хүхэрлэг хийн агууламж 0.001-0.064 мг/м<sup>3</sup> дунджаар 0.011 мг/м<sup>3</sup> агууламжтай байсан нь Агаарын чанар. Ерөнхий шаардлага MNS4585:2025 стандарт 0.45 мг/м<sup>3</sup> бага буюу стандарт утгаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй бохирдолгүй байгааг илтгэж байна.




График-11.2021-2025 оны агаар дахь хүхэрлэг хийн агууламж

Азотын давхар исэл (NO<sub>2</sub>): Азотын давхар исэл нь өндөр температурт шаталтын үеийн дулаан шингээх урвалын бүтээгдэхүүн бөгөөд хүрээлэн буй орчны бохирдлын шалтгаан болж байдаг. Бохирдуулагчийн гол эх үүсвэр нь тээврийн хэрэгслийн хөдөлгүүр, халаалтын зуухнууд ба дангаараа болон хоёрдогч тоосонцор, хүчиллэг тунадас, газрын гадарга орчмын озон үүсгэх хэлбэрээр хүний эрүүл мэнд байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлдэг.

Төслийн талбай дахь азотын давхар ислийн (NO<sub>2</sub>) 2025 оны хэмжилтийн үр дүнгээс харахад 6-р сард 0.013-0.09 мг/м<sup>3</sup>, 8-р сард 0.023-0.095 мг/м<sup>3</sup> хооронд

буюу “Агаарын чанар.Техникийн ерөнхий шаардлага” MNS4585:2025 стандартаас бага байна (График-12).

2021-2025 оны Агаарт агуулагдах азотын давхар ислийн агууламжийг (График-12)-д үзүүллээ. Азотын давхар ислийн агууламж 0.002-0.299 мг/м3 агууламжтай байсан. 2023 оны 8-р сарын агаарын чанарын хэмжилтээр мониторингийн цэг 21М-А-1(Төв кемпийн хашаан дотор)-0.299 мг/м3 агууламжтай байсан нь Агаарын чанар. Ерөнхий шаардлага MNS4585:2025 стандарт 0.2 мг/м3 утгаас давсан байна. Бусад мониторингийн цэгүүд дээр азотын давхар ислийн агууламж стандарт утга давсан үзүүлэлт байхгүй.




График-12. 2.6 2021-2025 оны агаар дахь азотын давхар ислийн агууламж

№	МЦ	SO <sub>2</sub>		NO <sub>2</sub>	
		6-р сар	8-р сар	6-р сар	8-р сар
1	21M-A-1	0.002	0.009	0.023	0.023
2	21M-A-2	0.014	0.016	0.04	0.062
3	21M-A-3	0.012	0.011	0.031	0.033
4	21M-A-4	0.019	0.013	0.038	0.036
5	21M-A-5	0.008	0.009	0.026	0.029
6	21M-A-6	0.007	0.005	0.013	0.03
7	21M-A-7	0.019	0.008	0.051	0.05
8	21M-A-8	0.01	0.004	0.03	0.047
9	21M-A-9	0.019	0.013	0.09	0.095
10	21M-A-10	0.006	0.009	0.025	0.024
11	21M-A-11	0.005	0.011	0.023	0.045
12	21M-A-12	0.008	0.006	0.022	0.029
13	21M-A-13	0.004	0.005	0.022	0.028
14	21M-A-14	0.004	0.003	0.024	0.025
15	21M-A-15	0.003	0.004	0.025	0.026

Хүснэгт-27. 2.6 2021-2025 оны агаар дахь хийн хэмжилтийн үр дүн

**Дүгнэлт:** Төслийн талбайд 2025 онд хийсэн агаарын чанарын мониторингийн ажлын үр дүнг өмнөх 4 жилийн үр дүнтэй харьцуулан дараах дүгнэлтийг гаргалаа. Төсөл нь олборлолтыг гүний түвшинд битүү системээр явуулдаг онцлогтой бөгөөд дуу чимээ үүсэх гол эх үүсвэрүүд нь өрөмдлөгийн ажлын үед дэх техник тоног төхөөрөмжийн дуу чимээ, үйлдвэрийн орчны

техникийн дуу чимээ, тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнөөс үүсэх дуу чимээ байдаг. Судалгааны ажлын үр дүнгээс харахад төслийн талбай, талбайн үйл ажиллагааны нөлөөллийн бүс дэх дуу чимээний хэмжээ 2021 онд нийт цэгүүдэд бусад оноос өндөр 21М-А-8 (Хатуу хог хаягдал) цэгт 63.6 дБа утгатай байсан нь Агаарын чанар. Ерөнхий шаардлага MNS4585:2025 стандартаас өндөр үзүүлэлттэй байсан байна. Үүнээс хойших судалгаануудаар стандартаас давсан үзүүлэлт бүртгэгдээгүй ба тухайн хэмжилт хийх үеийн хэмжилтийн цэгийн орчин дахь үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний байдлаас хамааран жил бүрд харилцан адилгүй өсөлт бууралттай байна. Тоосны хэмжилтийн хувьд хэмжилтийн стандарт шаардлагаас хамаарч Pm2.5, Pm10 нарийн ширхэглэгт тоосны хэмжилтийг голчлон тээвэрлэлтээс үүдэлтэй тоосжилт бий болох боломжит цэгүүдэд 24 цагаар хэмжсэн ба нийт тоосыг бүх цэгүүдэд хэмжсэн. Сүүлийн 5 жилийн хэмжилтээс харахад нийт тоосны хэмжээ 0.1 мг/м<sup>3</sup> -аас дотогш хэлбэлзэж байгаа нь MNS 4585:2025 стандарт 0.5 мг/м<sup>3</sup>-аас бага байна. 2025 оны хэмжилтийн хувьд 8 сард бага зэрэг өссөн нь тухайн үеийн салхины хурд өмнөх сарын хэмжилтүүдээс өндөр, хамгийн их нь 0.035 мг/м<sup>3</sup> байсан нь агаарын температур халалт ихтэй хуурай байснаас шалтгаалсан байна. PM10, PM2.5 тоосонцрын агууламж 2023 оны хэмжилтээр бусад онуудаас өндөр байсан ба PM10 хамгийн их нь 0.029 мг/м<sup>3</sup> (стандарт түвшин 0.1 мг/м<sup>3</sup>), PM2.5 хамгийн их нь 0.022 мг/м<sup>3</sup> (стандарт түвшин 0.0375 мг/м<sup>3</sup>) хүрсэн байна. Эндээс харахад төслийн тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас агаар орчинд үзүүлэх тоосжилтын нөлөө бага байна.

Мониторинг хийсэн 5 жилд хүхэрлэг хийн агаар дахь агууламж хамгийн их байсан утга нь 2022 оны 6-р сард хийсэн хэмжилтээр 21М-А-9 цэгт 0.064 мг/м<sup>3</sup> ба энэ нь стандарт 0.45 мг/м<sup>3</sup>-аас бага буюу бохирдолгүй, азотын давхар ислийн хувьд 2023 оны 8 дугаар сард төв кемпийн хашаан дотор 21М-А-1 цэгт 0.299 мг/м<sup>3</sup>, өрөмдлөгийн талбай 21М-А-10 цэгт 0.2 мг/м<sup>3</sup> хүрч стандарт хэмжээнээс давж байсан ба үүнээс хойш дахин ийм өндөр үзүүлэлт илрээгүй нь тухайн хэмжилтийн үед богино хугацааны бохирдол бий болсон байсныг илтгэж байна. Бусад судалгаагаар агууламж хамгийн их нь 0.07 мг/м<sup>3</sup> (стандарт 0.2 мг/м<sup>3</sup>) буюу хэмжилт хийсэн хийн элементүүдийн хувьд бохирдолгүй байна.

Дээрх үр дүнгүүдээс харахад төслийн үйл ажиллагаанаас агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл бохирдол бага буюу бохирдолгүй болохыг илтгэж байна.

Төслийн мониторингийн 3 удаагийн судалгаа нь 6-9 сарын хооронд хийгдэж байгаа ба 7-8 дугаар сарын судалгааны үед магадлан итгэмжлэгдсэн агаарын

чанарын лабораторийн багаж, экспертийн хүрэлцээ бага байгаа нь хүндрэл учруулж байна. Нөгөө талаас агаарын чанарын шинжилгээний үр дүнгүүдээс харахад төслийн үйл ажиллагааны хүрээнд үүсэж буй тоосжилт болон азотын давхар исэл, хүхэрлэг хийн агууламж бага, цаг хугацааны өөрчлөлт бага байгаа тул жилд 3 удаагийн шинжилгээ хийх шаардлагагүй, 6, 9 дүгээр сард хийхэд боломжтой гэж үзэж байна.

## 9.2. Усан орчны хяналт шинжилгээ

Төслийн хүрээнд ашиглаж буй гүний худгуудын усны чанар, усны түвшиний өөрчлөлтийг хянах, ажилчдын унд ахуйн хэрэглээний усны чанарыг хянах зорилгоор 16 цэгт дээжлэлт, хэмжилт хийсэн. Усан орчны мониторингийн цэгүүдийн мэдээллийг Хүснэгт-28-д, цэгүүдийн байршлыг харуулав.

№	МЦ-ийн дугаар <sup>2</sup>	МЦ-ийн мэдээлэл	МЦ-ийн солбилцол	
			Х	У
1	T21-W12	Нэгдсэн шугамд холбогдсон газрын доорх усны ашиглалтын худаг	116°59'33.75"	47°39'8.03"
	T21-W31		116°52'42.60"	47°32'46.60"
2	T21-W24		116°59'46.20"	47°41'10.31"
3	T21-W23		116°59'35.02"	47°41'23.76"
4	T21-W13		116°59'27.24"	47°41'38.10"
5	T21-W28		117° 4'18.92"	47°43'54.38"
6	T21-W14		116°59'14.77"	47°41'52.23"
7	T21-W15		117° 0'31.22"	47°41'18.01"
8	T21-W26		116°59'1.98"	47°39'53.87"
9	TW21-3		116°59'35.92"	47°39'39.70"
10	TW21-8		116°59'12.98"	47°38'17.20"
11	T21-W7		116°59'21.63"	47°39'7.22"
	T21-W18		116°59'9.86"	47°38'55.13"
12	T21-W38	117° 3'39.01"	47°43'30.04"	
13	T21-W39		117° 4'59.05"	47°44'12.05"
14	T21-W36	Ажилчдын унд ахуйд ашигладаг гүний худаг	116°59'8.74"	47°38'48.01"
15	Кемп-Цэвэршүүлсний дараа	Ажилчдын унд ахуйд ашиглаж буй цэвэршүүлсэн ус	116°59'24.04"	47°38'50.03"
16	Буйр нуур	Буйр нуур	116°52'42.60"	47°32'46.60"

Хүснэгт-28. Усан орчны мониторингийн цэгүүдийн ерөнхий мэдээлэл

Хээрийн судалгааны аргазүй: 2025 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд усны мониторингийн хээрийн судалгаа буюу усны дээж авах ажлыг 6-р сарын 09-10, 7-р сарын 24-25, 9-р сарын 03-5-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.

Дээжлэлтийг “Унд ахуйн хэрэгцээний, үйлдвэрийн ус хангамжийн зориулалттай ус. Химийн шинжилгээний дээж авах аргачлал” MNS3934 : 1986,

<sup>2</sup> Товчилсон угийн тайлбар: МЦ- мониторингийн цэг

Усны чанар-Дээж авах: 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж” MNS ISO 5667-11:2000 стандартын дагуу 1.5 л багтаамжтай цэвэр усны саванд. Дээж авахдаа дээжний савыг дээж авч буй эх үүсвэрийн усаар 2 удаа зайлж, савыг дээжээр бүрэн дүүргэж дээр нь агаар байх зайгүйгээр тагласан. Энэ нь тээвэрлэлтийн явцад сэгсрэгдэх, хүчил төрөгчтэй тухайн дээж харилцан үйлчлэлд орохыг хязгаарлана.

Лабораторийн задлан шинжилгээний аргазүй: Гүний усны ерөнхий химийн шинжилгээ (анион, катион, Ph, TDS, ES, физик үзүүлэлтүүд)-ийг Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний магадлан итгэмжлэгдсэн лабораторид, хүнд элементийн шинжилгээг “SGS IMME Mongolia” ХХК-ийн олон улсын магадлан итгэмжлэгдсэн лабораторид 57 үзүүлэлтээр шинжилгээний холбогдох аргачлал, стандартын дагуу тус тус шинжлүүлсэн.

Үр дүнгийн боловсруулалтын аргазүй: Газрын доорх усны мониторингийн ажлын боловсруулалтыг хийхдээ унд ахуйн хэрэглээний усны шинжилгээний үр дүнг Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандарттай, олборлолт, үйлдвэрлэлд ашиглаж буй усны шинжилгээний үр дүнг Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010 стандарт болон өмнөх онуудын мониторингийн шинжилгээний дүнтэй харьцуулан үнэлэлт дүгнэлт өгсөн.

**Усны ерөнхий хими-физик шинж чанар:** Усан дахь рН агууламж нь тухайн усны хүчил эсвэл шүлтлэг шинжийг илэрхийлдэг хэмжүүр бөгөөд Монгол улсын ундны усны стнадартад 6.5-8.5 хооронд байхад тохиромжтой гэж үздэг. рН агууламж нь 7.0 байхад саармаг буюу  $H^+$  ион ба гидроксид ион ( $OH^-$ ) тэнцвэртэй байх ба  $7.0 < pH$  бол шүлтлэг,  $7.0 > pH$  бол хүчиллэгийн хэмжээ нэмэгддэг. Тамсаг XXI талбайн ашиглалтын хугаагийн усны Ph орчин буюу хүчил, шилтийн харьцаа дундаж 7.2 буюу саармаг байна.








График-13. Худгуудын усан дахь усны орчин рН агууламж

Газрын тос олборлолтод ашиглаж буй худгуудын усны ерөнхий химийн үзүүлэлтүүдээс харахад Хлори, магни, төмрийн агууламж ихэнхи худгийн усанд

Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010 стандартад заасанаас өндөр байгаа нь талбайн хэмжээнд хлорийн ангийн, натрийн бүлгийн ус зонхилон тархсаныг харуулж байна. T21-W24, T21-W23, T21-W3 дугаар худгуудын усан дахь анион, катионуудын агууламж бусад худгуудаас илүү их байгаа ба сульфат, кальцийн агууламж стандартаас өндөр хэмжээнд байна.






График-14. Тамсаг XXI талбайн ашиглалтын худгуудын усан дахь зарим химийн элементүүдийн агууламж

**Хатуулаг:** Усны хатуулаг нь усанд ууссан кальци ( $Ca^{2+}$ ) ба магни ( $Mg^{2+}$ ) металл ионуудын нийт концентрацийг илэрхийлдэг усны чанарын чухал үзүүлэлт юм. Төслийн талбайн мониторингийн худгуудаас T21-W24, T21-W14, T21-W15, T21-W3 дугаар худгуудын ус нь маш хатуу, T21-W23, T21-W13, T21-W28, T21-W7, T21-W12 болон T21-W8 дугаар худгуудын ус нь хатуувтар, T21-W38, T21-W36, T21-W39, T21-W26 дугаар худгуудын ус нь зөөлөн устай байна.




График-15. Худгуудын усны хатуулаг

**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

Үзүүлэлт	Нэгж	Стандарт	T21-W24	T21-W23	T21-W13	T21-W14	T21-W38	T21-W36	T21-W39	T21-W28	T21-W15	T21-W26	TW-21-3	T21-W7	T21-W12	T-21-W8
<b>Физик үзүүлэлтүүд</b>																
Тунгалаг	см		30	16	25	25	30	30	30	22	18	30	16	30	25	30
Өнгө		-	өнгөгүй	шаргал	сул шаргал	сул шаргал	өнгөгүй	өнгөгүй	өнгөгүй	сул шаргал	шаргал	өнгөгүй	шаргал	өнгөгүй	Сул шаргал	өнгөгүй
Үнэр		20	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	Үгүй	үгүй
Тунадас		-	үл мэдэг	үл мэдэг	үгүй	үл мэдэг	үгүй	үгүй	үгүй	бага зэрэг	үл мэдэг	үл мэдэг	үл мэдэг	үгүй	Үгүй	бага зэрэг
Усны орчин, Ph		6.5-8.5	7.12	7.07	7.47	7	7.48	7.46	7.36	7.34	6.97	8.1	6.98	7.29	7.36	7.15
ЕС	мСм/см	1	2590	2620	2270	1325	1642	2900	1875	1999	1875	1855	2190	2450	2450	1667
<b>Химийн үзүүлэлтүүд</b>																
Cl-	мг/л	350	432.2	211.2	341.5	259.5	335.1	624.4	410.4	354.3	331.9	333.7	415.4	356	359.3	232.9
CO4--	мг/л	500	390	685	310	285	125	175	75	275	365	185	485	285	320	280
NO2--	мг/л	1	0	0.9	0	0.3	0	0	0.45	0	0	0.45	0.9	1.2	0.15	0
NO3-	мг/л	50	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
CO3-	мг/л	-	0	0	0	0	0	0	0	0	0	12	0	0	0	0
HCO3-	мг/л	-	359.9	305	347.7	341.6	414.8	494.1	469.7	366	311.1	378.2	347.7	390.4	408.7	280.6
NA <sup>+</sup> +K <sup>+</sup>	мг/л	-	363.7	394.9	352.2	228.5	363.2	605.5	420.6	357.2	303.2	391.2	380.2	365.3	396.8	241.3
CA <sup>++</sup>	мг/л	100	115	90.2	75.8	84.6	34.7	37.1	28.5	64.7	83.2	24.4	113.4	75.4	76	60.9
Mg <sup>++</sup>	мг/л	30	52	14	30.9	53.1	15.3	12.4	12.3	32.8	47.5	19.1	53	33.7	28.1	41.1
NH <sub>4</sub> <sup>+</sup>	мг/л	3	2	0.1	2.1	0.1	1.1	2	2.1	1	0.1	1.2	0.1	0	1.5	0
Fe <sup>++</sup>	мг/л	0.3	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Fe <sup>+++</sup>	мг/л	0.3	0	45	0.5	6	0	0.5	0	3.6	15	0	18	0	1	1.5
TDS	ppm	-	1425	1310	1249	729	903	1595	1031	1099	1031	1020	1314	1225	1348	917
Ерөнхий хатуулаг	мг-экв/л	7	10.02	5.65	6.32	8.59	2.99	2.87	2.43	5.93	8.06	2.79	10.02	6.53	6.1	6.42

*Хүснэгт-29. Тамсаг XXI талбайн гүний худгуудын усны ерөнхий хими-физикийн шинжилгээний дүн*

Ажилчдын унд ахуйн хэрэглээнд ашиглаж буй усны эх үүсвэрийн ерөнхий хими-физик шинж чанар: Усны мониторингийн цэг T21-W36 /Ажилчдын унд ахуйн хэрэгцээг хангадаг гүний худаг/: T21-W36 худгийн ус нь 2025 оны 6 дугаар сарын дээжлэлтээр химийн бүрэлдэхүүнээрээ хлорийн ангийн, натрийн бүлгийн 1-р төрлийн, чанарын хувьд давсархаг, зөөлөн ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүдээс төмрийн ион 0.2 мг/л-ээр Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартад заасанаас их буюу энэ худгийн усыг шууд унд ахуйн хэрэглээнд ашиглаж болохгүй.

**pH:** Усан дахь pH агууламж нь тухайн усны хүчил эсвэл шүлтлэг шинжийг илэрхийлдэг хэмжүүр бөгөөд Монгол улсын ундны усны стнадартад 6.5-8.5 хооронд байхад тохиромжтой гэж үздэг. pH агууламж нь 7.0 байхад саармаг буюу  $H^+$  ион ба гидроксид ион ( $OH^-$ ) тэнцвэртэй байх ба  $7.0 < pH$  бол шүлтлэг,  $7.0 > pH$  бол хүчиллэгийн хэмжээ нэмэгддэг. T21-W36 дугаар худгийн усны Ph орчин нь сүүлийн 4 жилийн хэмжилтээр хүчил, шилтийн харьцаа дундаж 7.4 буюу саармаг байна.




График-16. Усны орчин pH агууламжийн өөрчлөлт, 2022-2025 он

**Хлори, Cl:** T21-W36 дугаар худгийн усан дахь хлорийн ионы агууламж сүүлийн 4 жилд 2022 оны 6 сард хамгийн их буюу 944.3 мг/л хүрсэн ба үүнээс хойш 639-297.8 мг/л хооронд хэлбэлзсэн байна. Улирлын дээжнүүд дэх агууламжаас харахад харилцан адилгүй, тогтмол өсөлт болон бууралтын динамик харагдахгүй байгаа нь газрын доорх усны олборлолт, усны урсгал хөдөлгөөн зэргээс хамаарч агууламж нь өөрчлөгддөг байж болзошгүй байна. 2025 оны 6, 8 дугаар саруудад MNS 0900:2018 стандартаас 2 дахин өндөр байсан бол 9 дүгээр сард 297.8 мг/л болж стандарт түвшинээс дотогш орсон байна.




График-17. Хлорин ионы агууламжийн өөрчлөлт, 2022-2025 он

**Сульфат,  $SO_4^{2-}$ :** Худгийн усан дахь сульфатийн агууламж 2022 оны намраас 2024 оны хооронд тогтвортой 255-280 мг/л хооронд байсан байна. Харин 2025 оны дээжнүүдэд харилцан адилгүй агууламжтай буюу 6-р сард 175 мг/л, 8 дугаар сард 390 мг/л байсан бол 9 сард 521 мг/л байсан байна.




График-18. Сульфатийн агууламжийн өөрчлөлт, 2022-2025 он

**Кальци,  $Ca^{++}$ :** кальцийн агууламжийн өөрчлөлтийн графикаас харахад Хлортой урвуу хамааралтай харагдаж байна. Хлорин агууламж өндөр үеүдэд кальцийн агууламж өссөн байгааг График 3.7-3.8-оос харж болохоор байна. 2025 оны 9 дүгээр сард хлорин агууламж хамгийн бага түвшинд хүрсэн бол кальцийн агууламж хамгийн их хэмжээнд хүрч 102.8 мг/л буюу MNS 0900:2018 стандартаас давсан байна.




График-19. Кальцийн ионы агууламжийн өөрчлөлт, 2022-2025 он

**Магни, Mg<sup>++</sup>:** Магнийн ионы агууламж нь мөн жил, улирал хооронд харилцан адилгүй агууламжтай байгаагаас гадна хлорийн агууламжтай мөн урвуу байна. Графикаас харахад 8 дугаар сарын дунд, 9-р сарын эхээр магнийн агууламж өндөр байна.




График-20.Магнийн ионы агууламжийн өөрчлөлт, 2022-2025 он

**Төмөр, Fe<sup>+++</sup>:** Төмрийн агууламж нь мөн жил болон улирал хооронд харилцан адилгүй өөрчлөлттэй байна. 2023 оны 8 дугаар сарын хэмжилтээс хойш MNS 0900:2018 стандартаас тогтмол давсан үзүүлэлттэй байна.




График-21.Төмрийн ионы агууламжийн өөрчлөлт, 2022-2025 он

Үзүүлэлт	Нэгж	Стандарт	2022.VI	2022.VIII	2023.VII	2023.VIII	2023.IX	2024.VI	2025.VI	2025.VIII	2025.IX
<b>Физик үзүүлэлт</b>											
Тунгалаг	см		25	30	27	26	26	22	30	25	22
Булгингаршил	мСм/см	5	10.37	2,18	5.23	4.89	7.88			12.3	7.48
Усны орчин, рН		6.5-8.5	7.26	7.38	7.57	7.47	7.86	7.62	7.46	7.62	6.78
ЕС		1000	2945	2223	2817	2309	2665	2040	2900	3260	2180
<b>Химийн үзүүлэлт</b>											
Cl <sup>-</sup>	мг/л	350	944.3	361.4	635.5	375.9	608.5	311	624.4	639	297.8
SO <sub>4</sub> <sup>-</sup>	мг/л	500	200	262	275	280	255	280	175	390	521
NO <sub>2</sub> <sup>-</sup>	мг/л	1	0	0.4	0	0	0.01	0	0	0	0.0
NO <sub>3</sub> <sup>-</sup>	мг/л	50	0	0	0	10	0	12	0	2	1.0

**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

CO <sub>3</sub> <sup>-</sup>	мг/л	-	0	0	0	0	0	0	0	0	0.0
HCO <sub>3</sub> <sup>-</sup>	мг/л	-	8.2	420.9	515.5	469.7	475.8	366	494.1	500.2	396.5
Na <sup>+</sup> +K <sup>+</sup>	мг/л	-	840.8	332	669.5	358.8	624.1	256.9	605.5	720.3	351.2
Ca <sup>++</sup>	мг/л	100	29.9	81.2	37.3	94.6	38.1	86.8	37.1	35.9	102.8
Mg <sup>++</sup>	мг/л	30	10.1	49.4	12.4	47.1	13.4	61.2	12.4	12.9	63.6
NH <sub>4</sub> <sup>+</sup>	мг/л	1.5	1.6	0	1.6	0	1.65	2.1	2	2	1.6
Fe <sup>++</sup>	мг/л	0.3	0	0	0	0	0	0	0	0	0.0
Fe <sup>+++</sup>	мг/л	0.3	0	0.06	0	1.8	0.5	2.6	0.5	1.5	0.8
TDS	мг/л	-	1619	1270	1610	1385	1523	1122	1595	1956	1308
Ерөнхий хатуулаг	мг-экв/л	7	2.32	8.11	2.88	8.59	3	9.36	2.87	2.85	10.4

*Хүснэгт-30. T21-W36 дугаар хүдгийн 2022-2025 оны усны чанарын шинжилгээний дүн*

**Кемпийн цэвэршүүлсэн ус:** Ажилчдын унд ахуйн хэрэглээнд ашиглахын өмнө газрын доорх усыг цэвэршүүлдэг. Унд ахуйн хэрэглээний ус нь химийн бүрэлдэхүүнээрээ хлорийн ангийн, натрийн бүлгийн 1-р төрлийн, чанарын хувьд нэн цэнгэг, маш зөөлөн ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүд нь Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018 стандарттай нийцэж байгаа буюу ажилчдын унданд эрүүл мэндийн шаардлага хангасан ус ашиглаж байна.

Үзүүлэлт	Нэгж	Стандарт	2025.VI	2025.VIII	2025.IX
<b>Физик үзүүлэлт</b>					
Тунгалаг	см		30	30	30
Өнгө		-	өнгөгүй	үгүй	үгүй
Үнэр		20	үгүй	үгүй	үгүй
Тунадас		-	үгүй	0.59	0.01
Усны орчин, Ph		6.5-8.5	7.42	6.7	7.52
ЕС	мСм/см	1	120	162	198
<b>Хими үзүүлэлт</b>					
Cl <sup>-</sup>	мг/л	350	32	34.1	36.2
CO <sub>4</sub> <sup>--</sup>	мг/л	500	10	20	12.0
NO <sub>2</sub> <sup>--</sup>	мг/л	1	0	0	0.0
NO <sub>3</sub> <sup>-</sup>	мг/л	50	0	0	1.0
CO <sub>3</sub> <sup>-</sup>	мг/л	-	0	0	0.0
HCO <sub>3</sub> <sup>-</sup>	мг/л	-	30.5	18.3	48.8
NA <sup>+</sup> +K <sup>+</sup>	мг/л	-	32.7	37.6	44.8
CA <sup>++</sup>	мг/л	100	0.4	0.6	1.6
Mg <sup>++</sup>	мг/л	30	0	0.1	0.7
NH <sub>4</sub> <sup>+</sup>	мг/л	1.5	3	0	0.0
Fe <sup>++</sup>	мг/л	0.3	0	0	0.0
Fe <sup>+++</sup>	мг/л	0.3	0	0	0.0
TDS	ppm	-	66	89	100
Ерөнхий хатуулаг	мг-экв/л	7	7.42	0.04	0.14

*Хүснэгт-31. Ажилчдын гал тогоонд хэрэглэж буй цэвэршүүлсэн усны шинжилгээний дүн*

Олборлолтод ашиглаж буй гүний худгуудын усны хүнд элементийн агууламж, өөрчлөлт: Газрын тос олборлолтын үйл ажиллагаанд ашиглаж буй гүний худгуудын усны чанарын өөрчлөлтийг хянах зорилгоор дээж авч 52 төрлийн химийн элементийг “Эс Жи Эс” ХХК-ийн лабораторид шинжлүүлдэг. Шинжилгээний үр дүнг Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010 стандартад тэмдэглэгдсэн Ba, Cr, Fe, Mn, V, Zn, Be, Ni, Mo, As, Se, Ag, Cd, Sb, Hg, Pb, U элементүүд дээр харьцуулалт хийж үнэлэлт дүгнэлт өгөхийг зорьсон.

**Төмөр (Fe):** Газрын доорх усан дахь төмрийн агууламжийн сүүлийн дөрвөн жилийн шинжилгээний дүнгээс харахад T21-W23, T21-W14, T21-W13 худгууд дээр мониторингийн бүх хугацаан төмрийн агууламж хамгийн өндөр байсан бол T21-W15, T21-W26, T21-W8 дугаар худгууд дээр 8, 9 дүгээр саруудад, T21-W18, T21-W39 худгууд дээр 9-р сард, T21-W36 худаг дээр 6 дугаар сард тус тус стандартаас давсан агууламж илэрсэн байна. 2022 оны хавар бүх худгууд дээр стандартаас хэт өндөр биш боловч төмрийн агууламж мэдэгдэхүйц өссөн нь цар тахлын үед худгуудыг ашиглахгүй удсанаас шугам хоолойд зэврэлтийн нөлөөлөл үүссэн байж болохыг харуулж байна. Үүнээс цааш авсан дээжүүдэд цаг хугацааны хувьд харилцан адилгүй өсөлт бууралт ажиглагдаж байгаа нь тухайн үеийн худгийн ашиглалтаас хамаарч шугам хоолойд зэврэлт их бага хэмжээгээр үүссэнээс шалтгаалсан түр зуурын нөлөөлөл байх боломжтойг харуулж байна. Мөн худгууд нь нэгдсэн системрүү битүү шугам хоолойгоор усаа нийлүүлдэг, дээж авах цоргыг хяналт мониторингийн үед л зөвхөн ашигладаг нь ашиглаагүй удсанаас шугамд зэврэлт үүсч дээжин дэхь төмрийн агууламжийг өсгөсөн байх боломжтой.




График-22. Газрын доорх усанд агуулагдаж буй төмрийн агууламж

**Манган (Mn):** Усанд агуулагдах манганы өөрчлөлтийн сүүлийн дөрвөн жилийн судалгааны үр дүнгээс харахад T21-W24, T21-W23, T21-W13, T21-W14, T21-W15 худгууд дээр өсөх стандартаас 2-10 дахин их байсан ба улирал болоод жилээр

өсөх хандлагатай байна. Эдгээр худгууд нь бусад худгуудтай харьцуулахад удаан хугацаанд газрын тос олборлолтын шахалтад ашигласан тус гүний ус нь хөдөлгөөнд их орсон, усны гаралт багассан зэргээс усанд агуулагдах Mg хэмжээ өндөр байж болзошгүй. 2025 оноос мониторингийн судалгаанд хамруулсан худгуудаас T21-W39 худагт 8, 9 дүгээр сард, T21-W3 худагт 6, 9 дүгээр сард, T21-W7, T21-W12 дугаар худгууд дээр 6 дугаар сард, T21-W18, T21-W31 дугаар худгууд дээр 8,9 дүгээр сард стандартаас давсан манганийн агууламжтай байсан.




График-23. Газрын доорх усанд агуулагдаж буй манганы агууламж

**Никель (Ni):** Гүний худгуудын усанд агуулагдаж буй никелийн хэмжээ нь MNS 6148:2010 стандартаас бага, дээж авсан хугацаануудад өөрчлөлттэй буюу 2022 оны 9 сард ихэнх худгуудад 20 мкг/л орчим, 2024 оны 8 дугаар сард хэд хэдэн худаг дээр 7 мкг/л болж өссөн, 2025 оны шинжилгээгээр хамгийн их нь 9-р сард T21-W1х худаг дээр 15 мкг/л хүрсэн байна (График-24)




График-24. Газрын доорх усанд агуулагдаж буй никелийн агууламж

**Хүнцэл (As):** Судалгааны үр дүнгээс (График-25) харахад дээжнүүд дэх хүнцлийн агууламж 2023 оны 6 сард T21-W14, 2025 оны 8 сард T21-W3, 6, 9 сард T21-W8, 9 сард T21-W31 дугаартай худгууд дээр MNS6148:2010 стандартаас давсан байна. Ихэнхи худгуудад стандарт хэмжээнээс бага байгаа ч нийт худгуудын усанд хүнцэлийн агууламж илэрсэн талбайн дундажаар 2025 оны 9-р сард 6.7 мкг/л байна.




График-25. Газрын доорх усанд агуулагдаж буй хүнцэлийн агууламж

**Молбиден (Mo):** Судалгааны үр дүнгээс (График-26) харахад молбиденийн агууламж T21-W14 дугаар худгийн усанд молбиденийн агууламж өндөр, зарим улиралд стандартаас давсан үзүүлэлттэй байна. Молбиденийн агууламж өндөр, дээжлэлтийн ихэнхи хугацаанд стандартаас давсан агууламжтай байсан байна. T21-W13 худагт 2023 оны 6 сард, T21-W8 худагт 2024 оны 6 сард, T21-W15 худагт 2025 оны 9 сард стандартаас давсан агууламж илэрсэн ч бусад хугацаанд бага агууламжтай байсан тул энэ нь ус олборлолтын эрчим, ус чулуулагийн харилцан үйлчлэлийн идэвхижилт зэрэг хүчин зүлстэй хамааралтай байх магадлалтай. Жил, улирлын динамик өөрчлөлт ажиглагдахгүй.




График-26. Газрын доорх усанд агуулагдаж буй молбиденийн агууламж

**Селен (Se):** Судалгааны үр дүнгээс (График-27) харахад 2022-2023 оны хооронд худгуудын усанд агуулагдах селений агууламж 0-30 мкг/л хооронд хэлбэлзсэн байна. 2025 оны судалгаагаар T21-W3 худгийн усанд 2025 оны 8 сард 44.7 мкг/л, T21-W31 дугаар худгийн усанд 9 сард 45.7 мкг/л агууламжтай илэрсэн нь MNS6148:2010 стандартаас давсан үзүүлэлт юм. Гэвч эдгээр цэгүүд дээрх селений агууламж нь жил болон улирлын динамик өсөлт, бууралт харуулахгүй.




График-27. Газрын доорх усанд агуулагдаж буй селенийн агууламж

**Уран (U):** График-28-аас харахад ураны агууламж T21-W14 дугаар худаг дээр бүх онуудад өндөр байсан ба 2024 оны 6 болон 9 дүгээр сарууд, 2025 оны 9-р сард тус тус стандартаас давсан өсөлтийг харуулж байна. Бусад худгуудаас 2025 оын шинжилгээгээр T21-W28 худгийн усанд 3.85-7.68 мкг/л, T21-W3 худгийн усанд 0.14-12.5 мкг/л, T21-W8 худгийн усанд 4.3-10.8 илэрсэн нь бусад худгуудын агууламжтай харьцуулахад өндөр боловч стандарт хэмжээнээс бага байна.





График-28. Газрын доорх усанд агуулагдаж буй ураны агууламж

**Буйр нуурын усны чанар:** Төслийн үйл ажиллагааны хүрээнд буйр нуурын усны чанарыг мөн хянах зорилгоор дээж авсан. 2022-2025 онуудад Буйр нуурын усанд хийсэн хүнд элементийн шинжилгээний үр дүнг MNS4586:1998 “Усан орчны

**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” стандартад харьцуулан үзэхэд 2023 он 8 дугаар сарын дээжээс As агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 2.2 мкг/л-ээр их гарсан боловч дараагийн судалгаануудад стандартаас давсан үзүүлэлт илрээгүй.

Бусад элементүүдийн хувьд стандартаас өндөр болон агууламжийн хувьд мэдэгдэхүйц өссөн өөрчлөлт илрээгүй байна.



**График-29. Буйр нуурын усанд дахь хүнцэлийн агууламжийн өөрчлөлт (2022-2025 он)**

Огноо	Cr	Cu	Zn	Ni	Cd	Pb	Mo	As	Hg
2021 он	10	0	0	10	0	20	-	-	-
2022 он	<10	<5	<5	2.3	0.03	<0.5	4.4	5.85	<0.5
2023 он 6 сар	<10	<5	<5	<0.3	<0.01	<0.5	4.4	6.26	<0.5
2023 он 8 сар	<10	<5	<5	<0.3	<0.01	<0.5	3.2	12.2	<0.5
2023 он 9 сар	<10	<5	<5	<0.3	<0.01	<0.5	3	5.26	<0.5
2024 он 6 сар	<11	<6	<5	<0.3	0.06	<0.6	2.6	4.98	<0.5
2024 он 8 сар	<12	<7	7	3.8	<0.01	<0.7	2.9	5.62	<0.5
2024 он 9 сар	<13	<8	<5	<0.3	<0.01	<0.8	2.8	5.71	<0.5
2025 он 6 сар	<10	<b>16</b>	<5	5	0.01	0.9	2.9	5.74	<0.5
2025 он 8 сар	29	<5	<5	0.5	<0.01	<0.5	3.2	5.58	<0.5
2025 он 9 сар	<10	<5	<5	0.8	0.02	<0.5	3.4	4.78	<0.5
<b>MNS 4586:1998</b>	<b>50</b>	<b>10</b>	<b>10</b>	<b>10</b>	<b>5</b>	<b>10</b>	<b>250</b>	<b>10</b>	<b>100</b>

**Хүснэгт-32. Буйр нуурын усны шинжилгээний дүн, мкг/л**

**Олборлолтод ашиглаж буй гүний худгуудын усны түвшин:** Гүний худгуудын түвшний хэмжилтийн мэдээнээс харахад худгуудын усны түвшин нь жил болон улирлаас хамаарсан динамик өөрчлөлтгүй байгаа нь тухайн үеийн ус олборлолтын эрчимээс хамаарч өсөх болон буурах явц ажиглагдаж байх боломжтой байна. Графикаас харахад T21-W13 дугаар худаг дээр түвшний хэлбэлзэл хамгийн их байсан ба 2025 оны 6 дугаар сарын хэмжилтээр 104 м-т ус илэрч байсан бол 8 дугаар сарын хэмжилтээр 44.2 м-т ирж өссөн байна. 2025 оны

хэмжилтээр T21-W14, T21-W12, T21-W28, T21-W15 худгуудын усны түвшин 6 сараас 8 сард буурсан байсан бол, T21-W23, T21-W13 худгуудын усны түвшин нэлээд өссөн, бусад худгууд дээр түвшиний өөрчлөлт тогтвортой байсан байна.




График-30. Гүний худгуудын усны түвшний хэмжилтийн үр дүн

**Дүгнэлт:** Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт Тамсаг XXI талбайн гүний усны ашиглалтын худгуудад 2025 оны 6, 8, 9 дүгээр саруудад орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд дээж авч ажилласан. Тус дээжнүүдийн үр дүнг 2022-2025 оны судалгааны ажлын үр дүнтэй харьцуулан дараах дүгнэлт гарсан.

1.Төслийн газрын тос олборлолтод ашиглаж буй гүний худгуудийн ус нь ерөнхийдөө химийн бүрэлдэхүүнээрээ хлорийн ангийн, натрийн бүлгийн 1, 2-р төрлийн, чанарын хувьд давсархаг ус байна.

2.Ажилчдын унд ахуйн хэрэгцээг хангаж буй T21-W36 дугаар худгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ хлорийн ангийн, натрийн бүлгийн 1-р төрлийн, чанарын хувьд давсархаг, зөөлөн ус байгаа боловч хлори, манган, төмөр, аммоний агууламж ихэнхи судалгаагаар Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартад заасан хэмжээнээс өндөр байна.

3.T21-W36 дугаар худгаас ирсэн усыг цэвэршүүлж ажилчдын унд, ахуйн хэрэглээнд ашигладаг байна. XXI талбайн ажилчдын унданд эрүүл мэндийн шаардлага хангасан ус ашиглаж байна.

4.Шинжилгээнд хамруулсан худгуудын усан дахь манганы агууламж стандарт хэмжээнээс маш өндөр байна. Манган нь дэлхийн царцдаст өргөн агуулагддаг элемент бөгөөд уул уурхайн ус ашиглалт, ус зайлуулалтын үйл ажиллагаанаас ихэвчлэн газрын гадаргад ихээр гарч ирдэг байна.

5.Худгуудын усанд агуулагдах хүнд элементүүдийн агууламжийн жил болон улирлын өөрчлөлтүүд нь харилцан адилгүй, өсөлт болон бууралтын ямар нэг

динамик харуулахгүй байгаа нь тухайн дээж авах үеийн ус олборлолтын эрчимшилтэй холбоотой газрын доорх худас-усны харилцан үйлчлэл нэмэгдсэнээс зарим элементүүдийн агууламж өссөн байх магадлалтайг харуулж байна.

6. Буйр нуурын усны шинжилгээнд мэдэгдэхүйц бохирдол, өөрчлөлт илрээгүй.

### 9.3. Хөрсний хяналт шинжилгээ

Судалгааны аргазүй: Хөрсний хээрийн судалгааг 2025 оны VI, VIII, IX саруудад хийж гүйцэтгэсэн. Нийт 27 цэгээс хүнд элементийн 24 дээж, агрохимийн буюу ерөнхий хими, физикийн 7, нефтийн бүтээгдэхүүн буюу органик нүүрстөрөгчийн нийт 6 дээжийг 3 удаагийн хээрийн судалгаагаар цуглуулсан.

Лабораторийн задлан шинжилгээ: Хээрийн судалгаагаар талбайгаас цуглуулсан хөрсний дээжинд ерөнхий хими, физикийн үзүүлэлтүүд болон органик нүүрстөрөгчийн агууламжийг ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн Хөрс судлалын лабораторид, хүнд элементийн агууламжийг “SGS IMME Mongolia” ХХК-ий Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.

№	Хөрсний үзүүлэлтүүд	Задлан шинжилгээний арга	Стандарт
1	Ялзмаг	Тюрин ( <i>Walkley, Black</i> )	MNS 3310: 1991 Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга.
2	Урвалын орчин	Ионометр	MNS ISO 10390: 2001 Хөрсний чанар. рН тодорхойлох.
3	Карбонат	Кальциметр (10% HCl)	MNS 3310: 1991 Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга.
4	Хөдөлгөөнт фосфор	Спектрофотометр	
5	Хөдөлгөөнт кали	Дөлөн фотометр	
6	ЕС-MNS ISO 10390:2001	Кондуктометр	
7	Механик бүрэлдэхүүн	Гидрометр	ISO 11277:2009 Soil quality - Determination of particle size distribution in mineral soil material - Method by sieving and sedimentation
8	Хүнд металлууд	Optical Spectrometer	

Хүснэгт-33. Лабораторийн задлан шинжилгээний арга болон стандарт

Зураглал: Судалгааны талбайтай холбогдолтой зураглалын ажлуудад дараах мэдээллүүдийг ашиглан ArcGIS 10.8.2 программ хангамж дээр боловсруулалт хийсэн.

- SRTM (Shuttle Radar Topography Mission) гадаргын өндөршлийн зураг
- 1:100000 масштаб бүхий Монгол орны хөрсний зураг
- Google Maps Imagery гадаргын суурь зураг

- Байгаль орчны мэдээллийн сангийн вектор мэдээнүүд (улсын хил, аймгийн хил, сумын хил, аймгийн төв, сумын төв)

Хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээ

Хөрсөн бүрхэвчийн тархалт, шинж чанар: XXI талбай нь Монгол орны хуурай болон хуурайвтар хээрийн бүсд байрлана. Гадаргын өндөршлийн хувьд далайн түвшнээс дээш 576-709 метр орчимд хэлбэлзэх бөгөөд өндөржилтийн хэлбэлзэл бага байна. Монгол орны зүүн хэсэгт маш том талбайг хамрах Мэнэнгийн талд бүхэлдээ багтах бөгөөд энд томоохон уул, нурууд байхгүй харьцангуй тэгширхэг талын экосистемтэй. XXI талбай нь Монгол орны Физик-Газарзүйн мужлалтаар Монголын дорнод талын их мужийн Дорнодын тэгш талын мужийн Тамсагийн талын тойрогт багтана. Харин Хөрс-Газарзүйн мужлалтаар Хангайн их мужийн Хотгорын бүшилтэй нутгийн Монголын дорнод мужийн Мэнэн-Матадын 19-р тойрог, Тамсагбулагийн 21-р тойрогт багтаж байна.

Хөрсөн бүрхэвчийн хэв шинжийн тархалтын хувьд тал хээрийн бүсэд зонхилох жинхэнэ хүрэн болон хүрэн шороон хөрс тархаж байна. Нам дор хотос, хонхоруудаар хужир мараалаг хөрс болон нугын хөрс зонхилон тархана.

Жинхэнэ хүрэн хөрс: Хуурай хээрийн бүсийн өмнөд хэсгээр, эсвэл хархүрэн хөрстэй талархаг нутгийн доторхи уудам хотгоруудад харгана бүхий үетэнт, агь-үетэнт ургамалшилтай газраар тархах бөгөөд ургамал нөмрөгийн бүрхэц нь 30-50% байна. Хөрсний чийгийн хангамж төдий л сайн биш, зуны хамгийн их хур бороотой үед ус чийг хөрсөнд дөнгөж 20-40 см хүртэл нэвчдэг тул түүнээс дооших хэсэг нь хуурай голдуу байна. Хөрсний үе давхарга үүнээс гүн чийглэгдэх нь ховор. Хүрэн хөрсний ялзмаг хуримтлалын давхарга нь хархүрэн хөрснийхийг бодвол нимгэн, өнгөөр мэдэгдэхүйц гэгээтэй, карбонатын давхарга нь арай дээрээс эхэлдэг.

Чийгт хэлбэрийн хужир хөрс: Энэ хэвшинжийн хөрс хээрийн болон заримдаг цөлийн бүсэд, мөн говийн баянбүрдүүдэд түрүүчийн хөрсийг бодвол нилээн түгээмэл тархсан байна. Ер нь манай орны хужир хөрсний дийлэнх нь чийгт хэлбэрийнх гэж болно. Ийм хөрс газрын доорх усны түвшин 1-2.5м гүнд буюу заримдаа түүнээс ч дээхнүүр оршдог, ууршилт хүчтэй явагдах боломжтой өвөрмөц нөхцөлд тогтворждог байна. Ус чийг нь байнга өөдөө хөөрч гадагшаа алдагдах учраас хөлрөх маягийн чийгийн горимтой гэж үздэг. Хөрсний гүнээс дулаан улирлын турш их хэмжээний ус дээшээ хөөрч дэгдэхдээ бүх үе давхаргуудыг нь нэвт дамжиж гадагшаа ууршиж алдагдах бөгөөд устай цуг түүнд ууссан давсны нэгдлүүд мөн өөдөө хөөрч хөрсний өнгөн давхаргад хүрээд тэндээ тунаж

хуримталсаар хужир марз болж тогтдог байна. Ингэж үүссэнийг чийгт хэлбэрийн хужир хөрс гэнэ (Доржготов, 2003).

Мониторингийн цэгүүд: Хөрсний мониторингийн цэг SMP-1 (Төв кемпийн зогсоол): Энэ цэгт хөрсний гадарга нь сайжруулсан шороон замын нөлөөгөөр хөрсний гадарга нь хүчтэй талхлагдсан, ургамал бүрхэвчгүй, хөрсний өнгөн хэсэг хайрган хучилттай, элс болон давсныг хуримтлал байхгүй, гадарга дээр хатуу шингэн хог хаягдалгүй.

### Ерөнхий хими, физик шинж чанарын үр дүн

Хөрсний ялзмагийн агууламж: Ялзмагийн бодис нь ойролцоогоор 60% нүүрстөрөгч, 6% азот болон фосфор, хүхэр зэрэг макро, микро элементүүдийг өөртөө агуулж байдаг. Ялзмагийн бодис их байх тусам хөрсний өнгө гүн хар болдог.




График-31. Ялзмагийн агууламж

Хөрсний урвалын орчин-pH: Энэхүү үзүүлэлт нь хөрсний хүчиллэг болон шүлтлэгийг тодорхойлох үзүүлэлт болдог. Хөрсний pH-ээс шалтгаалж тухайн хөрсөнд явагдах химийн үйл явцууд шууд болон урвуу хамааралтай байдаг. 6.6-7.3 хооронд буюу саармаг шинжтэй байхад ургамал ургах таатай орчин бүрддэг.

	pH		pH
Хэт хүчиллэг	< 3.5	Саармаг	6.6–7.3
Туйлын хүчиллэг	3.5–4.4	Сул шүлтлэг	7.4–7.8
Маш хүчтэй хүчиллэг	4.5–5.0	Дунд шүлтлэг	7.9–8.4
Хүчтэй хүчиллэг	5.1–5.5	Хүчтэй шүлтлэг	8.5–9.0
Дунд хүчиллэг	5.6–6.0	Маш хүчтэй шүлтлэг	> 9.0
Сул хүчиллэг	6.1–6.5		

Хүснэгт-34. Хөрсний урвалын орчны шинж чанар




График-32. Хөрсний урвалын орчин

Дээрх графикаас харахад бүх цэгт урвалын орчин 5.78-8.97 хооронд хэлбэлзэх бөгөөд энэ нь дунд хүчиллэгээс хүчтэй шүлтлэг орчинг илэрхийлнэ. 2024 оны 7-р сарын судалгаагаар бүх цэгт урвалын орчин хамгийн өндөр буюу 8.73-8.97 хооронд байна. Хүчтэй шүлтлэг орчинг үзүүлж байна. 2022 он, 2023 оны 7 болон 9-р саруудад хамгийн бага урвалын орчинтой байжээ.

**Хөрсний карбонат:** Хөрсний карбонат гэдэг нь нүүрстөрөгчийн гуравч исэлтэй (CO<sub>3</sub>) нэгдсэн газрын металлуудын (Ca, Mg) давс юм. Карбонат нь хөрсний pH-ийн орчин суурилаг буюу шүлтлэг шинж чанартай байгааг илэрхийлдэг. Карбонатын тархалт, хэмжээ нь хөрсний үржил шим, элэгдэлд тэсвэртэй байдал, боломжит чийгийн багтаамжид нөлөөлдөг. Карбонат 0 байвал карбонатжаагүй, 0-2% сул, 2-10% дундаж, 10-25% хүчтэй, >25% маш хүчтэй карбонатжсан гэж ангилдаг.




График-33. Хөрсний карбонат

Лабораторийн дүнгээс харахад 2022 болон 2023 онуудад бүх цэгт карбонат илрээгүй. 2024 болон 2025 онуудын 6, 9-р саруудад SMP-7 цэг 0.76-1.82 хэмжээтэй карбонат илэрсэн байна. Энэхүү цэг нь N506-246 дугаартай цооног юм. Илэрсэн агууламжаас харахад тухайн цэг нь сул карбонатжсан байна. Бусад хугацаанд бүх цэгт карбонатжаагүй буюу давсжилтгүй байна.

Хөрсний цахилгаан дамжуулах чадвар буюу хялбар уусах давс: ЕС буюу хөрсний цахилгаан дамжуулах чанар нь хөрсөн дэх усанд хялбар уусах давсны хэмжээг (хөрсний давсжилт) тодорхойлдог үзүүлэлт юм.




График-34. Хөрсний цахилгаан дамжуулах чадвар

Цахилгаан дамжуулах чадвар 0.75 dS/m хэмжээнээс бага байвал давсжилтгүй гэж үздэг. Судалгааны хугацаагаар харьцуулж үзвэл 2022 онд 0.11 dS/m, 2023 онд 0.076 dS/m, 2024 онд 0.074 dS/m, 2025 онд 0.081 dS/m байна. Давсжилтийн хэмжээ 2022 онд хамгийн өндөр байсан бол түүнээс хойш тогтвортой хэмжээнд байна.

Хөрсний хөдөлгөөнт фосфор, калий: Хөрсний фосфор, кали (P,K) нь ургамлын шим тэжээлийн хамгийн чухал анхдагч макро элементүүд бөгөөд эдгээрээс нэг нь л дутагдахад ургамал ургах боломжгүй болдог. Фосфорын пентоксидаг агууламжаар нь <1мг/100гр бол маш бага хангамжтай, 1-1.5 мг/100гр бол бага хангамжтай, 1.5-3.0 мг/100гр бол дундаж хангамжтай гэж үнэлдэг. Кали (K) нь өсөлт хөгжил болон бусад олон процессуудад чухал хэрэгтэй байдаг. Кали нь ихэвчлэн "чанарын элемент" гэж нэрлэгддэг бөгөөд ургамлын чанар, хэмжээ, хэлбэр, өнгө, амт гэх мэт олон шинж чанаруудад нөлөөлдөг. Хөрсөн дэх калийн исэл (K<sub>2</sub>O) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Калийн исэл (K<sub>2</sub>O)-ийг агууламжаар нь <10 мг/100гр бол маш бага хангамжтай, 11-20 мг/100гр бол бага, 21-30 мг/100гр бол дундаж хангамжтай гэж үнэлдэг.




График-35. Хөдөлгөөнт фосфор

XXI талбайн дээжнүүдийн хувьд 0.2-1.45 мг/100гр хооронд хэлбэлзэж байна. Тиймээс бүх дээж фосфорын хангамж маш бага болон бага түвшинд байна. 7 цэгийг харьцуулж үзвэл SMP-7 цэг 0.8 мг/100гр, SMP-8 цэг 0.76 мг/100гр, SMP-13 цэг 0.45 мг/100гр, SMP-19 цэг 0.89 мг/100гр, SMP-20 цэг 0.31 мг/100гр, SMP-23 цэг 0.93 мг/100гр, SMP-25 цэг 0.33 мг/100гр тус тус агууламжтай байна.

Судалгааны хугацаагаар харьцуулж үзвэл 2022 онд 0.5 мг/100гр, 2023 онд 0.78 мг/100гр, 2024 онд 1.01 мг/100гр, 2025 онд 0.56 мг/100гр байна. Хөдөлгөөнт фосфорын хэмжээ 2022-2024 оны хооронд тогтмол өссөн дүнтэй байсан бол 2025 онд өмнөх оноос огцом буурсан.




График-36. Хөдөлгөөнт калий

Дээрх графикаас харахад бүх цэгт хөдөлгөөнт калий 6.5-21.7 мг/100гр хооронд хэлбэлзэх бөгөөд энэ нь бага, маш бага болон дундаж хангамжтай байна. 2024 оны 7-р сарын судалгаагаар бүх цэгт калий хамгийн өндөр буюу 10.2-18.2 мг/100гр хооронд байна. 2024 оны 6-р сард хамгийн бага калийн хангамжтай байжээ.

**Хөрсний механик бүрэлдэхүүн:** Хөрсний механик бүрэлдэхүүн нь 2 мм-ээс жижиг ширхэгтэй элс, тоос, шавар гэсэн хатуу хэсгүүдийн харьцаагаар илэрхийлэгдэх бөгөөд эдгээрээс аль фракц нь зонхилж байгаагаас хамаарч тухайн хөрсний механик бүрэлдэхүүний нэршил хамаардаг.




График-37. Хөрсний механик бүрэлдэхүүн, элсэн фракци

Бүдүүн ширхэгтэй элсэн фракци хөрсний бүтцийн 63-88% эзэлж байна. SMP-7 цэгийн дундаж элсний хэмжээ 79.8%, SMP-8 цэг 77.13%, SMP-13 цэг 78.73%, SMP-19 цэг 74.07%, SMP-20 цэг 82.73%, SMP-23 цэг 78.35%, SMP-25 цэг 79.43%-ийг эзэлж байна. Харин мониторингийн хугацаагаар харвал 2022 онд элсний хэмжээ 84.0%, 2023 онд 67.5%, 2024 онд 81.5%, 2025 онд 80.7% эзэлж байна.





График-38. Хөрсний механик бүрэлдэхүүн, тоосны фракци


0.05-0.002 мм хэмжээтэй тоосны фракци хөрсний бүтцийн 2-26% эзэлж байна. SMP-7 цэгийн дундаж тоосны хэмжээ 11.14%, SMP-8 цэг 12.91%, SMP-13 цэг 13.3%, SMP-19 цэг 15.12%, SMP-20 цэг 7.3%, SMP-23 цэг 11.99%, SMP-25 цэг 11.93%-ийг эзэлж байна. Харин мониторингийн хугацаагаар харвал 2022 онд

*XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН*

тоосны хэмжээ 8.0%, 2023 онд 21.3%, 2024 онд 9.3%, 2025 онд 10.19% эзэлж байна.



*График-39. Органик нүүрстөрөгчийн агууламж*



*График-40. Хөрсний механик бүрэлдэхүүн, физик шавар*

Дээжний дугаар	2022.VII	2023.VII	2023.VIII	2023.IX	2024.VI	2024.VII	2024.IX	2025.VI	2025.VIII	2025.IX
SMP-5	0.57	6.21	0.73	0.25	6.81	1.008	0.655	0.272	0.133	0.345
SMP-9	0.24	2.17	0.214	7.7	6.51	0.871	0.666	0.347	0.339	0.295
SMP-10	0.59	6.09	0.243	0.06	4.62	0.444	0.183	0.307	0.219	0.309
SMP-23		6.03	0.712	0.21	7.55		0.602	0.687	0.867	0.796
SMP-25	0.43	5.67	0.192	0.23	8.75	0.914	0.582	0.735	0.713	0.784
SMP-27	0.34	5.05	0.72	0.57	4.9	0.833	0.512	0.314	0.336	0.492
<b>MNS5850:2019</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>8</b>

*Хүснэгт-35. Хөрсний органик нүүрстөрөгч*

Органик нүүрстөрөгчийн агууламжаас харахад N488-168 цооногийн SMP-5 цэг нийт 10 удаагийн хэмжилтийн дундаж агууламж 1.7% байна. 2024 оны 6-р сард 6.81% байсан нь хамгийн өндөр үзүүлэлт бол 2025 оны 8-р сард 0.13% хамгийн бага үзүүлэлт байна. Стандартаас давсан дүн гараагүй байна.

**Хөрсний бохирдол:** XXI талбайн нийт 24 цэгээс хүнд элементийн дээжлэлт хийсэн. Дээжнүүдийг “SGS IMME” хөрсний лабораторид шинжлүүлсэн бөгөөд нийт 33 элементийн шинжилгээг хийсэн.

**Хүнцэл:** 2022 оноос хойш бүх судалгаанд хүнцлийн агууламж стандарт даваагүй буюу бохирдолгүй гэсэн үр дүнтэй гарсан байна. Харин 2023 оны 9-р сарын судалгаанд төв кемпийн SMP-1 цэгт 47 мг/кг хэмжээтэй илэрсэн нь стандарт давсан ганц үзүүлэлт болсон.

2022 оны хүнцлийн дундаж агууламж 2.67 мг/кг, 2023 онд 2.02 мг/кг, 2024 онд 5.42 мг/кг, 2025 онд 4.36 мг/кг тус тус агууламжтай гарсан байна. 2024 онд хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан боловч стандартаас 4 дахин бага агууламж юм. 2022 оны 9-р сар, 2023 оны 7-9 саруудад дийлэнх цэгүүдэд хүнцэл илрээгүй байна.




График-41. Хүнцлийн агууламж

**Кобальт:** Энэхүү элемент нь хортой хүнд металлын жагсаалтад багтах бөгөөд хүн, амьтан, ургамлын өсөлт хөжилтөд сөргөөр нөлөөлдөг. MNS 5850:2019 стандартад зөвшөөрөгдөх дээд хэмжээг 50 мг/кг гэж тогтоосон.




График-42. Кобальтийн агууламж

Нийт 24 цэгийн 11 удаагийн хэмжилтийн үр дүнг дээрх графикт харууллаа. Эдгээр бүх хэмжилтүүд стандартаас хэд дахин бага хэмжээнд байна. 2024 оны 9-р сард авто баазийн орчмын SMP-30 цэгт 8 мг/кг гарсан нь хамгийн өндөр үзүүлэлт

болж байна. 24 цэгийн дундаж кобальтийн агууламж 2.55-3.27 мг/кг хооронд хэлбэлзэх бөгөөд энэ нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 15-22 дахин бага дүн юм. Хром: Энэхүү элемент нь хортой хүнд металлын жагсаалтад багтах бөгөөд хүн, амьтан, ургамлын өсөлт хөжилтөд сөргөөр нөлөөлдөг. MNS 5850:2019 стандартад зөвшөөрөгдөх дээд хэмжээг 150 мг/кг гэж тогтоосон.




График-43. Хромын агууламж

Дээрх графикаас харахад бүх цэгийн агууламж хүлцэх хэмжээнээс хэд дахин бага байна. 2025 оны 6-р сард Ахуйн цэвэрлэх байгууламжийн SMP-3 цэгт 45 мг/кг гарсан нь хамгийн өндөр үзүүлэлт болох бөгөөд стандартаас 3 дахин бага дүн юм. Бүх цэгийн дундаж хромын агууламж 11.55-16.09 мг/кг хооронд байна. Стандарттай харьцуулж үзвэл 9-13 дахин бага агууламжтай байна. SMP-23 цэгийн байгалийн хөрсний дундаж агууламж 15.0 мг/кг байгаа бөгөөд зөвхөн SMP-22 цэгийн дундаж агууламж л энэ хэмжээнээс өндөр гарсан байна.

**Зэс:** Энэхүү элемент нь хортой хүнд металлын жагсаалтад багтах бөгөөд хүн, амьтан, ургамлын өсөлт хөжилтөд сөргөөр нөлөөлдөг. MNS 5850:2019 стандартад зөвшөөрөгдөх дээд хэмжээг 100 мг/кг гэж тогтоосон.





График-44. Зэсийн агууламж

Зэсийн агууламж SMP-3 цэгт 2025 оны 6-р сард 336 мг/кг агууламжтай гарсан нь хамгийн өндөр үзүүлэлт болох бөгөөд стандартаас 3 дахин өндөр агууламжтай байна. Бусад цэгүүдэд стандарт хэтэрсэн дүн байхгүй. Нийт 24 цэгийн дундаж

агууламж 2022 онд 5.32 мг/кг, 2023 онд 6.11 мг/кг, 2024 онд 9.04 мг/кг, 2025 онд 14.29 мг/кг хэмжээнд байна. Дундаж агууламж байнга өсч байгаа боловч хамгийн өндөр дүн нь хүлцэх хэмжээнээс 7 дахин бага байна.

Байгалийн горимтой харьцуулж үзвэл тухайн цэгт зэсийн дундаж агууламж 10.2 мг/кг байгаа бөгөөд SMP-1 болон SMP-3, цэгүүдийн дундаж өндөр агууламжтай байна. Нийт 24 цэгийн дундаж агууламж 4.29-35.85 мг/кг хооронд хэлбэлзэж байна.

**Хар тугалга:** Энэхүү элемент нь хортой хүнд металлын жагсаалтад багтах бөгөөд хүн, амьтан, ургамлын өсөлт хөжилтөд сөргөөр нөлөөлдөг. MNS 5850:2019 стандартад зөвшөөрөгдөх дээд хэмжээг 100 мг/кг гэж тогтоосон.



**График-45. Хар тугалгын агууламж**

Хар тугалга нь машин, техникт ашиглагдах түлш болон тосолгооны материалд ихээр агуулагддаг. Тухайн талбайн 24 цэгийн хувьд SMP-03 цэгт 2025 оны 6-р сард 126 мг/кг агууламжтай гарсан нь хамгийн өндөр дүн болж байна. Энэ нь хүлцэх агууламж давсан байна. Хар тугалгын дундаж агууламж 2022 онд 14.92 мг/кг, 2023 онд 14.97 мг/кг, 2024 онд 17.38 мг/кг, 2025 онд 17.86 мг/кг байгаа бөгөөд жил бүр өссөн дүнтэй байна. Гэвч хамгийн өндөр дундажтай гарсан 2025 оны хувьд стандартаас 6 дахин бага хэмжээтэй байна.

Байгалийн гормын хяналтын цэгт 15.5 мг/кг агууламжтай гарсан бөгөөд бусад цэгүүд энэ хэмжээтэй ойролцоо буюу 13.73-25.91 мг/кг хооронд хэлбэлзэж байна. SMP-3 цэгт 2025 оны 6-р сарын хэмжилтээр хүлцэх агууламж өндөр гарсан боловч хэмжилтийн бусад хугацаанд 10-26 мг/кг гарсан учир бохирдолтой гэж үзэх боломжгүй байна.

**Цайр:** Энэхүү элемент нь хортой хүнд металлын жагсаалтад багтах бөгөөд хүн, амьтан, ургамлын өсөлт хөжилтөд сөргөөр нөлөөлдөг. MNS 5850:2019 стандартад зөвшөөрөгдөх дээд хэмжээг 300 мг/кг гэж тогтоосон байна.




График-46. Цайрын агууламж

Цайрын агууламж бүх цэгт 10-119 мг/кг хооронд хэлбэлзэж байна. Үүнээс 2022 оны 7-р сард Туслан гүйцэтгэгч анги-1 орчимд 119 мг/кг гарсан нь хамгийн өндөр үзүүлэлт болох бөгөөд стандартаас 2-3 дахин бага байна. Цайрын дундаж агууламж 2022 онд 27.08 мг/кг, 2023 онд 21.96 мг/кг, 2024 онд 23.21 мг/кг, 2025 онд 21.47 мг/кг байна. 2022 онд хамгийн өндөр хэмжээнд байгаа боловч хүлцэх агууламжаас 11 дахин бага байна. Байгалийн горим хяналтын цэгт цайр дунджаар 23.7 мг/кг агууламжтай байгаа бол SMP-1, SMP-2, SMP-3, SMP-14, SMP-22, SMP-27 цэгүүд энэ хэмжээнээс өндөр буюу 23.9-31.2 мг/кг хооронд хэлбэлзэж байна.

XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

	As			Co			Cr			Cu			Pb			Zn		
	2025.VI	2025.VIII	2025.IX	2025.VI	2025.VIII	2025.IX	2025.VI	2025.VIII	2025.IX	2025.VI	2025.VIII	2025.IX	2025.VI	2025.VIII	2025.IX	2025.VI	2025.VIII	2025.IX
SMP-1	8	6	5	4	3	3	11	12	14	20.7	46.5	7.5	16	16	21	20	20	34
SMP-2	6	0	9	2	3	2	11	15	11	4.4	15.6	6.1	16	17	22	19	23	27
SMP-3	3	0	16	5	3	2	45	12	13	336	12.7	6	126	16	26	39	22	44
SMP-4	6	10	3	3	3	4	12	15	21	7.5	13.1	6.3	15	14	18	20	19	25
SMP-6	0	0	0	3	3	2	15	13	12	5.9	6.8	3.8	16	18	13	25	27	13
SMP-8	0	5	7	3	3	3	14	14	15	7.1	4.9	6.8	19	27	17	25	23	20
SMP-9	5	0	5	2	3	3	8	12	13	3.7	4	3.9	12	14	12	12	16	17
SMP-10	7	8	3	2	3	3	12	11	14	3.3	3.2	5.2	17	16	15	17	15	21
SMP-11	12	5	0	3	3	2	14	14	11	5	3.3	3.5	17	16	13	24	18	16
SMP-13	0	4	0	3	3	3	12	11	19	5.1	4	5.3	17	18	17	19	20	23
SMP-14	10	11	5	2	4	3	9	14	17	5.9	29.8	12.5	14	17	21	23	35	56
SMP-15	3	0	5	3	3	3	14	14	16	4.7	18.7	5.2	16	16	16	22	20	20
SMP-16	0	0	4	2	3	2	10	13	12	3.6	32.4	3.9	19	16	15	19	19	18
SMP-18	19	12	4	4	3	3	15	14	18	4.2	5.2	5.4	17	16	16	21	21	21
SMP-20	10	0	0	4	2	3	17	10	15	4.4	3.5	5.7	19	15	14	22	16	21
SMP-21	0	0	0	3	3	2	16	14	13	5.2	17.8	4.5	18	17	15	24	19	20
SMP-22	0	0	13	3	3	3	42	13	15	8.8	18.1	18.4	15	17	19	23	21	28
SMP-23	0	6	6	3	4	3	16	13	13	5.5	46.7	6.6	17	16	13	22	21	20
SMP-25	4	12	0	3	3	3	15	14	17	4.9	19.5	4.8	17	18	16	20	18	21
SMP-27	4	5	0	2	2	2	14	10	11	5	14.2	4.3	17	13	14	20	15	14
SMP-28	9	9	3	3	4	4	14	17	19	5.3	45.7	5.7	15	19	17	18	21	33
SMP-30	0	0	9	2	2	2	10	8	19	3.3	17.2	4.5	14	12	13	15	10	15
SMP-32	0	0	7	3	4	3	15	20	18	4.2	27.3	5.9	16	18	17	19	24	23
SMP-33	6	5	0	3	3	3	11	9	14	3.8	5.2	4.1	14	12	13	16	13	16
MNS 5850:20 19	20			50			150			100			100			300		

Хүснэгт-36.2025 оны хөрсний хүнд элементийн дүн

**Дүгнэлт:** Дорнод аймгийн Халхгол, Матад сумдын нутгийг дамнах XXI талбайд хээрийн судалгааг 2025 оны 6, 8, 9-р саруудад хийж гүйцэтгэсэн. Мониторингийн тайлангийн хувьд 2022 оны 7 болон 9-р сар, 2023 оны 7-9 сар, 2024 оны 6, 7, 9 саруудтай харьцуулж бичсэн.

Ялзмагийн агууламж 2025 оны 8-р сард SMP-19 цэгт 2.09% гарсан нь хамгийн өндөр дүн болох бөгөөд бусад цэгт түүнээс доош байгаа бөгөөд агууламжийн хувьд бага болон маш бага хэмжээнд байна. 2024 оны 7-р сард хамгийн их, 2023 оны 9-р сард хамгийн бага агууламжтай байна. 2022 онд нийт цэгийн дундаж ялзмагийн агууламж 0.88%, 2023 онд 0.77%, 2024 онд 1.14%, 2025 онд 1.12% байна. Ялзмагийн агууламж 2024 болон 2025 онд хамгийн өндөр хэмжээнд хүрч өссөн байна.

Урвалын орчин 5.78-8.97 хооронд хэлбэлзэх бөгөөд энэ нь дунд хүчиллэгээс хүчтэй шүлтлэг орчинг илэрхийлнэ. 2022 болон 2023 онуудад бүх цэгт карбонат илрээгүй. 2024 оны 6, 9-р сар, 2025 оны 6, 9-р саруудад SMP-7 цэгт 0.73-1.82% хэмжээтэйгээр илэрсэн байна. Илэрсэн агууламжаас харахад тухайн цэг нь сул карбонатжсан байна. Бусад цэгүүд карбонатжаагүй буюу давсжилтгүй байна.

Цахилгаан дамжуулах чадварын хувьд 0.026-0.224 dS/m хооронд хэлбэлзэж байна. Тиймээс бүх дээж давсжилтгүй байна. Судалгааны хугацаагаар харьцуулж үзвэл 2022 онд 0.11 dS/m, 2023 онд 0.076 dS/m, 2024 онд 0.074 dS/m, 2025 онд 0.081 dS/m байна. Давсжилтийн хэмжээ 2022 оноос хойш буурсан дүнтэй байна.

2024 оны 6-р сард SMP-25 буюу нэгдсэн байгууламжийн баруун тал орчимд органик нүүрстөрөгч хүлцэх агууламжаас үл ялиг хэтэрсэн дүнтэй байгаа боловч 7 болон 9-р саруудад буцаад хэвийн хэмжээнд очсон байна. Хугацаагаар нь харьцуулж үзвэл дундаж агууламж 2022 онд 0.43%, 2023 онд 2.39%, 2024 онд 2.62%, 2025 онд 0.46% байна. Хяналтын цэгтэй харьцуулж үзэхэд бүх цэгт органик нүүрстөрөгчийн агууламж бага хэмжээнд байна.

Хүнд элементийг хүнцэл, кобальт, зэс, цайр, хар тугалга, хромын агууламжийг нийт 24 цэгт 11 удаагийн хэмжилтээр харьцуулж үзсэн.

#### **9.4. Ургамлын нөмрөгийн хяналт**


Судалгааны талбайн 2025 оны ургамлан нөмрөгийн мониторинг судалгааг 6, 8, 9-р саруудад нийт 3 удаагийн хээрийн хэмжилт судалгааны мэдээлэлд үндэслэн, үр дүнг 2022-2025 оны судалгааны үр дүнтэй харьцуулан боловсрууллаа.



**Зураг-18. Ургамлан нөмрөгийн төлөв байдал 6-р сар VP-23 цэг, 2025.06.15**



**Зураг-19. Ургамлан нөмрөгийн төлөв байдал 8-р сар VP-23 цэг, 2025.08.02**



**Зураг-20. Ургамлан нөмрөгийн төлөв байдал 9-р сар VP-23 цэг, 2025.09.11**

### Ургамлан нөмрөгийн судалгаа хийсэн арга зүй

Ургамалжилтын судалгааг хийхдээ ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, түүний өөрчлөлтийг Друдегийн аргаар, тусгаг бүрхцийг Л.Г.Раменскийн аргаар тодорхойлсон. Геоботаникийн бичиглэл хийхдээ тухайн ургамлын мониторингийн цэгийг төлөөлүүлэн 1x1 м<sup>2</sup> болон 10 x10 м<sup>2</sup> талбайд раменскийн тор ашиглан тодорхойлсон бөгөөд санамсаргүй байрлуулан цэг тус бүрээр бичиглэл хийж, хээрийн судалгааны мэдээ материалуудад үндэслэн ургамлын тайланг боловсруулсан.

Зүйлийн бүрэлдэхүүн: Ургамалжилтын зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо зүйл тус бүрийг флорын баялаг тодорхойлох аргаар бүртгэж, зүйлийн латин, Монгол нэрийг И.В.Грубовын (1982) бүтээлд зааснаар тус тус нэрлэсэн.


Арви: Ургамалжилтын зүйлийн арвид О.Друдегийн нүдэн баримжааны аргаар үнэлгээг өгсөн.

Тусгаг бүрхэц: Ургамалжилтын зүйлийн тусгаг бүрхцийг Раменскийн 1 м<sup>2</sup>-ийн хэмжээст тороор тодорхойлсон.

#### Хүснэгт-37. Ургамлан бүрхэвчийн арви ба бүрхцийн үнэлгээ


Арви	Тусгаг бүрхэц, %	Ургамлын тохиолдоц, тархалтын шинж
Soc- Socialis	75 %, <	Ургамал маш ихээр буюу нэлэнхүйд нь тархсан
Cop3- Copiosae 3	51 -75 %	Ургамал ихээр биш буюу нэлэнхүйд нь тархсан
Cop2- Copiosae 2	26 - 50 %	Ургамал нэлээд ихээр тархсан
Cop1- Copiosae 1	11 - 25 %	Ургамал дунд зэрэг тархсан
Sp- Sparsae	5 - 10 %	Ургамал бага зэрэг тархсан
Sol- Solitaires	1 -2 %	Ургамал хааяа нэг тохиолдоно
Rr-Rare	1>	Талбайд зөвхөн ганц нэг тохиолдоно
Un-Unicum	1>	Маш ховор тохиолдоно

Ургац: Мониторингийн цэг тус бүрээс ургацын дээжийг газрын хөрснөөс 0 см өндөрт хайчлан авч ерөнхий ургацыг тодорхойлсон бөгөөд, ургацыг нойтон ба хуурай жинг жигнэж тодорхойлсон.



**Зураг-21. Ургацын дээж авч буй байдал**

NDVI тодорхойлох арга: Ургамлын нормчлогдсон ялгаврын индексийг тодорхойлохдоо “Сэнтинэл 2” хиймэл дагуулын зуны мэдээг ашиглан дүрс зүйн боловсруулалт хийн  $NDVI S2 = \frac{Band8 - Band4}{Band8 + Band4}$  томъёог ашиглаж тодорхойлсон.



**Зураг-22. Ургамлын нормчлогдсон ялгаврын индекс NDVI тодорхойлох арга**

### Судалгааны талбайн ургамлан нөмрөг

Судалгааны талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалтаар Монголын Дорнод талын их муж, Дорнодын тэгш талын муж Тамсагийн талын тойрогт хамаарна. Монгол орныг ургамалжилтын 6 бүс, бүслүүрт ерөнхийлөн хуваадаг ба судалгааны талбай нь Хээрийн бүсэд, Монгол орны ургамал газарзүйн тойргоор Дорнод монголын хуурай хээрийн тойрогт хамаарна (Өлзийхутаг Н).

Дэлхий дээр оршиж байгаа өвслөг ургамал бүхий экосистемийн хамгийн өргөн хүрээтэй нь хээр юм. Судлаачдын үзэж байгаагаар Евроазийн хээр нь 8.0 сая км<sup>2</sup> талбайг эзэлдэг ба үүний 60-70%-ийг хүн төрөлхтөн хот суурин, үйлдвэрийн байгууламж, газар тариаланд ашигласан байна (Зеленая книга Сибири, 1996).


Газар тариалангийн зориулалтаар хагалаагүй үлдсэн 2.3 сая км<sup>2</sup> талбай өнөөдрийн байдлаар зөвхөн Төв Азид үлджээ. Төв Азийн хээр нь өнөө хүртэл биологийн олон янз байдал, экосистемийн олон талт шинж чанарыг хадгалсаар ирсэн нөхөн сэргээгдэх байгалийн генофонд, маш нарийн зохицолтой цогц тогтолцоо юм. Төв Азийн хэмжээнд хээрийн экосистем д.т.д 500 – 3400м өндөрт байршин өргөн уудам нутгийг эзлэн оршино. Хээрийн экосистемийг хээрийн ургамалжилт бүрдүүлдэг. Хээр нь дэлхийн хойд сэрүүн бүсэд тархдаг дэгнүүлт хуурайсаг үетэн (*Stipa*, *Festuca*, *Agropyron*, *Koeleria*, *Cleistogenes*, *Helictotrichon*) зэрэг өвслөг ургамлууд зонхилсон ургамлан бүлгэмдлүүдтэй байдгаараа онцлог юм.

Хээр нь Монгол орны хувьд хамгийн түгээмэл ургамалжлын хэв шинж бөгөөд 1034737.38 км<sup>2</sup> талбай буюу нийт газар нутгийн 66.12%-ийг эзэлдэг бол дэлхийн хээрийн 2.6%-ийг бүрдүүлдэг байна. Монгол орны хээрийн ургамалжил, түүний бүс бүслүүрийн хуваарилалтыг А.А. Юнатов (1948, 1950), Е.М. Лавренко (1987), Е.А. Волкова (1992) нар тодорхойлон бичсэн байдаг. Хуурай хээрийн орших газар нутаг нь зөвхөн хур тунадасны усаар тэжээгдэх бөгөөд хөрсний болон гүний уснаас ямар нэгэн нэмэлт чийг авдаггүйгээрээ бусад ургамалжилтын хэв шинжээс ялгаатай юм.

Монгол орны хээрийг нийт 54 овгийн 227 төрөлд хамаарах элбэг тархацтай 614 зүйлийн дээд гуурст ургамал бүрдүүлдэг бол хуурай хээрийн дэд хэв шинжийг 36 овгийн 120 төрөлд хамаарагдах 250 гаруй зүйл ургамал бүрдүүлдэг байна.

Дорнод монголын хуурай хээрийн тойрог: Уг тойрогт тохиолдох голлох ургамлуудаас дурдвал Том хялгана (*Stipa grandis*), Крыловын хялгана (*Stipa krylovii*), Байгалийн хялгана (*Stipa baicalensis*), Сибирь зүр өвс (*Filifolium sibiricum*), Литвиновын ботууль (*Festuca litvinovii*), Урт дохиурт сонгино (*Allium macrostemon*), Нангиад хиаг (*Leymus chinensis*), Потанины сараана (*Lilium potaninii*), Эгэл годил өвс (*Acorus calamus*), Хар агширгана (*Veratrum nigrum*), Цагаан цээнэ (*Paeonia lactiflora*), Кузнецовын хорс (*Aconitum kuznezoffii*), Дагуур хунчир (*Astragalus dahuricus*), Нарийн навчит харгана (*Caragana stenophylla*), Дагуур сарнай (*Rosa dahurica*), Нангиад гичгэнэ (*Potentilla chinensis*), Цулбуур навчит зогдор өвс (*Clematis aethusifolia*), Урт навчит далан товч (*Androsacea longifolia*), Манж сүүт өвс (*Euphorbia mandschurica*), Тал нүцгэн гичгэнэ (*Potentilla semiglabra*), Шар лидэр (*Sophora flavescens*), Сибирь гүйлс (*Armenica sibirica*), Пржевальскийн тарваган шийр (*Thermopsis przewalskii*), Байгаль гүүн хөх (*Scutellaria baicalensis*),

Ломоносовын хасзул (*Oglaea lomonossowii*), Өргөнийн зохимон (*Senecio argunensis Turcz*) гэх мэт ургамлуудыг дурдаж болно.



**Зураг-23. Төслийн талбайн ургамал газарзүйн тойргийн байршил**

### Судалгааны талбайн ургамлан нөмрөг, өнөөгийн төлөв байдал

Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт “Тамсаг XXI” талбай орчмын нутаг нь газрын гадаргын байдлаараа нэгэн жигд учраас ургамалжилтын хувьд ч мөн нэг төрлийн хэв шинжийн ургамлан бүлгэмдэл зонхилно.

Гадаргын өндөршлийн хувьд далайн түвшнээс дээш 608-899 метр орчимд хэлбэлзэх бөгөөд тал хээрийн бүсэд зонхилох жинхэнэ хүрэн болон хүрэн шороон хөрсний төлөөллийг дагаж хуурай хээрийн Харгана оролцсон Үетэн-Том хялганат (136а, Х-II-4-1) бүлгэмдэл үндсэн хэв шинжийг бүрдүүлэх боловч судалгааны талбайн газрын гадарга, геоморфологийн онцлог, нөлөөллийн эх үүсвэр, газар ашиглалтын байдлаас хамаарч хэд хэдэн жижиг бүлэг хэв шинжид хуваагдана.

Судалгааны талбайн төв хэсгийн үйлдвэр, барилга байгууламж, хотхонуудын барилга, газар ашиглалтын нөлөөгөөр ургамлан нөмрөг дарагдаж, ургах чадвараа алдан, хүчтэй нөлөөлөлд өртсөн байна. Харин өрмийн цооног, авто замын

## XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

хөдөлгөөн зэрэг дам нөлөөлөлд өртсөн талбайн ойр орчмоор Шарилж-үетэнт (128а, Х-II-2-7) бүлгэмдлийг үүсгэх бол харьцангуй нөлөөлөл багатай газраар Шарилж оролцсон Хиаг-Үетэнт (99, Х-I-1-2) болон Алаг өвс-Үетэнт (119, Х-I-3-2) бүлгэмдлүүд тохиолдоно.

Төв хэсгийн нөлөөлөлд өртсөн зам талбай, үйлдвэр, кемп, олборлолтын цооногуудын орчмоор талхагдсан хөрс, ургамлан нөмрөг доройтсон газарт элбэг ургадаг нэг наст амьдралын хэлбэртэй Саваан булгансүүл (*Chloris virgata* Sw.), Үслиг манан хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch. et Mey.) Ktze.), Толгодын бударгана (*Salsola collina* Pall.) шарилжаас Ямаан шарилж (*Artemisia scoparia* Waldst. et Kit) зэрэг нэг наст ургамлууд зонхилон ургасан, өмнө жилүүдийн судалгааны үр дүнтэй харьцуулахад эдгээр зүйлүүдийн арви бага зэрэг нэмэгдсэн байдал ажиглагдсан.

Шарилж, лууль болон бусад хөл газрын ургамал нь хөрсний үржил шим буурч доройтоход их хэмжээгээр ургадаг хэдий ч хөрсний нөхөн төлжилт, ургамалжилт, ногоон масс нэмэгдэх, доройтсон хөрсөнд урган олон зүйл ургамал шинээр ургах таатай нөхцөлийг бүрдүүлдгээрээ чухал үүрэгтэй.

Мөн 2025 оны хэмжилт судалгаагаар олон наст, өвслөг, буурцагт ургамал болох Дагуур хошоон бут (*Lespedeza dahurica* (Laxm.)-ийн бүлгэмдэлд эзлэх арви ихэссэн байдал ажиглагдсан. Дагуур хошоон бут (*Lespedeza dahurica* (Laxm.) нь балт болон тэжээлийн чухал ургамал бөгөөд эмийн чухал түүхий эд болдог. Тус ургамлыг гар тэжээл бэлтгэх замаар уурагт тэжээлийн түүхий эд болгон ашиглах нь зүйтэй. Тус зүйл нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/603 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Нэн ховор, ховор, зарим элбэг ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр элбэг тархалттай ашигт ургамалд багтах бөгөөд хуурай жин 108100 кг/төг, нойтон жин 64900 кг/төгрөгөөр үнэлэгддэг.



**Зураг-24 Дагуур хошоон бутны бүлгэмдэлд зонхилон ургасан байдал, VP2, VP6 цэг**

Харгана оролцсон Үетэн-Том хялганат (136а, X-II-4-1) бүлгэмдэл: Судалгааны талбайн нөлөөлөлд өртөөгүй, хэвийн соргог хэсгээр тархана, мониторингийн цэг VP-5, VP-15, VP-19, VP-21, VP-23, VP-25 цэгүүдэд тухайн ургамлан бүлгэмдэл түлхүү тохиолдоно.

Бүлгэмдлийн ургамлын тусгаг бүрхэц 9 сард дунджаар 68.55%, ургамлын дундаж өндөр 17-19 см, ургац дунджаар 13.2 ц/га, 1 м<sup>2</sup> талбайн зүйлийн баялаг дунджаар 7, 10 м<sup>2</sup> талбайн зүйлийн баялаг дунджаар 14 байна.

Бүлгэмдэлд зонхилогчоор Том хялгана (*Stipa grandis*), Крыловын хялгана (*Stipa krylovii*) сор1-сор3 үнэлгээтэйгээр нийт ургамлын 65-75%-ийг дангаараа эзлэх бол сөөг ургамлаас 2 зүйл харгана болох Нарийн навчит харгана (*Caragana stenophylla*), Бяцхан навчит харгана (*Caragana microphylla*) 5-8%-ийн тусгаг бүрхэцтэйгээр байнга бүлгэмдэлд оролцоно, харин Хиаг (*Elymus chinensis*) 15-10%, Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa*) 10-15%, Саман ерхөг (*Agropyron cristatum*) 10-15%, Криловын хялгана (*Stipa krylovi*) 5-10%, Ширэг Улалж (*Carex duriuscula*) 8-10%, Сибирь хялгана (*Stipa sibirica*) 5-8%-ийн тусгаг бүрхэцтэйгээр бүлгэмдэлд дэд зонхилогчоор тохиолдоно. Бэлчээрийн төлөв байдал хэвийн соргог.



**Зураг-25. Харгана оролцсон Үетэн-Том хялганат бүлгэмдлийн төлөв байдал, 9-р сар**

Дагалдах зүйлээр үетнээс Том цэцэгт дааган сүүл (*Koeloeria macrantha*), Сунагар биелэг (*Poa attenuate*), Байгалийн хялгана (*Stipa baicalensis*), Гялгар дэрс (*Achnatherum splendens*), алаг өвснөөс Сибирь зүр өвс (*Filifolium sibiricum*), Үслиг манан хамхаг (*Bassia dasyphylla*), Дагуурын хүж өвс (*Haplophyllum dauricum*), Дагуур

хатны цэцэг (*Cymbaria daurica*) Агь (*Artemisia frigida*), Хонгорзуллаг хонгорзалаа (*Serratula centauroides*), Их таван салаа (*Plantago major*), Ямаан шарилж (*Artemisia scoraria*), Дагуур хэрээн нүд (*Asparagus dauricus*), Манж сүүт өвс (*Euphorbia mandschurica*), Имт гичгэнэ (*Potentilla bifurca*), Навтуул гичгэнэ (*Potentilla acaulis*), Шүдлэг сонгино (*Allium bidentatum*), Урал чихэр өвс (*Glycerhiza uralensis*), Дагуур хунчир (*Astragalus dahuricus*), Дэрвээн хависгана (*Scrozonera austrica*) зэрэг ургамлууд түгээмэл тохиолдож байна.

Шарилж-үетэнт (128а, X-II-2-7) бүлгэмдэл: Судалгааны талбайн төв хэсгээр болон өрмийн цооног, авто замын хөдөлгөөн зэрэг дам нөлөөлөлд өртсөн талбайн ойр орчмоор тархана, мониторингийн цэг VP2, VP3, VP4, VP7, VP9, VP10, VP13, VP14, VP18 цэгүүдэд тухайн ургамлан бүлгэмдэл түлхүү тохиолдоно.

Бүлгэмдлийн тусгаг бүрхэц 9 сард дунджаар 56%, ургамлын дундаж өндөр 17-19 см, ургац дунджаар 13.2 ц/га, 1 м<sup>2</sup> талбайн зүйлийн баялаг дунджаар 7, 10 м<sup>2</sup> талбайн зүйлийн баялаг дунджаар 14 зүйл тохиолдож байв.

Бүлгэмдэлд зонхилогчоор Ямаан шарилж (*Artemisia scoraria*), Саваан булгансүүл (*Chloris virgata* Sw.), Ногоон хоног будаа (*Setaria viridis*) сор1-сор2 арвитай буюу нийт ургамлын 30-35%-ийн тусгаг бүрхэцтэйгээр зонхилж, Бага хургалж (*Eragrostis minor*), Хиаг (*Elymus chinensis*), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa*), Орос царгас (*Medicago ruthenica*), Ширэг улалж (*Carex duriuscula*), саман ерхөг (*Agropyron cristatum*), Арзгар согсоот (*Heteropappus hispidus*), Үслиг манан хамхаг (*Bassia dasyphylla*) бүлгэмдэлд тогтмол оролцож зарим газраар дэд зонхилогчоор тохиолдоно.



**Зураг-26. Шарилж-үетэнт бүлгэмдлийн төлөв байдал, 9-р сар**

Дагалдах зүйлээр Сибирь гүүн хөх (*Vincetoxicum sibiricum*), Шоргор лууль (*Chenopodium aristatum*), Толгодын бударгана (*Salsola collina*), Дурсгал цэцгэрхүү ноцоргоно (*Larula myosotis*), Өнчин хонгорцгоно (*Leuzea uniflora*) шарилжын

төрлөөс Хурган шарилж (*Artemisia comutata*), Хурган шарилж (*Artemisia commutata* Bess.), буурцагтнаас Нарийн навчит харгана (*Caragana stenophylla*), Бяцхан навчит харгана (*Caragana microphylla*) зэрэг зүйлүүд түгээмэл тохиолдож байна.

Ургамлан нөмрөгийн төлөв байдал антропоген болон техноген нөлөөгөөр дунд зэргийн талхагдалд орж доройтсон.

Шарилж оролцсон Хиаг-Үетэнт (99, X-I-1-2) бүлгэмдэл: Судалгааны талбайн харьцангуй нөлөөлөл багатай газраар тархан ургана, мониторингийн цэгийн VP-1, VP-6, VP-8, VP-11, VP-12, VP-20, VP-22 гэсэн цэгүүдээр гол төлөв тохиолдоно.

Бүлгэмдлийн тусгаг бүрхэц 9 сард дунджаар 56%, шарилж, лууль зонхилж ургасан, ургамлын дундаж өндөр 17-19 см, ургац дунджаар 13.2 ц/га, 1 м<sup>2</sup> талбайн зүйлийн баялаг дунджаар 7, 10 м<sup>2</sup> талбайн зүйлийн баялаг дунджаар 14 зүйл ургамал тохиолдож байв.

Бүлгэмдэлд зонхилогчоор Хиаг (*Elymus chinensis*), Саваан булган сүүл (*Chloris virgata* Sw.), Ямаан шарилж (*Artemisia scoparia*), Ногоон хоног будаа (*Setaria viridis*) зэрэг ургамлууд түгээмэл тохиолдоно.

Дагалдах зүйлээр алаг өвснөөс Цагаан лууль (*Chenopodium album*), Шоргор лууль (*Chenopodium aristatum*), Толгодын бударгана (*Salsola collina*), Дагуур хатны цэцэг (*Cymbaria daurica*), Амманы сэдэргэнэ (*Convolvulus ammannii*), Агь (*Artemisia frigida*), Таван салаа (*Plantago major*), Арзгар согсоолж (*Heteropappus hispidus*), Навтуул гичгэнэ (*Potentilla acaullis*), шарилжаас Адамсын шарилж (*Artemisia adamsii*), Хурган шарилж (*Artemisia commutata* Bess.) зэрэг зүйлүүд түгээмэл тохиолдож байна.

Ургамлан нөмрөгийн төлөв байдал антропоген болон техногены нөлөөгөөр сул доройтсон.



**Зураг-27. Хиаг-Үетэнт бүлгэмдлийн төлөв байдал, 9-р сар**

Алаг өвс-Үетэнт (119, X-I-3-2) бүлгэмдэл: Судалгааны талбайн нөлөөлөлд бага өртсөн хэсгээр тархана, мониторингийн цэг VP16, VP24 цэгүүдэд тухайн ургамлан бүлгэмдэл түлхүү тохиолдоно.

Бүлгэмдлийн тусгаг бүрхэц 9 сард дунджаар 71%, шарилж, лууль зонхилж ургасан, ургамлын дундаж өндөр 18-20 см, ургац дунджаар 13.7 ц/га, 1 м<sup>2</sup> талбайн зүйлийн баялаг дунджаар 8, 10 м<sup>2</sup> талбайн зүйлийн баялаг дунджаар 18 зүйл ургамал тохиолдож байв.

Тухайн бүлгэмдэлд зонхилогчоор Том хялгана (*Stipa grandis*) сор<sup>2</sup> үнэлгээтэйгээр нийт ургамлын 30-35%-ийг дангаараа эзлэх бол үетнээс Хиаг (*Elymus chinensis*) 8-10%, Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa*) 10-12%, Саман ерхөг (*Agropyron cristatum*) 5-10%, Ширэг Улалж (*Carex duriuscula*) 5-10%, алаг өвснөөс Налчгар хэрээн хошуу (*Sibbaldentha adpressa*), Хонгорзуллик Хонгорзалаа (*Serratula centauroides*), Дагуур хатны цэцэг (*Cymbaria dahurica*, L.), Дагуурын хүж өвс (*Harpophyllum dauricum* (L.) G.) sp үнэлгээтэйгээр буюу 5-10%-ийн тусгаг бүрхэцтэйгээр бүлгэмдэлд дэд зонхилогчоор тохиолдоно.



**Зураг-28. Дэрс-Бударганат (185, Ц-II-1-4) бүлгэмдлийн төлөв байдал, 9-р сар, Хөвөө нуур орчим**

Дагалдах зүйлээр үетнээс Том цэцэгт дааган сүүл (*Koeloeria macrantha*), Сунагар биелэг (*Poa attenuate*), алаг өвснөөс Үслиг манан хамхаг (*Bassia dasphylla*), Агь (*Artemisia frigida*), Хонгорзуллик хонгорзалаа (*Serratula centauroides*), Их таван салаа (*Plantago major*), Дагуур хэрээн нүд (*Asparagus dauricus*), Имт гичгэнэ (*Potentilla bifurca*), Навтуул гичгэнэ (*Potentilla acaulis*), Шүдлик сонгино (*Allium bidentatum*), Урал чихэр өвс (*Glycerhiza uralensis*), Дэрвээн хависгана (*Scrozonera*


**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

austrica), буурцагтнаас буурцагтнаас Нарийн навчит харгана (Caragana stenophylla), Бяцхан навчит харгана (Caragana microphylla) зэрэг ургамлууд түгээмэл тохиолдож байна.

Ургамлан нөмрөгийн төлөв байдал хэвийн соргог, зарим хэсгээр сул доройтсон.

**Хүснэгт-38. Ургамлын мониторингийн цэгүүдийн нэр, дугаар, солбицол**

Цэгийн дугаар	Цэгийн нэр	Солбицол	
		Уртраг	Өргөрөг
VP-1	Төв кемпийн зогсоол	116°59'23.03"	47°38'44.78"
VP-2	Туслан гүйцэтгэгч анги-1	116°59'29.19"	47°39'8.20"
VP-3	ТА-2 шингэн хаягдлын сан	116°58'38.36"	47°38'58.63"
VP-4	Цооног N440-84	117°5'19.7"	47°43'48.2"
VP-5	Цооног N488-168	117°1'28.6"	47°40'57.3"
VP-6	Цооног N514-180	117°1'32.0"	47°39'47.5"
VP-7	Цооног N506-246	116°57'36.7"	47°38'52.9"
VP-8	Цооног N502-266	116°56'28.7"	47°38'36.9"
VP-9	7-р хуваарилах	117°02'24.1"	47°40'26.2"
VP-10	12-р хуваарилах	116°56'51.9"	47°38'49.8"
VP-11	Засварын цех	116°59'13.62"	47°38'16.60"
VP-12	ТА-2 Ачилтын талбай	116°58'57.42"	47°38'53.76"
VP-13	Ахуйн цэвэрлэх байгууламж	116°58'36.75"	47°37'49.42"
VP-14	Хатуу хог хаягдлын талбай	116°53'47.67"	47°32'50.16"
VP-15	Үйлдвэрлэлийн шингэн хаягдлын талбай	116°53'49.2"	47°32'22.8"
VP-16	Өрөмдлөгийн талбай (нөхөн сэргэсэн)	116°57'33.69"	47°38'43.19"
VP-17	Химийн бодисын агуулах байсан газар	116°56'56.59"	47°38'30.10"
VP-18	Цацрагийн бодис агуулах орчим	116°59'48.50"	47°39'9.2"
VP-19	21-р талбай явах зам дагуу	116°51'28.97"	47°26'22.82"
VP-20	Экспортын зам дагуу	117°1'36.5"	47°38'58.7"
VP-21	Чойбалсан явах зам дагуу	116°56'39.32"	47°39'55.76"
VP-22	T21-W5 худаг	116°59'47.96"	47°41'8.66"
VP-23	Байгалийн горим	116°58'56.89"	47°42'12.47"
VP-24	Туслан гүйцэтгэгч анги-2	116°58'45.83"	47°39'12.48"
VP-25	Цооног N458-90	117°05'31.1"	47°43'06.8"



Зураг-29. Ургамлын мониторингийн цэгүүдийн байршил

## XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

Ургамлын мониторингийн VP-1 цэг: Тамсаг XXI талбайн “Төв кемп”-ийн зогсоолын дэргэд тухайн орчны ургамлан нөмрөгт үзүүлж буй нөлөөллийг хянах зорилготойгоор тухайн мониторингийн цэгийг байгуулсан байна. Тухайн цэг орчимд Хиаг-Үетэнт (99, X-I-1-2) бүлгэмдэл тархсан байна.

Гол зонхилогч: *Chloris virgata* Sw., *Carex duriuscula* C.A.Mey, *Eragrostis minor* Host, *Heteropappus hispidus* (Thunbg.), *Taraxacum officinale* Wigg., *Chenopodium acuminatum*, *Artemisia commutata* Bess., *Salsola collina* Pall

Дагалдах зүйлүүд: *Plantago major* L, *Lappula myosotis* Moench., *Elymus chinensis* (Trin.) Keng., *Cleistogenes squarrosa* (Trin.) Keng, *Lespedeza dahirica* (Laxm.) Schindl., *Stipa Krylovii* Roshev., *Agropyron cristatum* (L.) P. B., *Salsola collina* Pall., *Bassia dasyphylla* (Ficsh. et Mey.)



**Зураг-30. Ургамлын мониторингийн цэг VP-1**

Ургамлын бүрхэц: 6 сард 44%, 8 сард 46%, 9 сард 57%-ийн бүрхэцтэй байна.

Өнөөгийн төлөв байдал: Автомашины зогсоолын талбай, түүний ашиглалт, машин техник, хүний хөл хөдөлгөөний нөлөөгөөр тухайн орчны ургамлан нөмрөг маш хүчтэй доройтсон байна.

Биомасс: Чийгтэй ургац – 54.1 гр/м<sup>2</sup>, Хуурай ургац – 39.6 гр/м<sup>2</sup>

Тухайн цэгийн бичиглэлээс харахад ургамлын бүрхэц 6 сард 43%, 7 сард 64%, 9 сард 80% болж өөрчлөгдсөн байна. Ургамлын зүйлийн тохиолдцын хувьд авч

**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

үзвэл 1 м2 талбайд 6 сард 6 зүйл тохиолдож байсан бол 7 сард 7 зүйл, 9 сард 5 зүйл тус тус тохиолдож байна. Харин 10 м2 талбайд 6-р сард 4 зүйл, 7-р сард 7 зүйл, 9-р сард 5 зүйл ургамал тохиолдож байна. Тухайн мониторингийн цэгийн ойр орчимд 3 удаагийн мониторинг судалгаагаар нийт 14 зүйл ургамал бүртгэгдэв. Ургамлын дундаж өндөр 15-16 см байна.

Тухайн орчинд 2022 онд 1 м2 талбайд 2-3 зүйл ургамал, 2023 онд 2-4 зүйл ургамал, 2024 онд 5-7 зүйл ургамал тохиолдож байхад 10 м2 талбайд 14 зүйл ургамал тохиолдож байв. Ургамлын бүрхцийн хувьд 2022 онд 10-30%, 2023 онд 20-40%, 2024 онд 43-80%-ийн тусгаг бүрхэцтэй байна.

Энэ үр дүнгээс харахад тухайн орчны ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц болон зүйлийн бүрэлдэхүүн өмнөх жилүүдийн үр дүнгээс нэмэгдсэн байдал ажиглагдаж байна.

**Хүснэгт-39. Ургамлын мониторингийн VP-1 цэгийн бичиглэл**

№	Зүйлийн шинжлэх ухааны нэр	Бүрхэц, %			Арви /VII сар/	Тохиолдоц			Дундаж өндөр, см /VII Iсар/
		VI	VIII	IX		VI	VIII	IX	
1	<i>Chloris virgata Sw.</i>	14	24	54	cop2	+	+	+	6
2	<i>Carex duriuscula C.A.Mey</i>	10	5		sp	+	+		10
3	<i>Eragrostis minor Host</i>	6	9		sp	+	+		6
4	<i>Heteropappus hispidus (Thunbg.)</i>	4	2		sp	+	+		13
5	<i>Taraxacum officinale Wigg.</i>	4			sp	+			6
6	<i>Chenopodium acuminatum</i>	3	3		sol	+	+		5
7	<i>Artemisia commutata Bess.</i>	3	3		sol	+	+		6
8	<i>Salsola collina Pall</i>			3	sol			+	6
Нийт 1 м2 талбайд		44	46	57		7	6	2	7
Дагалдах зүйлүүд									
9	<i>Plantago major L</i>				-	+	+	+	18
10	<i>Lappula myosotis Moench.</i>				-	+		+	24
11	<i>Elymus chinensis (Trin.) Keng.</i>				-	+		+	10
12	<i>Cleistogenes squarrosa (Trin.) Keng</i>				-		+	+	6
13	<i>Lespedeza dahurica (Laxm.) Schindl.</i>				-	+	+		14
14	<i>Stipa Krylovii Roshev.</i>				-	+		+	18
15	<i>Agropyron cristatum (L.) P. B.</i>				-		+	+	8
16	<i>Salsola collina Pall.</i>				-	+	+	+	10
17	<i>Bassia dasyphylla (Ficsh. et Mey.)</i>				-	+	+	+	11
Нийт 10 м2 талбайд		-	-	-	-	15	12	10	13

Ургамлын мониторингийн VP-2 цэг: Тамсаг XXI талбайн “Туслан гүйцэтгэгч анги-1” орчмын ургамлан нөмрөгт үзүүлж буй нөлөөллийг хянах зорилготой тухайн мониторингийн цэгийг байгуулсан байна. Тухайн орчинд алаг өвс-нэг наст үетэнт ургамлан нөмрөгтэй байна. Тухайн цэг орчимд Шарилж-үетэнт (128а, Х-II-2-7) бүлгэмдэл тархсан байна.

Гол зонхилогч: *Lespedeza daturica* (Laxm.) Schindl., *Leuzea uniflora* (L.) Holub., *Carex duriuscula* C.A.Mey., *Artemisia* sp, *Vincetoxicum sibiricum* (L.) Decne, *Lappula myosotis* Moench., *Chenopodium aristatum* L., *Enneapogon borealis* (Greseb.), *Taraxacum officinale* Wigg.

Дагалдах зүйлүүд: *Stipa grandis* P. Smirn., *Stipa Krylovii* Roshev, *Elymus chinensis* (Trin.) Keng., *Artemisia scoparia* Waldst. et Kit., *Artemisia macrocephala* Jacquem., *Serratula centauroides* L., *Chenopodium acuminatum* Willd., *Urtica cannabina* L.



**Зураг-31. Ургамлын мониторингийн цэг VP-2**

Ургамлын бүрхэц: 6 сард 37%, 8 сард 41%, 9 сард 42%-ийн бүрхэцтэй байна.

Биомасс: чийгтэй ургац – 84.3 гр/м<sup>2</sup>, хуурай ургац – 51.1 гр/м<sup>2</sup>

Өнөөгийн төлөв байдал: Ургамлан нөмрөг дам нөлөөлөлд өртөж, бүлгэмдлийн ургамлын тусгаг бүрхцэд хөл газрын ургамлын оролцоо ихэссэн дунд зэргийн доройтсон төлөвтэй байна.

Тухайн цэгийн бичиглэлээс үзэхэд ургамлын бүрхэц 6 сард 37%, 8 сард 41%, 9 сард 42%-ийн бүрхэцтэй байна.

Ургамлын зүйлийн тохиолдцын хувьд авч үзвэл 1 м<sup>2</sup> талбайд 6 болон 3, 8 сард 6 зүйл, 9-р сард 3 зүйл тохиолдож байна. Харин 10 м<sup>2</sup> талбайд 9-12 зүйл тохиолдож байна. Тухайн мониторингийн цэгийн ойр орчимд 3 удаагийн

**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

мониторинг судалгаагаар нийт 17 зүйл ургамал бүртгэгдэв. Ургамлын дундаж өндөр 14-26 см байна.

Тухайн орчинд 2022 онд 1 м<sup>2</sup> талбайд 1-3 зүйл ургамал, 2023 онд 3-5, 2024 онд 3-5, 2025 онд 3-6 зүйл ургамал тохиолдож байв. Ургамлын бүрхцийн хувьд 2022 онд 10-30%, 2023 онд 15-40%, 2024 онд 21-59%, 2025 онд 37-42%-ийн тусгаг бүрхэцтэй байна.

Энэ үр дүнгээс харахад тухайн орчны ургамлан нөмрөгийн өөрчлөлт өмнөх жилийн үр дүнтэй харьцуулахад өөрчлөлт багатай, тогтвортой байгааг илтгэж байна.

**Хүснэгт-40. Ургамлын мониторингийн VP-2 цэгийн бичиглэл**

№	Зүйлийн шинжлэх ухааны нэр	Бүрхэц, %			Арви /VII сар/	Тохиолдоц			Дундаж өндөр, см /VII сар/
		VI	VIII	IX		VI	VIII	IX	
1	<i>Lespedeza dahurica (Laxm.) Schindl.</i>	25	16		cop2	+	+		24
2	<i>Leuzea uniflora (L.) Holub.</i>	10			cop1	+			32
3	<i>Carex duriuscula C.A.Mey.</i>	2	4		sp	+	+		11
4	<i>Artemisia sp</i>		8		sp		+		10
5	<i>Vincetoxicum sibiricum (L.) Decne</i>		5	7	sp		+	+	11
6	<i>Lappula myosotis Moench.</i>		4		sp		+		15
7	<i>Chenopodium aristatum L.</i>		4		sp		+		6
8	<i>Enneapogon borealis (greseb.)</i>			35	cop2			+	10
9	<i>Taraxacum officinale Wigg.</i>			4	sp			+	7
Нийт 1 м <sup>2</sup> талбайд		37	41	42	-	3	6	3	14
Дагалдах зүйлүүд									
10	<i>Stipa grandis P. Smirn.</i>				-	+	+	+	21
11	<i>Stipa Krylovii Roshev</i>				-	+	+	+	20
12	<i>Elymus chinensis (Trin.) Keng.</i>				-	+		+	20
13	<i>Artemisia scoparia Waldst. et Kit.</i>				-		+	+	41
14	<i>Artemisia macrocephala Jacquem.</i>				-	+		+	35
15	<i>Serratula centauroides L.</i>				-	+	+		23
16	<i>Chenopodium acuminatum Willd.</i>				-		+	+	5
17	<i>Urtica cannabina L.</i>				-	+	+		45
Нийт 10 м <sup>2</sup> талбайд		-	-	-	-	9	12	12	26

Ургамлын мониторингийн VP-3 цэг: Тамсаг XXI талбайн ТА-2 шингэн хаягдлын сангийн ургамлан нөмрөгт үзүүлж буй нөлөөллийг хянах зорилготой тухайн мониторингийн цэгийг байгуулсан байна. Тухайн цэг орчимд Шарилж-үетэнт (128а, Х-II-2-7) бүлгэмдэл тархсан байна.

Гол зонхилогч: *Vincetoxicum sibiricum (L.) (sp)*, *Heteropappus hispidus (Thunbg.)*, *Lappula myosotis Moench.*, *Carex duriuscula C.A.Mey.*, *Enneapogon borealis (greseb.)*, *Eragrostis minor Host*, *Chenopodium aristatum L.*, *Salsola collina Pall*, *Chloris virgata Sw*

Дагалдах зүйлүүд: *Chenopodium acuminatum* Willd, *Lespedeza dahurica* (Laxm.) Schindl., *Artemisia scoparia* Waldst. et Kit., *Artemisia commutata* Bess., *Eragrostis minor* Host, *Elymus chinensis* (Trin.) Keng., *Bassia dasyphylla* (Ficsh. et Mey.) Ktze., *Chloris virgata* Sw, *Artemisia macrocephala* Jacquem.



### **Зураг-32. Ургамлын мониторингийн цэг VP-3**

Ургамлын бүрхэц: 6 сард 25%, 8 сард 47%, 9 сард 71%-ийн бүрхэцтэй байна.

Биомасс: чийгтэй ургац – 95.6 гр/м<sup>2</sup>, хуурай ургац – 70.0 гр/м<sup>2</sup>

Өнөөгийн төлөв байдал: Шингэн хаягдлын сангийн бүтээн байгуулалт, газар ашиглалт, хүн техникийн нөлөөгөөр тухайн орчны ургамлан нөмрөг хүчтэй доройтсон байна.

Ургамлын мониторингийн VP-3 цэгийн бичиглэлээс харахад тухайн орчинд ургамлын бүрхэц 6 сард 25%, 8 сард 47%, 9 сард 71%-ийн бүрхэцтэй байна.

Ургамлын зүйлийн тохиолдцын хувьд 1 м<sup>2</sup> талбайд 6,8 сард 4 зүйл ургамал тохиолдож байна. Харин 10 м<sup>2</sup> талбайд 6-р сард 10 зүйл, 8 сард 11, 9 саруудад 14 зүйл ургамал тус тус тохиолдож байв. Тухайн мониторингийн цэгийн ойр орчимд 3 удаагийн мониторинг судалгаагаар нийт 18 зүйл ургамал бүртгэгдэв. Ургамлын дундаж өндөр 12-15 см байна.

Тухайн орчинд 2022 онд 1 м<sup>2</sup> талбайд 4 зүйл, 2023 онд 4-5 зүйл, 2024 онд 6 зүйл ургамал тохиолдож байв. Ургамлын бүрхцийн хувьд 2022 онд 45-65%, 2023

**XXI ТАЛБАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

